



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2024 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2024 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 12-НЫ ӨДӨР, БААСАН ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

НЭГДСЭН ХУРАЛДААН



ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2024 оны 04 дүгээр сарын 12-ны өдөр, Баасан гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	0
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	1-6
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	7-87

1.Хуулийн төсөл эцэслэн батлах	11-13
2.“Хянан шалгах түр хороо байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /үргэлжлэл/	13
3.Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /хэлэлцэх эсэх, үргэлжлэл/	13-14
4.“Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн нарын 7 гишүүн 2024.03.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	14-29
5.Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж буй уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2024.04.10-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх, нэн яаралтай/	29-69
6.Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөрөөс Монгол Улсын Ерөнхий сайдад хандан “Монгол Улсын сэргээгдэх эрчим хүчний үнэ тариф, баримталж буй бодлогын хэрэгжилт, хэвийн төлөвийн талаар” тавьсан асуулгын хариуг сонсох	70-85
7.Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Н.Учрал 2019.02.20-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	85-87

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы
04 дүгээр сарын 12-ны өдөр /Баасан гараг/-ийн нэгдсэн
хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 72 гишүүнээс 38 гишүүн хүрэлцэн ирж, 52.8 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 05 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Томилолттой: А.Адъяасүрэн, С.Амарсайхан, Ж.Батсуурь, С.Ганбаатар, Н.Ганибал, Ц.Мөнхцэцэг, Д.Өнөрболор, Ч.Хүрэлбаатар, Д.Цогтбаатар, О.Цогтгэрэл;

Чөлөөтэй: Ё.Баатарбилэг, Г.Ганболд, Л.Оюун-Эрдэнэ, Л.Энх-Амгалан, Б.Энхбаяр;

Эмнэлгийн чөлөөтэй: С.Батболд, Э.Батиугар, Т.Доржханд, Ц.Мөнх-Оргил, Ш.Раднаасэд;

Хоцорсон: Ш.Адъяашаа- 05 минут, Э.Бат-Амгалан- 41 минут, Б.Баярсайхан- 03 минут, Х.Болорчулуун- 1 цаг 32 минут, Д.Ганбат- 05 минут, Ц.Даваасүрэн- 08 минут, Г.Дамдинням- 07 минут, Б.Дэлгэрсайхан- 21 минут, Б.Жавхлан- 03 минут, Г.Мөнхцэцэг- 02 минут, С.Одонтуяа- 02 минут, Д.Өнөрболор- 1 цаг 05 минут, Б.Чойжилсүрэн- 02 минут, Б.Энх-Амгалан- 02 минут, Ж.Эрдэнэбат- 01 минут.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн Ш.Адъяашаа, Г.Амартүвшин, Д.Ганбат, Б.Пүрэвдорж нараас ирүүлсэн албан бичгийг танилцуулж, Улсын Их Хурлын гишүүн Ш.Адъяашаа, Г.Амартүвшин, Д.Ганбат, Б.Пүрэвдорж нар үг хэлэв.

Нэг.Хуулийн төслийг эцэслэн батлах

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын дарга Б.Болдбаатар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Г.Анар-Эрдэнэ, Ё.Энхсайхан, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Г.Агар-Эрдэнэ, мөн хэлтсийн референт А.Наранцэцэг, Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул нар байлцав.

Г.Занданшатар: Хөрөнгө оруулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 44

Татгалзсан: 5

Бүгд: 49

89.8 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбатын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дэмжсэнээр тооцож, 91,8 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар үг хэлэв.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар дараах хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Үүнд:

1.Хөрөнгө оруулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./10:28/

Уг асуудлыг 10 цаг 28 минутад хэлэлцэж дуусав.

2.“Хянан шалгах түр хороо байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /үргэлжлэл/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын дарга Б.Болдбаатар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Г.Анар-Эрдэнэ, Ё.Энхсайхан, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Г.Агар-Эрдэнэ, мөн хэлтсийн референт А.Наранцэцэг, Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул нар байлцав.

Г.Занданшатар: “Хянан шалгах түр хороо байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 35
Татгалзсан: 15
Бүгд: 50
70.0 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал, Ц.Идэрбат, Б.Жавхлан нарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дэмжсэнээр тооцож, 76.0 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар “Хянан шалгах түр хороо байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./10:29/

Уг асуудлыг 10 цаг 30 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд нарын 3 гишүүн 2024.04.05-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх, үргэлжлэл/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын дарга Б.Болдбаатар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Г.Анар-Эрдэнэ, Ё.Энхсайхан, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Г.Агар-Эрдэнэ, мөн хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул нар байлцав.

Г.Занданшатар: Байнгын хорооны саналаар Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Хууль хүчингүй болсонд тооцох тухай, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт

оруулах тухай, Нийтийн сонсголын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Олон нийтийн радио, телевизийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 43

Татгалзсан: 7

Бүгд: 50

86.0 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 10 цаг 32 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв. “Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн нарын 7 гишүүн 2024.03.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын дарга Б.Болдбаатар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Г.Анар-Эрдэнэ, А.Болортуяа, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Г.Агар-Эрдэнэ, мөн хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Төсвийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяа нар танилцуулав.

Улсын Их Хурлын дэд дарга Л.Мөнхбаатар 10 цаг 36 минутаас хуралдааныг даргалав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ, Ц.Даваасүрэн, Б.Энх-Амгалан, Ц.Туваан, Д.Ганбат, Б.Жаргалмаа нарын тавьсан асуултад хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн, Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн нар хариулж, тайлбар хийв.

Л.Мөнхбаатар: “Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 28

Татгалзсан: 21

Бүгд: 49

57.1 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Улсын Их Хурлын гишүүн Б.Бейсений “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дэмжсэнээр тооцож, 59.2 хувийн саналаар дэмжигдлээ.

“Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 11 цаг 29 минутад хэлэлцэж дуусав.

Тав.Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж буй уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2024.04.10-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Улсын Их Хурлын гишүүн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн дэд сайд М.Ганхүлэг, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын зөвлөх Ү.Амарбат, мөн газрын Хууль, эрх зүйн газрын дарга Ч.Дондогмаа, референт О.Дөлгөөнтуул, Д.Батсүрэн, Сангийн яамны Төсвийн бодлогын газрын дарга М.Санжаадорж, мөн яамны Санхүүгийн бодлогын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Л.Сонор, Санхүүгийн хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга С.Тулга, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун, мөн яамны Хуулийн хэлтсийн дарга Э.Цолмонжаргал, Жижиг, дунд үйлдвэрийн газрын дарга Я.Эрдэнэсайхан, Зээлийн батлан даалтын сангийн гүйцэтгэх захирал С.Цогтсайхан, Монголбанкны Мөнгөний бодлогын газрын захирал Б.Баярдаваа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын дарга Б.Болдбаатар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Г.Анар-Эрдэнэ, Б.Мажигсүрэн, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Г.Агар-Эрдэнэ, мөн хэлтсийн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ш.Ариунжаргал нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаар Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Мөнхцэцэг нар танилцуулав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатар, С.Чинзориг, Ш.Адьяаа, Ж.Бат-Эрдэнэ, Б.Бейсен, Б.Баярсайхан, Д.Өнөрболор, Г.Тэмүүлэн, Д.Тогтохсүрэн, Б.Бат-Эрдэнэ, Ц.Туваан, Б.Пүрэвдорж нарын тавьсан асуултад Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун, Сангийн сайд Б.Жавхлан, Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дарга Ж.Батжаргал нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар 13 цаг 31 минутаас хуралдааныг даргалав.

Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдинням, С.Бямбацогт, Д.Ганбат, Б.Бат-Эрдэнэ, Б.Пүрэвдорж нар үг хэлэв.

Г.Занданшатар: Байнгын хорооны саналаар Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж буй уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн

төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Зээлийн батлан даалтын сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хоршооны тухай хуулийн зарим хэсгийг хүчингүй болсонд тооцох тухай, Газрын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулиудын болон “Тогтоолд нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 25

Татгалзсан: 17

Бүгд: 42

59.5 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж буй уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 14 цаг 01 минутад хэлэлцэж дуусав.

Зургаа. Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөрөөс Монгол Улсын Ерөнхий сайдад хандаж “Монгол Улсын сэргээгдэх эрчим хүчний үнэ тариф, баримталж буй бодлогын хэрэгжилт, хэтийн төлөвийн талаар” тавьсан асуулгын хариуг сонсох

Асуулгын хариулттай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн, Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Тавинбэх, мөн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Б.Ерөн-Өлзий, Эрчим хүчний зохицуулах хорооны Үнэ, тарифын газрын дарга Б.Эрдэнэбулган, мөн хорооны зохицуулагч П.Товуудорж, Диспетчерийн үндэсний төвийн захирал Г.Балжинням нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Б.Болдбаатар, Хяналт шалгалт, үнэлгээний газрын Хяналт шалгалтын хэлтсийн дарга Г.Болорсүх, мөн хэлтсийн референт Б.Хангай нар байлцав.

Асуулгын хариуг Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн танилцуулав.

Улсын Их Хурлын дэд дарга Л.Мөнхбаатар 14 цаг 23 минутаас хуралдааныг даргалав.

Асуулгын хариулттай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяа, Г.Амартүвшин, С.Одонтуяа, Д.Батлут, С.Бямбацогт, Б.Баттөмөр нарын тавьсан асуултад Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн, Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Тавинбэх, Эрчим хүчний зохицуулах хорооны Үнэ, тарифын газрын дарга Б.Эрдэнэбулган, мөн хорооны зохицуулагч П.Товуудорж, Диспетчерийн үндэсний төвийн захирал Г.Балжинням нар хариулж, тайлбар хийв.

Асуулга асуусан Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр үг хэлэв.

Нэгдсэн хуралдаанаар Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөрөөс Монгол Улсын Ерөнхий сайдад хандаж “Монгол Улсын сэргээгдэх эрчим хүчний үнэ тариф, баримталж буй бодлогын хэрэгжилт, хэтийн төлөвийн талаар” тавьсан асуулгын хариуг сонслоо.

Уг асуудлыг 15 цаг 05 минутад хэлэлцэж дуусав.

Долоо.Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Н.Учрал нар 2019.02.20-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Х.Сүрэнхорол, Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын зөвлөх С.Тэнгис, “Ажил олгогчдын нэгдсэн холбоо”-ны гүйцэтгэх захирал Х.Ганбаатар нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Б.Болдбаатар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх М.Отгон, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан референт Г.Баярмаа нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Улсын Их Хурлын дэд дарга Л.Мөнхбаатар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.12-т заасны дагуу санал хураалтыг хойшлуулав.

Уг асуудлыг 15 цаг 13 минутад хэлэлцэж дуусав.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 7 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээч Ц.Мөнхцоож, ахлах мэргэжилтэн С.Золжаргал нар хариуцан ажиллав.

Хуралдаан 5 цаг 08 минут үргэлжилж, 72 гишүүнээс 52 гишүүн хүрэлцэн ирж, 72.2 хувийн ирцтэйгээр 15 цаг 13 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

**ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА**

Д.ЭНХБАТ

Тэмдэглэл хөтөлсөн:

**ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ**

П.ОЮУНГЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 04 дүгээр сарын 12-ны өдөр,
Баасан гараг
Төрийн ордон “Их эзэн Чингис хаан”
танхим
10 цаг 18 минут.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Г.Занданшатар: Улсын Их Хурлын гишүүдийн өдрийн амгаланг айлтгая.

Ирц бүрдсэн тул Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы 04 дүгээр сарын 12-ны өдрийн нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

1 дүгээрт, хуулийн төсөл эцэслэн батална.

2 дугаарт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг үргэлжлүүлж хэлэлцэнэ.

3 дугаарт, “Хянан шалгах түр хороо байгуулах” Улсын Их Хурлын тогтоолын төсөл үргэлжилж хэлэлцэнэ.

2 дугаарт Хянан шалгалтын түр хороо,

3 дугаарт, Монгол Улсын Их Хурлын хянан шалгалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд,

4 дүгээрт, “Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл.

Улсын Их Хурлын гишүүн Тэмүүлэн нарын өргөн барьсан.

5 дугаарт, Уламжлалт МАА-д тулгамдаж буй уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд,

6 дугаарт, Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

7 дугаарт, Улсын Их Хурлын гишүүн Баагаагийн Баттөмөрөөс Монгол Улсын Ерөнхий сайдад хандан “Монгол Улсын сэргээгдэх эрчим хүчний үнэ тариф, баримталж буй бодлогын хэрэгжилт, хэтийн төлөвийн талаар” тавьсан асуулгын хариуг сонсоно.

Үг хэлэхээр 4 гишүүн саналаа ирүүлсэн байна. Ингээд Улсын Их Хурлын гишүүн Ширнэнбаньдын Адьшаа. Алга байна, хаслаа.

Ганибалын Амартүвшин гишүүн.

Г.Амартүвшин: Баярлалаа. Гишүүддээ өглөөний мэнд дэвшуулье. Энэ хэлэлцэх асуудалд сүүлийн хэдэн чуулганаар 1 асуудал ерөөсөө орж ирэхгүй байна. Энэ нөгөө Банкны тухай хууль Баттөмөр гишүүн өргөн барьсан. Энэ бол манай гишүүд жоохон ач холбогдлыг нь ойлгохгүй байх шиг байх юм. Энэ манай улсад үйл ажиллагаа явуулж байгаа бүх банкнууд чинь хуулиа зөрчөөд яваад байгаа шүү дээ, 01 сарын 01-нээс. Монголбанк нь ажлаа хийхгүй. Нөгөө зохицуулдаг байгууллага нь юугаа ч хийгээд байдаг юм банкнууд нь хуулиа зөрчөөд л яваад байдаг. Үүний үр дагавар нь юу вэ гэхээр ер нь гаднаас хөрөнгө оруулалт санхүүжилт авсан банкнууд чинь ер нь дефолтод орох эрсдэлд орж байгаа шүү дээ. Үүнийг яагаад Байнгын

хороогоор яагаад хэлэлцэхгүй байгаа юм бэ? Би нэг хэлэлцэх 5-д нь орсон байхад нь хүлээгээд суугаад байсан, тэгээд л хэлэлцэхгүй хаячхаж л байна лээ. Энэ Монголбанкны ерөнхийлөгч Лхагвасүрэн хаана, юу хийгээд яваад байгаа юм. Энэ ажлаа хий л дээ.

Ер нь олон жил энэ банкнууд, арилжааны банкнуудыг Монголбанк ерөөсөө зөв зохицуулж чадахгүй байгаа шүү. Одоо арилжааны банкнуудын Монголбанкны үнэт цаасны багц нь 10 их наяд болчихсон. Өөрөөр хэлбэл ямар ч эрсдэл хүлээхгүйгээр зүгээр хүүгийн орлого аваад л сууж байгаа. Бизнесийн зээл гарахаа байсан. Ганц ашиг хийдэг юм нь ерөөсөө цалингийн зээл. Тэр нь сарын 2 хувийн хүүтэй. Өөрөөр хэлбэл иргэдийн зүгээр л цалингийн зээлийг л дахин санхүүжүүлээд л сууж байдаг. Бодит эдийн засагт хийж байгаа санхүүжилт огт байхгүй болчихсон. Ганц гарч байгаа зээл нь дандаа засгийн тусгай арга хэмжээний татаастай зээлүүд 5 их наяд болчихсон.

Хамгийн сүүлд аялал жуулчлалын салбарын зээл гэж гарч байсан. Өөрөөр хэлбэл энэ банкнууд чинь эрсдэл хүлээхгүй гэсэн мөртөө 23 оны байдлаар том банкнууд бүгдээрээ түүхэнд байгаагүй их хэмжээний ашиг хийсэн байдаг. 1 их наяд төгрөгийн ашиг хийчихсэн байгаа шүү дээ. Түүний 50 хувийг нь ноогдол ашиг тараана гээд сууж байгаа.

Гэтэл Банкны тухай хууль бид нарын баталсан хуулиар энэ том банкнуудын эздийн хувь хэмжээ нь, эзэмших хувь хэмжээ нь 20 хувиас хэтэрч болохгүй гээд бид нар 2 жилийн өмнө үүнийг чинь баталсан шүү дээ. Тэгээд энэ хуулиа яагаад мөрдөхгүй байгаа юм. Монголбанк энэ дээр хариу өг. Лхагвасүрэн Ерөнхийлөгч ирж энэ юун дээрээ Байнгын хороо болон чуулган дээрээ тайлангаа тавь. Яагаад энэ банкнуудаа ингээд л хаацайлаад яваад байдаг юм бэ? Энэ дээр Их Хурлын дарга аа, та нэг шаардаж энэ асуудлыг яаралтай Эдийн засгийн байнгын

хороогоор оруулаад энэ чуулган дээр хэлэлцмээр байна. Энэ банкнуудын хууль зөрчиж байгаа нөхцөл байдлыг.

Г.Занданшатар: Ойлголоо.

Баярлалаа. Энэ асуудлыг Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанаар тов дараалалд оруулж 1 удаа тавиад, тэгээд Байнгын хороо дээр хойшлуулсан. Миний ойлгосноор ЗГ-ын саналыг авахаар хойшлуулсан гэж ойлгосон. Тэгээд Баттөмөр гишүүн бол ЗГ-ын саналаа авчихсан гэж авчихсан тэгээд ирэх 7 хоногийн хуваарьт оруулахаар саналаа ирүүлчихсэн гэж ойлгочихсон. Тэгээд энэ асуудал бол чухал асуудал.

Монголбанкнаас бүр оны өмнө саналаа ирүүлээд Эдийн засгийн байнгын хороонд ирүүлээд, ЗГ луу түүнийх нь дагуу Баттөмөр гишүүн хууль санаачлаад явуулаад ингээд ажиллаад л байгаа. Одоо үүнийгээ харин хурал чуулганаараа Байнгын хороогоор хэлэлцээд, яаралтай шийдэх шаардлагатай.

Ганибал гишүүний зөв байна. Үүнийг ингээд холбогдох Байнгын хороод Эдийн засгийн байнгын хороо анхааръя.

Амартүвшин гишүүн, Ганибалын Амартүвшин гишүүний санал зөв байна.

Дашдондогийн Ганбат гишүүнийг хасчихсан байсан юм, ороод ирлээ. Дашдондогийн Ганбат гишүүн. Ганбат гишүүн бэлдэж байх хооронд Бөхчулууны Пүрэвдорж гишүүн үг хэлье.

Б.Пүрэвдорж: Тэгэхээр энэ гурилын асуудлаар сүүлийн үед бол сүрхий ингээд ажил хийх гээд байгаа юм шиг, угаасаа хийж чадахгүй л дээ. Дандаа нэг ийм явуулж, явуулж, явуулж бүгдийг нь тартагт нь тулчхаад юм хийдэг ЗГ-тай болчихоод байна л даа. Тэгээд бүх малыг нь бүгдийг нь хорогдуулж дуусчхаад одоо тэжээлийн асуудал яриад л нэг ард түмэндээ хайртай, сонгууль дөхөж байгаагийн шинж л дээ. Унгасан хойноо барина гэгч нь болдог нь, ийм л юм болоод байна.

Тэгэхээр нөгөө өнгөрсөн жил бас дахиад л маш их тэжээлийн асуудал гарсан. Түүнийгээ бүтэн жилжингээ юу ч хийхгүй байж байгаад бүх мал цариг нь дуусчихсан хойно л тэжээлийг татваргүй болгоно гээд л, түүгээр нь тэгээд цариг нь муудчихсан мал орж ирээд тэнд хэн хэдийг тэжээх вэ дээ. Ямар ч үр дүн байхгүй. Ийм л зүйл болоод байгаа юм.

Би тэгээд энэ гурилын асуудлаар яг өнгөрсөн оны 10 сарын 04-ний 5 дахь өдөр би үг хэлж, энэ хөдөөгүүр яваад ирсэн чинь ард ирээд энэ гурилын үнэ өсчихсөн байна, орос гурил оруулж ирээч ээ гэдэг хүсэлт тавиад байна гэдгийг хэлээд ярьж байсан байна. Тэгээд 11 сарын 02-ны өдөр бүр ингээж, ингэж ажилла гэдэг зүйлийг нь ярьж байсан байна. Заавал гаалийн татварыг чөлөөлөхгүйгээр тэр Хунсний аюулгүй байдлын зөвлөлийн шийдвэрийг хүчингүй болгоод, орос гурилыг импортлодог болгочихсон бол одоо ийм хүндрэлтэй асуудал ерөөсөө гарахгүй байсан байхгүй юу даа.

ЗГ дээр ганцхан хуралдаан хийгээд л түүгээрээ шийдчих юмыг одоо ингээд л Их хурал руу оруулж ирээд л нэг л их тийм гурилын мафийнхны юу, энэ тэр гээд л лаг лаг юм яриад л. Ийм ийм сүртэй сүртэй юм ярьж байхын оронд зүгээр тэр гурил оруулж ирж байгаа хүмүүстээ нэг жоохон санхүүгийн дэмжлэг өгөөд, тэгээд тэр гурилынхаа импортын зөвшөөрлийг бүрэн дүүрэн өгөөд явчихсан бол ямарваа нэгэн асуудалгүй байх байсан байхгүй юу даа.

Тэгээд өнөөдөр ингээд гурилын асуудлыг шалгадаг нэг түр хороо ч гэнэ үү, нэг ажлын хэсэг гарсан юм шиг байгаа юм. Түүн дээр хамгийн их ирсэн нь намайг оруулахгүй нэг өөрийнхөө намын нэг хэдэн нөхдийг оруулаад л тэгээд л нэг хаацайлаад л гарна л даа. Тэгээд одоо энэ чинь тээр 8 жилийн өмнө ЗГ 10 жилийн өмнө засаг барьж байсан Алтанхуяг дарга буруутай гэгчихсэн сууж байж магадгүй шүү дээ, тийм ээ. Үгүй ээ, ёстой нээрээ яачихсан улсууд ийм байдаг байна.

Тэгээд энэ Занданишатар дарга аа, тэр ажлын хэсэгтээ намайг оруул. Би арьсыг нь хуулаад өгье. Болохгүй байгаа нөхдийг нь. Ер нь бол үнэ дүнг нь бүгдийг нь гаргаж өгөөд та нар ерөөсөө ингээд нэг дандаа бөөрөнхийлдөг ...

Г.Занданишатар: Ойлголоо. Ажлын хэсэгт орж болно. Ажлын хэсэгт АН-ын бүлгээс Цэвэгдоржийн Туваан гишүүн орсон байгаа. Тэгээд солигдоод бас тийм. Тувааныг болохгүй байгаа гэж үзвэл танай бүлэг солиод орж байхад нээлттэй. Тэгээд би байгуулаад нэмээд өгье.

Одоо Дашидондогийн Ганбат гишүүн.

Д.Ганбат: Та бүхнийхээ амар амгаланг айлтгая. Үгүй ээ, овоо шүү дээ, манай хэд бас ингээд ихэнх нь байх шив дээ, МАН-ын бүлгийнхэн. Бас яах вэ, яах вэ, болж байна, болж байна. Их Хурлын дарга бас олонхын бүлгийн дарга энэ тэр бол манай гишүүд ч гэсэн ер нь дажгүй байгаа юм байна. Бас улс эх орныхоо төлөө санаа зовж байгаа юм байна гэж ойлгож байна.

Хэд хэдэн хуулиуд байгаа. Бид нарын өмнө батлах, яаралтай батлах. Түүний нэг нь бас энэ 60, 40 жилээр эзэмшинэ, бас сунгана гэсэн тийм газрын Үндсэн хуулийн зөрчилтэй ийм хуулиуд байгаа. Үүнийг бид нар яаралтай баталж гаргах нь зүйтэй гэж ойлгож байна.

Ер нь ийм байна. Үгүй ээ, энэ Ардын намын удирдлага, ер нь та нар бас их хэцүү юм. Үндсэндээ Монголын ард түмний эсрэг 8 жил зарлаагүй дайн хийлээ шүү дээ. Халх голын зарлаагүй дайнд бол 100, 200 Монгол хүн үрэгдсэн юм гэнэ лээ. Тэр андуурч, эндүүрч бөмбөгдсөнөөс болж. Үгүй ээ, энэ чинь Дарханы замд хэчнээн хүн нас барав. Тэр 173 жолооч нас барсан гэж байгаа юм. 200 гаран зорчигч нас барсан гэж байгаа юм. Одоо болтол тэр зам нь ороогүй.

Энэ өвөлжингөө энэ агаарын бохирдол, энэ хорт утаанд бактериологийн дайн хийж байгаа юм шиг л юм болж байна шүү дээ. Тэгээд 10 хүн нас барчихад чив чимээгүй, яг л Японы 2 хотын бөмбөгдсөний дараа ямар байсан тийм ээ, яг тийм юм шиг ингээд л дув дуугүй. Үгүй ээ, бид нар чинь цөөхүүлээ шүү дээ. Монгол хүмүүс, Монголчууд тэгээд 3 сая 500 мянга л байгаа. 10 хүн нас барж байхад чив чимээгүй. Сая 7 айлын 15 хүн агаарын угаартаад, 2 хүн нас барж байна. Онцгой байдлынхан яаж ар араасаа нас барж байна. Үгүй ээ, ийм хүнд нөхцөл байна.

Тэгээд манай малчид ард түмнийхээ 30 хувь нь, 50 хувь нь ядуу байгаа. Гэтэл гурилын үнийг ямар их барьж байна. Тэгсэн тэр компаниудад ямар их зээл өгсөн байна. Нэг хэдхэн компанид л зээл өгөөд байдаг. Тэгээд зээл аваагүй Алтан тариа энэ тэр гэсэн компаниуд нь зүгээр өрсөлдөөд, зүгээр гурилаа борлуулаад яваад болдог. Тэгээд юу гэнэ ээ, гурилын мафия би дийлэхээ больчихоод байна гэж байгаа байхгүй юу. Үгүй ээ, тэр гурилын мафидаа та нар л мөнгө өгөөд биз дээ.

Хар, одоо. Энэ Монгол Улсын нөгөө боомтуудын сэргэлт гээд байгаа. Үгүй ээ, энэ замаа хэчнээн жил холбож чадахгүй байна. Мухар замтай. Мухар төмөр замтай. Монгол Улсын хөгжлийг 10, 20 жил гацаалаа шүү дээ. Юу вэ, тэр Владивостокоор нүүрс гаргана гэлүү? Үгүй ээ, тэр үлгэрийг хэчнээн жил ярьдаг юм бэ? Бонин ч гэлүү, находка ч гэлүү. Үгүй ээ, тэр нүүрсээ гаргасан юм уу, тэгээд түүгээр. Үгүй ээ, байхгүй байгаа шүү дээ. Түүнийг харж чадахгүй, түүнийгээ мэдэхгүй, ийм хөлдүү, иргэдэд ээлгүй, хүүхдэд ширүүн, энэ эмнэлгээр чинь хүүхдүүд дүүрэн байна шүү дээ. Ийм ЗГ-тайгаа хариуцлага тооцохгүй. Хамгийн хулгайчид ээлтэй, хулгайч нарыг өгшиүүлж байдаг ийм Ардын намын удирдлага, би Ардын намын жирийн гишүүдийг хэлэхгүй байна. Тэд нар ард түмэнтэй адилхан л зовж байгаа. Тэгээд л пропаганда ...

Г.Занданшатар: Хэлэлцэх асуудалтай холбогдуулж үг хэлье.

Д.Ганбат: Ийм ажлуудыг маш сайн хийх юм. Яг л социализм, коминтерн, коммунизмын үе эргээд ирчихсэн юм шиг. Үүнийгээ хэдүүлээ больё оо, больё, больё гэж бодож байна.

Тэгэхээр гурилынхаа үнийг буулгая. Тэр хулгайч нараа тэтгэхээ больё, та нар. Үүнийгээ яаралтай хэлэлцээд шийдье. Овоо олон бүрэлдэхүүнээр ирсан юм байна. Бас ингээд үг сонс ... /минут дуусав/

Г.Занданшатар: Ширнэнбаньдын Адышаа гишүүн үг хэлнэ.

Ш.Адышаа: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ, би нэг энэ үндэсний аюулгүй байдалтай холбоотой нэг асуудал дээр зайлшгүй энэ шаардлага тавьж, энэ асуудлыг шийдүүлэх ийм шаардлага үүслээ гэж үзэж байна.

Өнөөдөр Монгол Улсад хүний аюулгүй байдал, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, улс орныхоо амгалан тайван байдлыг хамгаалах асуудал бол төрийн үүрэг ээ гэдэг. Энэ үүргээ бид өнөөдөр биелүүлэх ёстой. Өнөөдөр Монгол Улсын Их Хурал дээр яаралтай горимоор олон хуулийн төслүүд орж ирж хэлэлцэх гэж байна. Энэ зөв зүйтэй.

Тэгтэл өнөөдөр Монгол Улс чинь маань энэ цахим гэмт хэрэгт, цахим залиланд, цахим луйварт бүх ард иргэд нь нэрвэгдэж, олон хүн өмч хөрөнгөөсөө салсан, унаа машинаасаа салсан, гэр орноо барьцаанд тавьсан ийм ноцтой аюул үүсээд байна. Энэ асуудалд яагаад бид өнөөдөр арга хэмжээ авч болохгүй байна. Энэ Хууль зүйн сайд нөгөө шударга Энхбаяр хаана байна. Өнөөдөр энэ цахим гэмт хэрэгтэй тэмцдэг, цахим асуудлыг хариуцсан Учрал сайд энэ тэр хаана байна?

Өнөөдөр Монгол Улсын чинь бүх ард иргэд энэ цахим гэмт хэрэгт

нэрвэгдэж, бүх юмаа барьцаанд тавьж, энэ цахим залилангийн золиос болж байна. Үүнийг яаралтай оруулж ирж, энэ Улсын Их Хурал дээр шийдье ээ, шийдье. Энд энэ хууль хүчний байгууллагынхан, энэ арилжааны банкныхан энд хуйвалдаж эндээс энэ асуудлыг зохион байгуулж байгаа гэж би хардаж байгаа. Яагаад гэхээр өдөр бүхэн энэ цахим орчинд олон мөрийтэй тоглоомын асуудлыг сурталчилж, яаж орохыг зааж, ийм нүд олон түмний нүдэн дээр энэ гэмт хэрэг үйлдэгдэж байхад энэ Хууль зүйн сайд шударга Энхбаяр энэ чих нь балай нүд нь дүлий байна.

Энэ цахим гэмт хэрэгтэй тэмцэх, цахим асуудлыг хариуцсан Учрал сайд нэг хууль батлуулаад тэр нь унаад, тэгээд эргээд эндээ гомддог юм уу, аль эс үгүй бол айдаг юм уу, энэ асуудал ерөөсөө шийдэгдэхгүй байна. Үүнийг нэн яаралтай горимоор авч ирж оруулж энэ хуулийг шийдэх асуудал бол үндэсний аюулгүй байдлын асуудал байна шүү. Энэ бол тэр малчдын асуудалтай мөн эн зэрэгцэх асуудлыг нь яаралтай энэ оруулж ирж энэ Улсын Их Хурлаар шийдэхийг, хэлэлцүүлэхийг ард түмний төлөөллийн хувьд би албан ёсоор шаардаж байна.

Энэ хуулийн төслийг надтай хамт өргөн барьж, энэ чуулганы хугацаанд энэ асуудлыг шийдэж, энэ ард түмнээ цахим залилангаас, цахим гэмт хэргээс хэдэн хоногийн өмнө ч гэсэн аврах ийм цаг болсон байна шүү гэдгийг албан ёсоор хэлье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Гишүүд үг хэлж дууслаа.

Хэлэлцэх асуудалдаа орно.

Хуулийн төсөл эцэслэн батална.

Гишүүд, гишүүд суудалдаа сууцгаая. Санал хураалт явуулна. Хууль эцэслэн батална. Жавхлан сайд, Батжаргал гишүүн санал хураалт явуулах гэж байна. Тэмүүлэн гишүүн суудалдаа сууцгаая.

Өнөөдөр анхны санал учраас хууль эцэслэн батална.

Ингээд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44.3-т 7 хоногийн Баасан гарагийн 10 цагаас нэгдсэн хуралдаанаар хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулна. Хуралдааны ирц хуулийн төсөл эцэслэн батлах шаардлага хангахаар бол бусад өдөр, цагт хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалтыг явуулж болно гэж заасны дагуу Байнгын хороо хуулийн төслийг эцэслэн батлуулах хувилбарыг бэлтгэн, гишүүдэд тарааж, эцэслэн батлуулахад бэлэн болсон байгаа.

Одоо төслийг эцэслэн батлах санал хураалт явуулна.

Хөрөнгө оруулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулна.

Чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн дагуу нэгдсэн хуралдаанд хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулах бөгөөд Улсын Их Хурлын нийт гишүүний олонх дэмжсэн бол хууль эцэслэн баталсанд тооцно гэж заасан. Ингээд санал хураалт явуулъя.

Эхлээд бүртгэлийн санал хураалт явуулъя. Бүртгэлийн санал хураалт.

Өглөөний анхны санал хураалт учраас бүртгэлийн санал хураалт явуулж байна. Эрүүл мэндийн сайд, Анандбазар.

Одоо санал хураалт явуулна. Анандбазар гишүүн суудалдаа суугаарай.

Хөрөнгө оруулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

44 гишүүн дэмжиж, хуулийн төсөл эцэслэн батлагдлаа.

Энэ хууль бол ард иргэдийн саналыг үндэслэж, Эдийн засгийн байнгын хорооны дарга Цэрэнпунцаг болон Улсын Их Хурлын даргын дэргэдэх зөвлөлийн гишүүд олонх нь дэмжиж, санаачилсан ийм хууль. Тэгээд Монгол Улсын Үндсэн хуулийн.

Дашдондогийн Ганбат гишүүн дэмжсэн. Дэмжсэнд тооцъё.

Монгол Улсын Үндсэн хуулийн 3.1-д Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн байгууллагаараа төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаар уламжлан энэхүү эрхээ эдэлнэ гэж заасан. Өөрөөр хэлбэл Улсын Их Хурлаар дамжуулж, иргэд төрийн үйл хэрэгт шууд оролцох эрхээ хэрэгжүүлнэ гэж заасан. Энэхүү Үндсэн хуулийн заалтын дагуу Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, иргэдийн санал бодлыг хууль тогтоомжид тусгах энэ санаачилгаар бол Ди парламент гэдэг цахим парламентын төслийг хэрэгжүүлсэн. 2019 онд баталсан Улсын Их Хурлын стратеги төлөвлөгөөгөөр Ди парламент цахим парламент болох зорилтыг дэвшүүлсэн.

Энэхүү Үндсэн хуулийн заалтыг амьдралд хэрэгжүүлж 100 мянган иргэдийн санал Монголын түүхэнд анх удаа хууль болон батлагдаж байна. Ийм учраас энэ санаачилгыг гаргасан иргэн Номуун-Эрдэнэд болон энэхүү хуульд өөрчлөлт оруулахаар саналаа өгсөн 100 мянган Монгол Улсынхаа иргэдэд баяр хүргэе. Анх удаа иргэдийн саналаар үүнийг Цэрэнпунцаг гишүүн Эдийн засгийн байнгын хорооны дарга санал ч хэрэгжиж, өөрөөр хэлбэл, төрийн эрх барих байгууллага ард түмнээсээ зайтай байна, хол хөндий байна, тасарчихсан байна гэдэг энэ яриа шүүмжлэл байсан бол бүх хууль тогтоомжийг батлахдаа иргэдийн саналыг авдаг Ди парламент төсөл хэрэгжүүлсэн. Ди фитишин буюу иргэдийн өргөдөл гомдлыг хүлээж авдаг системийг нэвтрүүлсэн.

Монгол Улсын Үндсэн хуулийн 16.2-т иргэд, төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдол гаргах эрхтэй. Төрийн байгууллага, албан тушаалтан шийдвэрлэх үүрэгтэй гэж заасан байдаг бол энэ саналыг бол хэлэлцээд шүүн хэлэлцээд, шинжлэх ухааны үндэслэлтэй нотолгоо, Үндсэн хууль, бусад хууль, эрх зүйтэй нийцүүлээд үнэхээр зөв бол түүнийг баталж байгаа энэ ард түмнийхээ санал дээр тулгуурласан ийм шинэ систем анх удаа хэрэг хэрэгжиж байна.

Ди парламент цахим систем маань Үндсэн хуулийн энэ нэмэлт, өөрчлөлтийн дагуу ийнхүү биеллээ олж байгаад бид бүхэн баяртай байна. Та бүхний, Улсын Их Хурлын гишүүд та бүхний бодит бус бүтээсэн түүх бол энэ Ди парламент зөвлөлдөх ардчилал энэ системээр ард иргэдийнхээ саналаар авч хяналт шалгалтын системийг сайжруулсан. Ди парламент цахим систем 2019 онд анх ашиглалтад орж, хэлэлцүүлэгдэж байгаа бүх хуулиудад иргэдээс санал авдаг болсноос хойш хэлэлцэгдэж байгаа асуудлуудад маань иргэдийн санал шүүмжийг бодитой тусгагддаг боллоо.

Ди өргөдөл цахим системд 2023 оноос Ди өргөдлийн систем цахим өргөдлийн систем хэрэгжиж эхэлснээр улсууд иргэд маань заавал жагсаж, цуглаж, талбай дээр ч юм уу эсэргүүцэж, илэрхийлдэг биш цахимаар жагсаж, цуглаж, санал бодлоо илэрхийлдэг ийм системийг бид бодитой ажил хэрэг болголоо.

Монгол Улсын маань ардчиллын гол баталгаа бол иргэдийн оролцоо, иргэд юм. Төрийн бүх эрх мэдэл ард түмнээс эх сурвалжтай, ардчиллын үндсэн зарчим бол. Энэ бол жирийн иргэн цахимаар хуулийн төсөлд саналаа өгснөөр хууль батлагдаж байгаа бодитой жишээ боллоо. Энэ бол ардчилсан цахим парламентын хөгжлийн тод жишээ боллоо. Өнөөгийн технологийн эрин зуун дахь цахим талбарыг ашиглаж, иргэн хүн төрийн бодлогод саналаа хэлж, олноороо

дэмжиж, хууль болон батлагдах үйл явц цаашдаа парламентад үлгэр жишээ болно гэдэгт итгэж байна.

Иргэдийн маань оролцоотойгоор Монгол Улсад маань ийм цэгцтэй хөдөлгөөн, цэгцрэх хөдөлгөөн өрнөсөөр байна. Ийнхүү газрыг гадаадын иргэнд 100 жилээр эзэмшүүлэх хуулийн заалт Монгол Улсын ямар ч хуульд байхгүй болсныг үүгээр мэдэгдэж байна. Хуулийг санаачилж, идэвхтэй ажилласан Эдийн засгийн байнгын хорооны дарга Цэдэндамбын Цэрэнпунцаг нарын гишүүдэд талархал илэрхийлье.

Дараагийн асуудалд орно.

Баталсан хуулийн эцсийн найруулгыг сонсоно.

Хөрөнгө оруулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Ингээд хууль албажлаа.

10.28 цаг

Дараагийн асуудалд орно.

Хянан шалгах түр хороо байгуулах Улсын Их Хурлын тогтоолын төслийг, хэлэлцэх эсэх асуудлыг үргэлжлүүлэн хэлэлцэнэ.

Гишүүд байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууссан.

Одоо Байнгын хорооны саналаар санал хураалт явуулна.

“Хянан шалгах түр хороо байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Үг явчихсан. Өчигдөр үг, санал. 2 удаа.

70 хувийн саналаар санал дэмжигдэж, тогтоолын төсөл батлагдлаа.

Жигжидийн Батжаргал, Болдын Жавхлан, Цагаанхүүгийн Идэрбат нарын гишүүд гараа өргөж, протоколд дэмжсэнээр тэмдэглэгдэж байна. Үүнийг протоколд системд дэмжсэнээр тэмдэглэж аваарай, ороогүй байна.

Баталсан тогтоолын эцсийн найруулгыг сонсоё.

“Хянан шалгах түр хороо байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна.

Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Энэ байгалийн баялагтаа эзэн байх, энэ ашигт малтмалын лиценз, түүний ашиглалт, АМНАТ, үүний шударга зөв хэрэгжиж байгаа эсэхийг хяналт тавьж хэрэгжүүлнэ. Үндэсний баялгийн сангийн хуулийг хэрэгжүүлэх үндсэн нөхцөл болж энэ хянан шалгалтын түр хороо ажиллана. Байгалийн баялгийн хяналт шалгалтыг бодитой утгаар нь хэрэгжүүлнэ. Энэ чиглэлээр Түр хорооны гишүүд идэвхтэй ажиллахыг, Эдийн засгийн байнгын хороо шуурхай ажиллахыг үүрэг болгож байна.

Дараагийн асуудал хэлэлцэнэ.

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх асуудлыг үргэлжлүүлэн хэлэлцэнэ.

Гишүүд асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууссан.

Одоо Байнгын хорооны саналаар санал хураалт явуулна.

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Хууль хүчингүй болсонд тооцох тухай, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Нийтийн сонсголын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Олон нийтийн радио, телевизийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт.

43 гишүүн дэмжиж, 86 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Төслүүдийг хэлэлцэх нь зүйтэй гэж гишүүдийн олонх үзсэн тул төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэнд тооцон анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр ТББХ-нд шилжүүлээ.

Цэвэгдоржийн Туваан гишүүн дэмжээгүй гарсан байна.

10.32 цаг

Дараагийн асуудалд орно.

“Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэнэ.

Хууль санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн Ганзоригийн Тэмүүлэн танилцуулна. Индэрт урьж байна.

Г.Тэмүүлэн: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ, Монгол Улсын Их Хурал 2018 оны 01 дүгээр сарын 05-ны өдөр Агаарын бохирдлыг бууруулахтай холбогдуулан авах арга хэмжээний тухай тогтоолыг баталсан бөгөөд тус тогтоолын 4 дэх хэсэгт зохистой хэмжээнээс их хорт утаа ялгаруулж байгаа авто тээврийн хэрэгсэл, зориулалтын бус түлш хэрэглэн химийн

хорт бодис ялгаруулж, агаарын чанар нийгмийн эрүүл мэндэд хохирол учруулж байгаа иргэн, ААНБ-ын үйл ажиллагаанд тавих хяналтыг чангатгаж таслан зогсоох арга хэмжээг хэрэгжүүлэх талаар тусгасан байдаг.

Гэтэл сүүлийн жилүүдэд хууль тогтоогчийн дээрх бодлого, Үндсэн хуулиар тунхагласан хүний үндсэн эрх, эрх чөлөөг хөндсөн үйлдлүүд гарах боллоо. Тухайлбал, автомашинаас ялгарах хорт утааг шүүх зориулалттай нүүрсэн янданг хулгайн аргаар болон сайн дураар худалдан борлуулах, улсын хилээр гаргах үйлдэл ихээр гарах болсон нь төв, суурин газрын агаарын бохирдлыг үлэмж хэмжээгээр нэмэгдүүлэх болсныг холбогдох судалгааны байгууллагууд танилцуулж байна.

Автомашины хөдөлгүүрээс ялгарах утаанд агуулагддаг онц аюултай нүүрстөрөгчийн дутуу исэл, нүүрстөрөгч, азотын исэл, хорттой бохирдуулагч, утаа үүсгэгч бодисууд, хүхрийн исэл, тоосонцор, хар тунгалгийн нэгдлүүд болон бусад 200 гаруй химийн хорт бодисууд нүүрсэн яндангүй тохиолдолд шууд агаар мандал цацагдаж, ноцтой аюулд хүргэдэг учраас нүүрсэн янданг салгаж авах, зарах, хулгайлах зөрчил нь хүн болон хүрээлэн буй орчны эсрэг хийж буй онц аюултай үйлдэл гэж олон улсын түвшинд үздэг байна.

Мөн олон улсын зах зээл, цагаан алт, роди, палади зэрэг үнэт металлуудын эрэлт ихсэж, үнэ нэмэгдэж байгаатай холбоотойгоор автомашины нүүрсэн янданг дахин боловсруулж, үнэт металл гарган авч худалдаалах хандлага ихээр гарч байна. Өөрөөр хэлбэл улсын хилээр нэвтрүүлэхийг хориглосон барааны жагсаалтад багтдаггүй тул хулгайн замаар болон бусад байдлаар цугларсан нүүрсэн янданг энгийн горимоор гаалийн бүрдүүлэлт хийж, улсын хилээр нэвтрүүлдэг байна.

Цагдаагийн байгууллагаас ирүүлсэн мэдээллээс үзэхэд сүүлийн 4

жилийн байдлаар автомашины зөөлөн яндан алдагдсан дуудлага мэдээлэл 1000 орчим бүртгэгдсэн байна. Мөн ГЕГ-аас ирүүлсэн мэдээллээс үзэхэд жилд ойролцоогоор улсын хилээр нүүрсэн яндангийн хаягдал нэрээр 27,5 тонн автомашины нүүрсэн янданг улсын хилээр гаргасан байна.

Улмаар нүүрсэн яндангийн дамын наймааны төлөөсөнд олон 100 мянган иргэд, мөн машин техник өмч хөрөнгөөрөө хохирч, төв суурин газрын олон 100 мянган жирийн иргэд амь нас, эрүүл мэндээрээ хохирч байна.

Дээрх үндэслэлээр Монгол Улсын Их Хурлын 1998 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн улсын хилээр нэвтрүүлэхийг хориглох0 тарифын бус бусад хязгаарлалт тогтоох бүлэг барааны жагсаалт батлах тухай 5 дугаар тогтоолын хавсралтад нэмэлт оруулж, автомашины нүүрсний яндан болон нүүрсний яндангийн хаягдлыг улсын хилээр гаргахыг хориглох барааны жагсаалтад оруулах замаар эрэлтийг хязгаарлаж, гарч буй гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй үйлдлүүд болон агаар, орчны бохирдол үүсгэгч томоохон эх үүсвэр болсон автомашинаас гарч буй утааг бууруулах боломжийг бүрдүүлэх юм.

Улсын Их Хурлын энэхүү тогтоол батлагдсанаар төсвөөс нэмэлт зардал шаардагдахгүй бөгөөд автомашины нүүрс янданг хулгайлах гэмт хэрэг болон сайн дураар худалдан борлох, дамлан зарах үйлдэл болон улсын хилээр гарах үйлдэлд дасан зохицогдох бөгөөд агаар орчны бохирдол, ялангуяа Улаанбаатар хотын хэмжээнд нүүрсэн яндангүй автомашинаас ялгарч буй утаа багасах агаарын бохирдлыг бууруулахад онц нөлөөтэй болно.

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ, “Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл болон

үзэл баримтлалыг хэлэлцэн дэмжиж өгөхийг хүсье. Баярлалаа.

Төслийн талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Хүрэлбаатарын Булгантуяа танилцуулна. Индэрт урьж байна.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Тэмүүлэн нарын 7 гишүүнээс 2024 оны 03 дугаар сарын 25-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн “Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Төсвийн байнгын хороо 2024 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Төсөл санаачлагчид автомашины нүүрсэн яндан болон нүүрсэн яндангийн хаягдлыг улсын хилээр гаргахыг хориглох барааны жагсаалтад оруулах замаар эрэлтийг хязгаарлах, гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй үйлдлүүд болон агаар, орчны бохирдол үүсгэгч томоохон эх үүсвэр болсон автомашинаас ялгарч буй утааг бууруулах нөхцөл бүрдэнэ гэж үзэж, Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулжээ.

Төсөл батлагдсанаар төсвөөс нэмэлт зардал шаардагдахгүй бөгөөд автомашины нүүрсний янданг хулгайлах, сайн дураар худалдан борлуулах, дамлан зарах, улсын хилээр гаргах үйлдэл зогсох бөгөөд агаар орчны бохирдол, ялангуяа Улаанбаатар хотын хэмжээнд нүүрсний яндангүй автомашинаас ялгарч буй утаа багасах, агаарын бохь бохирдлыг бууруулахад эерэг нөлөөлнө гэж үзсэн байна.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүдээс асуулт санал гараагүй болно.

“Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх

дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, “Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцэх эсэх талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

Л.Мөнхбаатар: Булгантуяа сайдад баярлалаа.

Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух Улсын Их Хурлын гишүүн байна уу? Нэрсээ өгье. Ганбат, Жаргалмаа гишүүнээр тасаллаа.

Улсын Их Хурлын гишүүн Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ асуултаа асууя.

Б.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Та бүхнийхээ өглөөний амгаланг айлтгая. Энэ 2017 оны 11 сарын Улсын Их Хурлын чуулганд өдөр болгон энэ Улаанбаатар хотын агаарын бохирдолтой холбоотой ийм асуудлыг тавьсан, шаардсан ажлын хэсэг байгуулахыг. Нөгөө нэг нь бол Оюутолгойн ажлын хэсэг байгуулахыг шаардсан. Ингээд хоёулангаар нь ажлын хэсэг байгуулагдсан. Ажлын хэсэгт орж ажилласан.

Оюутолгойн ажлын хэсэг бол Тэрбишдагва гишүүнээр ахлуулсан ийм ажлын хэсэг. Та бүхэн мэдэж байгаа. Энэ агаарын бохирдолтой холбоотойгоор Баатарбилэгээр ахлуулсан ийм ажлын хэсэг, энд Сарангэрэл гишүүн байна. Тэрбишдагва бид нар ороод ингээд ажилласан юм. Тэгэхэд яг бодит байдал дээр ямар байсан гэхээр зэрэг нөгөө Цэвэр агаар сангийн хөрөнгийг завшаад хүмүүс нь шоронд явчихсан. Утаатай дайн зарлах ажил бүр унтарчихсан, таг. Тэр талаар хэн ч ган хийдэггүй ийм л нөхцөл байдалтай байсан.

Ингээд манай ажлын хэсэг үзээд, Улсын Их Хурлын холбогдох 2 хуульд өөрчлөлт оруулсан. Улсын Их Хурлын

тогтоол батлуулсан. Үүнтэй холбоотойгоор бүх нийслэл, дүүрэг, газруудад манай ажлын хэсэг ажилласан. Харин тухайн үеийн Хүрэлсүх Ерөнхий сайдын Засгийн газар бол эрс шийдвэртэй арга хэмжээ аваад энэ Улаанбаатар хотод түүхий нүүрс оруулахгүй. Ингээд мийтлингээр сайжруулсан түли хийх ийм ажил хийгдсэн юм. Тэр үед зөвхөн мийтлингээр сайжруулсан түли хийх төдийгүй энэ хяналтыг нь их сайн тавьсан. Ер нь олон хүчин зүйл ажлын хариуцлага зохион байгуулалтыг нь сайжруулсантай холбоотойгоор ер нь харьцангуй агаарын бохирдол бол буурсан шүү дээ. Гэтэл одоо яагаад иймэрхүү нөхцөл байдалтай байна. Зүгээр бидэнд ирж байгаа мэдээллээр бол энэ мийтлингийн чанар байдалд өөрчлөлт орсон. Үйлдвэрлэлийн технологи горимд бас тодорхой сайжруулах ийм шаардлагууд байна. Хяналтын хувьд төдийлөн сайн хяналт тавьж чадахгүй байгаа гэх зэрэг ийм байдлаас агаарын бохирдол, үүнийг дагасан олон ноцтой үр дагаврууд гараад байгаа.

Тийм учраас үүнийг бас давхраар нь үзэх ёстой. Манай ажлын хэсгийн Их Хуралд оруулж батлуулсан Улсын Их Хурлын тогтоолд бол энэ Улаанбаатар хотын агаарын бохирдолд айхтар нөлөөлж байгаа энэ хүчин зүйл бол хуучирсан ашиглалтын хугацаа дууссан ийм автомашинуудын утааны бохирдол байгаад байсан юм. Энэ талаар зүйл заалт тодорхой оруулсан. Энэ чиглэлээр яг бодитой судалгааны юм байгаа юм уу? Миний түрүүний хэлдэг энэ Улаанбаатар хотын агаарын бохирдолтой холбоотой асуудлаар энэ хариуцсан улсууд нь, байгууллага нь ямархуу арга хэмжээ авч байгаа юм бэ гэдэг ийм асуудал байгаа юм.

Үүн дээр өнөөдрийн энэ оруулж ирж байгаа тогтоолын төслийг бол дэмжиж байгаа. Энд зөвхөн 1 асуудлыг л авч үзээд байна л даа. Тэр машины яндангаас гарч байгаа хорт утааг шүүх зориулалттай энэ нүүрсэн янданг хулгайлж, зарим янз бүрийн аргаар энэ

гадаад руу гаргаж байгаатай холбоотойгоор миний түрүүний хэлээд байгаа энэ их агаарын бохирдлыг бий болгож байгаа хүчин зүйлүүдийг улам нэмэгдүүлж байгаа, хор хөнөөлийг нь өшөө их нэмэгдүүлж байгаа ийм зүйлүүд байгаад байгаа юм.

Тэгэхээр энэ талаар тодорхой хариулт өгөх хүн байвал нэг хариулт өгөөч. Би 2 тодорхой асуулт асуу ... /минут дуусав/

Л.Мөнхбаатар: Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулъя. Хуулийн төсөл санаачлагч Ганзоригийн Тэмүүлэн хариулъя. Тэмүүлэн гишүүний микрофоныг өгье. Ганзоригийн Тэмүүлэн гишүүний микрофоныг өгье.

Г.Тэмүүлэн: Та бүхэндээ гишүүддээ бас энэ өглөөний мэндийг хүргэе. Тэгэхээр бид бүхний хувьд бас энэ нийслэл болоод төв, суурин газруудад бас нэг онцгой анхаарах ёстой асуудал маань энэ агаар орчны бохирдлыг бууруулах асуудал бол зайлшгүй болчхоод байгаа. Ер нь яах вэ, зүгээр сүүлийн жилүүдэд энэ агаар орчны бохирдолтой холбогдуулаад нийт бас зөвхөн зүгээр би Улаанбаатар хотоор жишээ болгоод авч үзэж байгаа.

Агаар орчны бохирдлын нэг 20 орчим хувийг энэ ерөөсөө автомашины тээврийн хэрэгсэл болоод энэ зориулалтын бус түлш хэрэглэж байгаа ч гэдэг юм уу, энэ автомашинтай холбоотой энэ асуудлаас бас нэг 20 орчим хувь нь бий болж байна. Тэр дундаа бид бүхний хувьд бас нэг хяналтгүйн улмаас газар авсан, хууль бус нэг талдаа гэдэг юм уу, зүй бус энэ наймаа бас нэг арилжаа наймаа үндэсний хэмжээнд цэцэглээд байгаа асуудал маань ерөөсөө л энэ инженерийн ухаанаар бүтээгдсэн машин техник, түүнд байх ёстой агаар орчны бохирдлыг бууруулж байх ёстой хорт хийнүүдийг нь бас ялгаж байх ёстой энэ тоног төхөөрөмж буюу нүүрсэн янданг нь нэг талдаа хулгайлж авдаг. Нэг талдаа бас сайн дураараа дамлан наймаалдаг. Түүнийг нь ингээд улсын хилээр давуулж,

нүүрсэн яндангийн хаягдал нэрээр бас борлуулдаг ийм сүлжээ үүсчхээд байгаа.

Тэгэхээр үүний эцсийн үр дүнд хохирогч нь хүссэн хүсээгүй бас энэ нийслэлийн олон 100 мянган иргэд, мөн бусад аймгийн төвүүд болон суурин газруудад байгаа энэ иргэд болчхоод байгаа юм. Агаар орчны бохирдолтой холбоотойгоор. Өнөөдөр үндэсний хэмжээнд яг энэ тооцоог аваад үзэхээр нийт агаар орчны бохирдлын 20 орчим хувь нь гээд аваад үзэхэд яг энэ автомашины яндангаас гарч байгаа хорт хий ерөөсөө хамгийн магадгүй хүний биед хорттой ийм ноцтой ийм аюул учруулахаар ийм хорт хий байгаа. Нийтдээ нэг 300 орчим химийн хорт бодисууд энэ нүүрсэн яндангүй машинаас ялгарч байна гэдэг зүйл гарч ирж байгаа. Тэгэхээр юу болж байна гэхээр нүүрсэн янданг нь хулгайлдаг, эргээд буцаагаад тавьж байгаа нь магадгүй стандартын шаардлага хангахгүй, муу чанарын тийм нүүрсэн янданг суулгаж өгдөг ч гэдэг юм уу ийм зүйлүүд гараад байгаа юм.

Тэгэхээр бид бүхний хувьд энэ хууль бус, зүй бус бизнес наймааг нэг таслан зогсоох, Улаанбаатар нийслэл хотын агаар орчны 20 орчим хувийг бүрдүүлж байгаа энэ машины утаанаас ялгарч байгаа хортыг ерөөсөө бууруулах ийм боломжийг л бүрдүүлье гэдэг асуудал. Тэгэхээр бодитоор дээр бид нар энэ эрэлтийг нь хязгаарлаад, энэ зүй бус наймааг хязгаарласнаар магадгүй доод тал нь нэг 10-аас дээд тал нь нэг 20 орчим хувиар энэ хорт хийн ялгаралтыг бууруулах, агаар орчны бохирдлыг бууруулах боломж бололцоо бүрдэх байх гэж харж байгаа.

Нөгөө талдаа энэ тухайн тэр машин техник эзэмшиж, ашиглаж байгаа тэр тухайн хүний өмч хөрөнгийг эд хамгаалах асуудлууд байна. Тэгэхээр энэ үүднээсээ бид нар бас нэг талдаа хүний үндсэн эрх, эрх чөлөөтэй холбоотой, агаар орчны бохирдлыг бууруулахтай холбоотойгоор бол хуулийн төслийг ингээд санаачлаад ингээд явж байгаа гэдгийг танд бас хэлэх байна.

Л.Мөнхбаатар: Бат-Эрдэнэ гишүүн тодруулах юм уу, та. Тодруулж асууя. 1 минут. Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүнд.

Б.Бат-Эрдэнэ: Тийм. Тэгэхээр хариулт бол хангалттай байна. Миний эхний тавьж байгаа энэ асуудал дээр их ач холбогдол өгөх хэрэгтэй байгаа юм даа. Яг тухайн үед 16, 7 оны үед ямар байдалтай байсан гэхээр энэ Улаанбаатар хотод чинь бол Налайхын харьцангуй бохирдол багатай ийм нүүрсийг хэдэн 10 жил хэрэглэж байсан ийм оршин суугчид шүү дээ. Гэтэл Багануурын илүү бохирдол гэхдээ ийм нүүрсийг Улаанбаатар хотод оруулж ирж түлэх болсон. Үүнээс шалтгаалаад энэ агаарын бохирдол үнэхээр аймшигтай болсон л доо. Урд машин харагдахааргүй ийм хэмжээнд л болсон шүү дээ.

Тийм учраас бид нар өдөр болгон Их Хурал дээр шаардаж байж энэ ажлын хэсгийг байгуулаад, энэ талаар нэлээн ажлууд хийгдсэн юм. Тухайн үеийн авч хэрэгжүүлж байсан ажил бол иргэддээ таниулах, урьдчилан сэргийлэх ийм ажил хийгдэж байсан юм. Тэгээд энэ том хэмжээний агаар ... /минут дуусав/

Л.Мөнхбаатар: Бат-Эрдэнэ гишүүний тодруулгад хариулъя. Хуулийн төсөл санаачлагч Ганзоригийн Тэмүүлэн.

Г.Тэмүүлэн: Тэгэхээр Бат-Эрдэнэ гишүүнтэй бас үнэхээр зарчмын хувьд санал нэг байна. Бид бүхний хувьд бас яг энэ асуудлыг л ул суурь, үндэс сууриар нь судалж, бүхий л энэ бохирдуулагч этгээд, зүйлсийг бууруулах агаар орчны бохирдлыг бууруулах асуудлуудыг цогцоор нь зайлшгүй авах ёстой. Бид бүхний хувьд яах вэ, зүгээр энэ удаа яг хууль санаачлагчийнхаа хувиар л бид бүхний өдөр тутам анзаардаггүй бөгөөд чимээгүй тахал болсон энэ нэг асуудлыг л цэгцэлье л гэдэг асуудал байгаад байгаа юм. Би зүгээр энэ таширамд бас уялдуулаад энэ иргэдэд мэдээлэл өгөхөд сүүлийн үед ерөөсөө л хамгийн сайн

чанарын нүүрсэн яндантай машинууд бол манай Улаанбаатарчууд болоод нийслэлчүүд иргэдийн маань бас хамгийн их түгээмэл хэрэглэгддэг Приус маркийн бүхий л автомашиныуд байгаа. Нөгөө Приус 10, 20, 30, 40, 50 ч гэдэг юм уу. Энэ машин олон улсынхаа стандартаар хамгийн сайн нүүрс яндантай байдаг. Хамгийн бохирдуулагч энэ хорт химийн бодисуудыг шүүх ёстой байгаад байдаг. Гэтэл үүнийг нь юу гэдэг юм, эцсийн дүндээ цөөхөн одоо юу гэдэг юм хэдэн төгрөгийн төлөө хулгайлдаг, дамладаг, худалдаж авдаг, хил гарган борлуулдаг ийм сүлжээ зүй бус бизнес дэлгэрээд байна.

Тэгэхээр бид нар Улсын Их Хурал болоод хууль санаачлагч Засгийн газар төрийн үндсэн үйл ажиллагаа бол ямар нэг энэ зүй бус үйлдэлтэй, энэ үйл ажиллагаа дээр нь бол хяналт тавих, таслан зогсоох үндсэн үүрэг. Тэгэхээр бид нар нэг талдаа энэ иргэдийнхээ эрүүл эрүүл мэнд, хүрээлэн буй орчныг хамгаалах үүднээс бас энэ арга хэмжээг зайлшгүй авахаас өөр бол аргагүй байна л гэдэг зүйлийг бас танд нэмж хэлэх байна.

Л.Мөнхбаатар: Улсын Их Хурлын гишүүн Цэрэнпилийн Даваасүрэн асуултаа асууя.

Ц.Даваасүрэн: Та бүгдийн энэ өглөөний амгаланг эрье. Энэ Улаанбаатар хотын агаарын бохирдлын асуудлаар Эрчим хүчний сайдаар ажиллаж байх хугацаанд манай яамны хамт олон тэр Бат-Эрдэнэ гишүүний хэлээд байгаа мийтлин, коксожсон нүүрсээр шахмал түли хийж, утааг тодорхой хэмжээгээр бууруулсан юм. Тэр үед чинь бол гамшиг болчихсон байсан. Ер нь бараг л ордны хажуугаар л оройдоо манан татчихдаг байсан шүү дээ. Энэ ажлын үр дүнд нэг 50 хувь буурсан юм байгаа юм. 19, 20 оны өвөл.

Тэгээд сүүлийн үед болохоор ингээд нэмэгдэж байна гэдэг ийм шүүмжлэл. Яах вэ, гэхдээ энэ өмнөх шиг зүгээр манан татдаг юм бол Баянхошуунд

ч гэсэн байхгүй л байна лээ л дээ. Гэхдээ янз бүрийн утаа үнэртэх гэдэг юм уу, үнэр танартай байна гэдэг ийм яриа гараад байгаа юм. Тэгээд би үүнийг бол 2 шалтгаантай байна гэж үзэж байгаа юм.

1 дүгээрт, энэ хууль санаачилж орж ирсэн энэ гишүүдийн хэлээд байгаа автомашины тоо олишрсонтой холбоотой. Ялангуяа тухайн улс оронд энэ машинууд чинь ашиглалтаас актлагдсан шахуу ийм машинууд байгаа шүү дээ. Тэгээд эд нар чинь хэдэн мянгаараа ингээд ороод ирэхээр энэ нөлөөлж байна.

2 дугаарт, нөлөөлж байгаа юм бол Улаанбаатарт үнэгүй юм төлдөг нэг 30-аад мянган өрх байгаа. Энэ өрхүүд бол бакришик, машины ажилласан масло ямар үнэгүй юм байна тэр бүгдийг түлдэг юм. Тухайн үед нь бол Хууль зүйн яамныхан, манай яамныхан, тэгээд энэ орон нутгийн дүүрэг, мөн багийн түвшинд хүртэл бид нар бас энэ хяналтыг тавиад, тэр янз бүрийн юм түлж байгаа айлуудын тэр юуг хязгаарлачихсан байсан. Энэ бол их сайн нөлөөлсөн.

Одоо бол миний харж байгаагаар энэ 30-аад мянган өрх нөгөө үнэгүй юмаа түлж байх шиг байна. Ялангуяа түүн дотор байгаа тэр бакришикны хорт утаа хүнд хорт хавдар үүсгэдэг ийм аюултай эд ээ.

Тэгэхээр энэ хуулийн хүрээнд ч гэлээ гэсэн бид автомашин гэлтгүйгээр ер нь энэ үнэгүй юм түлж байгаа, ялангуяа энэ бакришик, химийн хортой бодис ялгаруулдаг түлш түшилж байгаа энэ асуудлыг бид нар хязгаарлаж өгөхгүй бол энэ бол биднийг мэдэгдэхгүйгээр хорлож байгаа. Үүнийг чинь бид бүгд л үнэрлэж байгаа. Энэ бол нүдэнд харагддаггүй ийм үхлийн хийнүүд шүү дээ.

Тийм учраас энэ агаарын бохирдлын асуудлыг бид ярихдаа бас энэ хортой бодис ялгаруулдаг түлш түлж байгаа, үнэгүй түлш түлж өгөх гэж ингэж яаж байгаа энэ айл өрхийн

асуудлуудыг бас яах вэ, яаж хязгаарлах вэ, ямар арга зам байна вэ гэдэг ийм арга хэмжээг авахгүй бол энэ Улаанбаатарын утаа хэдийгээр бас өмнөх шигээ манан татаж харанхуйлахгүй байгаа ч гэлээ гэсэн энэ үнэртээд байгаа тэр хорт утаан дотор чинь иргэдийн яриад байгаа тэр нэг сонин үнэр дотор чинь энэ айлуудын энэ утаа яваад байгаа, машины утаатай зэрэгцээд.

Тэгэхээр энэ асуудлыг бас энэ хэлэлцүүлгийнхээ явцад бас та бүхэн анхаараач ээ л гэж би хэлэх гээд байгаа юм. Одоо хуучин бас эд нарыг бид нар хянаж болдог байсан. Тэгэхдээ үргэлж хянахад бол хөрөнгө зардал их байх байх. Өөр арга хэмжээнүүд байж болно. Түлшний хөнгөлөлт үзүүлээд бас тодорхой энэ айл өрхүүдийн тэр түлшийг энэ дээр тусалцаа үзүүлэх ийм боломжууд байх уу. Ер нь олон талаас нь энэ хязгаарлах гэж тодорхой арга хэмжээнүүдийг авахгүй бол энэ болохгүй ээ. Энэ бол маш олон хүнийг өнөөдөр хорлож байгаа, хорт хавдрыг үгүйсгэж байгаа ийм аюултай, харагддаггүй тахал гэдгийг бас анхаараач ээ гэж хүсье.

Л.Мөнхбаатар: Даваасүрэн гишүүн хуулийн төсөлтэй холбогдуулан санал хэллээ гэж ойлголоо. Тийм ээ.

Одоо Гадаад бодлого, аюулгүй байдлын байнгын хорооны дарга Бямбасүрэнгийн Энх-Амгалан асуултаа асууя.

Б.Энх-Амгалан: Одос үхрийн туурай авна гээд байсан чинь ашигтай юм байна, үнэтэй юм байна гээд зараад яваад байсан чинь овъёос буудайгаараа тэргүүлэх алсын ухаан байсан юм байна лээ гэж нэг үг байдаг. Түүн шиг Монголчууд энэ оришхуйгаараа наймаалцаж л болохгүй юм байгаа юм. Ашиг олж болно, амьдралаа залгуулж болно. Гэхдээ энэ говьд хур тогтоодог, барьдаг олон өнгийн чулуугаа зардаг, энэ бөхөнгийн эврээ, бугын чив, баавгайн доньд, барагшин гээд л ерөөсөө авъя гэсэн болгоноо аваачиж өгдөг ийм ухаан

муутай байж хэрхэвч болохгүй юм байгаа юм. Энэ бол бид нар оршихуйгаа наймаалцаж хэрхэвч болохгүй. Яг үүнтэй агаа агаар нэг энэ орчны бохирдолтой тэмцэж байхад ядаж энэ приусын яндангийн шүүлтүүрийг нь хулгайлдаг, зардаг, хил давуулдаг нэг ийм бүлэглэл бий болчихоод байгаа юм. Энэ бол өөрөө маш хортой. Үүнийг таслан зогсоох ийм тогтоолын төсөл орж ирж байгаад их талархаж байна, дэмжиж байна.

Энэ дээр нэг 2 юм нэммээр байгаа юм.

Нэг нь бол энэ приус буюу энэ хайбрид машины шалан дээр байдаг тэр нэг зай хураагуур байгаа юм. Хуучин он хуучин энэ машиныг нь хилээр оруулчихдаг, буцаагаад гаргадаггүй, үүнийг нь боловсруулдаг үйлдвэр манайд байдаггүй. Дээхэн үед нэг хөгшин хэлж байсан юм. Үгүй ээ, манай бууцны яг энэ хэсэг дээр үс нь халцарчихсан хүн шиг ингээд ногоо ургадаггүй нэг газар байдаг юм гээд. Тэгээд байж байж байгаад энэ яадаг юм бол гээд ухаад үзсэн чинь дээр үеийн нэг муу транзистор гэж нэрлэдэг байсан радионы зай байж байсан шүү гэж. Тийм жижигхэн зай тэгж байгальд нөлөөлж байгаа юм чинь энэ олон машины зай хураагуур хөрс бохирдолд асар ихээр нөлөөлж байгаа юм.

Тэгэхээр энэ нэг зай хураагуурыг ил задгай хаядаггүй, бушилдаг, ил задгай бушилдаггүй байлгахын тулд нэг буцааж гаргадаг эсвэл үүнийг зай хураагуурын боловсруулдаг ийм үйлдвэр байгуулахгүй бол энэ Монголоор дүүрэн приусийн энэ зай хураагуур сүүлдээ энэ нутаг орныг бохирлоход асар нөлөөлнө гэж ингээж бодож байгаа.

2 дахь асуудал нь юу юм бэ гэхээр зэрэг энэ автомашины түүхийг авдаг болмоор байгаа юм. Ийм нэг 2 ийм тогтоол дээр тогтоолын төсөл дээр нэмж болох уу, үгүй юү. Тэгэхгүй болохоор зэрэг онхолдчихсон, шатчихсан, усанд автагдчихсан ийм машинуудыг чинь ингээд л мөргөлдчихсөн ийм машинуудыг

оруулаад ирдэг. Тэгээд тэр нь нөгөө Монгол хүн аваад унадаг. Эсвэл ингээд нөгөө тайрчихсан эргээд угсарчихсан юмнууд явдаг байсан шүү дээ. Тэгэхээр энэ автомашины түүхийг авдаг юмыг заавал ингээж оруулах нэг ийм 2 заалт энд оруулж болох уу, үгүй юү гэдгийг би асуугаад байгаа юм. Тэмүүлэн дарга энэ дээр нэг хариулаадхаач.

Л.Мөнхбаатар: Энд сайд хариулах уу? Илүү тодорхой хариулт өгөх ёстой байх. Зам, тээврийн хөгжлийн сайд Сандагийн Бямбацогт хариулъя.

С.Бямбацогт: Баярлалаа. Ер нь агаар орчны бохирдлыг бууруулах талаар Монгол Улсын Их Хурал, Засгийн газар, тэгээд л бүх л шатдаа орон нутгийн удирдлагууд гээд нэлээн анхаарч ажиллаж байгаа. Үр дүн бас харьцангуй бага гараад байгаа.

1 дүгээрт нь ДЦС утаа гарч байна. Гэр хорооллууд гал түлж байна. Мөн бас автомашины яндангаас тийм үү, хорт хаягдал гардаг. Хөрсний бохирдол гээд. Үүнийг бүгдийг нь шат шатдаа шийдэх гээд л цахилгаан станцын яндангууд шүүлтүүр тавих, гэр хороололд кокосжсон түши нүүрс бага зарцуулдаг түши шийдэх гээд л үр дүнд бас сайн хүрэхгүй байх. Ер нь бол гал түлэхгүй байх, энэ рүү л чиглэх ёстой юм байна лээ. Гэр хорооллыг өөрөөр хэлэх юм бол дэд бүтэцтэй болгох, гэр хороолол цахилгаан, дулаан, цэвэр бохир устай болчих юм бол халуун, хүйтэн устай, цэвэр, бохир устай болчих юм бол утаа гаргахгүй, гал түлэхгүй болно. Ингээж нэг том шийдэл байж байгаа.

Нөгөө нэг шийдэл нь бол энэ автомашины яндангаас гарч байгаа утааг багасгах. Энэ дээр л хууль санаачлагч бид нар энэ хуулийн төслийг санаачилсан. Өнөөдөр Монгол Улс 1 сая 200 гаруй мянган машинтай. Хайбрид машин нэг 400 гаруй мянга байна. Үүний яндангуудыг нөгөө хилээр гаргахыг хязгаарлаагүй учраас хулгай хийгээд зарчихдаг. 400 гаруй мянган машинаас

үндсэндээ энэ хар тугалга, дээрээс нь нүүрсхүчлийн хий, ийм агаар орчны бохирдлыг бууруулах 20 хувь нь шалтгаалж байгаа юм. Үүнийг ишийдчих юм бол үндсэндээ бас 20 орчим хувиар агаарын бохирдол ялангуяа автомашины яндангаас гардаг бохирдол маань буурчих болов уу гэсэн агуулгаар зорилгоор энэ төслийг санаачилсан.

Сая Энх-Амгалан гишүүний ярьж байгаа энэ хар тугалга маш их ордог тийм үү, зай хураагуур, батарей, аккумулятор. Үүнийг боловсруулах үйлдвэр Монгол Улсад байгуулагдсан. Дөнгөж бас үүд хаалгаа нээгээд хориодхон хонож байгаа. Урьд нь бол маш аюултай хог хаягдал эндээс гардаг байсан бол тэр хар тугалга дээрээс нь тэр нөгөө кислота гэж ярьдаг хүчил, мөн бас хуванцар энэ бүгдийг 99 хувь, 100 хувь боловсруулаад, хуванцраар нь тийм үү, хуванцар эдлэл хийх, нөгөө хүчлийг нь тийм үү, гөлтгөнө болгох, мөн хар тугалгыг нь боловсруулж, эцсийн бүтээгдэхүүн болгож экспортод гаргах ийм үйлдвэр байгуулагдсан байгаа.

Монгол Улсын бүх аккумуляторыг нарны батарейгаас гарч байгаа, автомашинаас гарч байгаа, дээрээс нь нөгөө харилцаа холбооны компаниудаас аккумулятор хэрэглэдэг энэ бүх аккумуляторыг бүгдийг нь боловсруулах Монголд байгаа гарч байгаа хаягдлыг түүнээс 2 дахин, 3 дахин илүү хүчин чадалтай 98, 99 хувь цэвэршүүлэх ийм бас үйлдвэр байгуулагдсан. Тийм болохоор цаашидаа үндсэндээ энэ хар тугалга, аккумуляторын асуудал бүрэн ишийдэгдэнэ.

Энэ хууль батлагдах юм бол бид нар энэ нүүрсэн янданг гаргахаа болих юм бол автомашинаас гардаг хорт утаа энэ хаягдлыг бас бууруулахад бас чухал ач холбогдолтой гэж бодож бас энэ хуулийн төслийг санаачилж өргөн барьсан юм гэдгийг хэлье. Баярлалаа.

Л.Мөнхбаатар: Энх-Амгалан гишүүн тодруулах юм уу? Тодруулж асууя. Бямбасүрэнгийн Энх-Амгалан гишүүн тодруулж асууя.

Б.Энх-Амгалан: Би тогтоол санаачлагчаас нэг 2 л юм тодруулаад байгаа юм л даа. Тийм үйлдвэр байгуулагдсан нь сайн. Тэр одоо ингээд хөдөөгөөр ингээд яваад үзээрэй. Энд тэнд ингээд машины сэг хаячихсан, эвдэрсэн машинаа хаячхаад дараагийнхаа машиныг авдаг ийм дадал зуршил маш их байгаа юм. Түүнийг заавал тэр үйлдвэрт авчирч тушаадаг ийм хэвшилд оруулахгүй бол болохгүй байгаа учраас ийм юм 1 дүгээрт, хийж болох уу, тогтоолд оруулж болох уу.

2 дахь нь, автомашины түүхийн асуудал би асуусан. Тэгэхгүй болохоор зэрэг автомашины түүхгүй юмыг хилээр оруулахгүй байж болох ийм зохицуулалт хийж болох уу гэдэг юм асуусан. Үүнийг ажлын хэсгийнхэн нэг тодорхой хариулаадхаач.

Л.Мөнхбаатар: Тодруулгад Сандагийн Бямбацогт сайд хариулъя.

С.Бямбацогт: Энэ тогтоолын хавсралт нэмэлт, өөрчлөлт оруулах гэж байгаа. Өөрөөр хэлэх юм бол улсын хилээр нэвтрүүлэхийг хориглох тарифын бус бусад хязгаарлалт тогтоох бүлэг барааны жагсаалт. Энэ дээр бид нар тэр автомашины нүүрсэн янданг оруулахыг, хилээр гаргахыг хориглох л ийм л заалт оруулах гэж байгаа юм. Тийм болохоор хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахад хууль тогтоомжийн төсөлд нэмэлт, өөрчлөлт оруулахад тогтоолд зөвхөн хөндөж байгаа заалттай л холбоотой, тийм үү, найруулга засвар хийж болно. Хөндөгдөөгүй заалтуудыг нэмэх, хасах бол боломж байхгүй байгаа.

Тийм болохоор таны ярьж байгаа саяын асуудлуудыг тийм үү, дахиж шинээр тогтоол санаачлах байдлаар ишийдэх боломжтой. Ер нь бол автомашины тэр хаягдал тийм үү, хаягдал төмөр үндсэндээ бол тийм үү, үүнийг бас нэг боловсруулах, үүнийг арматурын төмөр болгох, буцаагаад энэ тал дээр бас нэлээн анхаарч ажиллах

ёстой. Баруун бүс нутагт жишээ нь баруун бүс нутгийн хаягдал төмрүүдийг буюу хаягдаж байгаа тийм үү эдэлгээ норм нь дуусаад актлагдаж байгаа гэдэг юм уу, хаягдаж байгаа автомашинуудын төмрийг боловсруулж арматурын үйлдвэр болгох ийм үйлдвэр тун удахгүй бас эхлэх гэж байгаа.

Ийм байдлаар үндсэндээ бид нар энэ хаа сайгүй хаягдаад байгаа энэ автомашинууд Монгол Улс 1 сая 200 гаруй мянган машинтай. Жил болгон л ингээд л элгэгдээд л, сэлгэгдээд л ингээд хаягдаж байдаг. Эдгээрийг бас нэг энэ хаягдал төмөр, хаягдал аккумулятор эдгээрийг бас нэг боловсруулах эцсийн бүтээгдэхүүн болгох энэ хаягдал биш болгох, дахиж боловсруулах энэ чиглэлдээ бас нэлээн тодорхой бодлогууд явагдаж байна. Бас үүний бас үр дүнгүүд тун удахгүй бас гарч эхлэх байх гэж бодож байна.

Л.Мөнхбаатар: Хариулт тодорхой, тийм ээ.

Улсын Их Хурлын гишүүн Цэвэгдоржийн Туваан асуултаа асууя.

Ц.Туваан: Энэ асуудлыг дэмжиж байгаа. Тойргоор иргэдтэй уулзаад явж байхад энэ асуудлыг ишийдээч ээ гэж их хүсэлтийг хэлдэг. Энэ угаасаа бас гараад нэлээн удчихаж байгаа, нэлээн өндөр үнэтэй ч бололтой юм билээ.

Тэгэхээр энэ дээр асуулт байна. Бямбацогт сайд аа, би танаас нөгөө салбартаа ганцхан юм асуугаадахъя. Тэгээд үүнийг бол дэмжиж байгаа.

Тэгэхээр сүүлийн үед энэ агаарын бохирдлын асуудал бол нэлээн хүнд болчихлоо. Одоо ингээд 10 хүн угаартаад нас барлаа л гээд нэг юм тэр дуулиан намжаагүй байж байтал дахиад л 15 хүн угаартаад 2 хүн нас барчихлаа гээд. Тэгэхээр бид бүхэн энэ нэг тэр иргэд чинь агаараа бас яг хортой, хоргүйг нь бас шууд хараад мэдэх боломжгүй ийм зүйл дээр Засгийн газар ер нь бас нэлээн

анхаарал тавихгүй бол хүмүүсийн анхаарал сулраад, энэ урин дулаан болоод ирж байгаа үед бол иймэрхүү төрлийн зүйлүүд нэлээн яригдаж байгаад нь бол бас харамсаж байна.

Тэгээд тодруулах асуулт байна. Эндээс Бямбацогт сайд байгаа учраас энэ АТҮТ дээр энэ автомашины үзлэгүүд явагддаг. Тийм ээ. Тэгэхээр энэ үзлэгийн үеэр энэ нүүрсэн яндан энэ зөөлөн янданг үзэж шалгадаг юм уу? Үүнийг нэг та нэг хариулаад өгөөч.

2 дугаарт, энэ бусад Приусын яндан л гэж байгаа, бид хэд. Түүнээс бусад автомашинууд дээр энэ хэр байдаг юм. Түүнийг бас шалгадаг юм уу гэдэг нэг ийм зүйлийг асуух гэсэн юм.

Дараагийн асуудал нь энэ гаалийн байгууллагаар энэ яг түрүүн бас Тэмүүлэн даргын үгэнд гарч байна лээ. Гаалийн байгууллагаар энэ яндан чинь яг ямар бараа гээд гараад байсан юм бэ? Эс үгүй бол зүгээр яг энэ яндан байдлаараа биш гарчихдаг юм уу? Энэ нэг тодорхой бас Монгол Улс чинь хилээрээ гаргах бараа дээрээ хяналт тавьдаг, гааль өшөө бас бус байгууллагууд байна, тийм ээ. Тэгэхээр энэ ямар байдлаар гарч байсан гэдэг нэг асуулт.

2 дугаарт, энэ замуудтай холбоотой нэг асуудлыг Бямбацогт сайд та боломж байвал нэг хариулаад өгөөч. Энэ Дарханы замын асуудал дээр ингээд эхний ээлжид тэр замын 80, 81 дэх километр цөмрөлтийн асуудал, тэр хяналтын компаниуд нь ямар ажил хийж байгаа юм. Энэ зам ер нь яг хүлээж авсан зам уу? Хүмүүс асуугаад байх юм. Алийг нь хүлээж авсан юм бэ, алийг нь аваагүй юм бэ. Энэ авсан, аваагүй нь мэдэгдэхгүй ийм замаар ингээд яваад байна гээд. Тэгэхээр энэ дээр тэр тэмдэг тэмдэглэгээнүүд энэ тэр ганцхан тэр цөмөрсөн хэсэгтээ ч биш. Ер нь бол энэ замын компаниуд дуртай газартаа нэг ийм эрээн хувцастай, зарим нь ч энгийн хувцастай хүмүүс зогсоогоод ингээд шууд гаргачхаж байгаа, хүмүүсийг ийшээ гар

гээд л. Тэгээд л нөгөөдөх нь нэлээн урт хугацаанд эсрэг замаараа явах болчихоод, нөгөө гэнэт 2 урсгалтай зам өргөн замаар явж байгаа гэсэн машин дээр бол маш их хүнд нөхцөл байдал үүсэж байгаа. Тэгэхээр энэ энэ тэр дээр та нэг хариулт өгөөч.

Дараагийнх нь та боломж байвал өөрөө хариулаад, боломжгүй гэвэл яамныхаа ТНБД энэ тэрийг нэг хэлүүлээдхээрэй. Тэр нь Төв аймгийн Батсүмбэр сумын иргэд над руу ярьж байгаа юм. Нөгөө Батсүмбэр сумаас юу руу явж байгаа, тэр ахмадын асрамжийн төв рүү явж байгаа замыг тэр ухаа дээгүүр гэж ярьдаг юм. Нэлээн жоохон тийм бусад нөгөө суурьшлынхаа газар луу дөхсөн байдлаар ингээд зам нь явах байх гээд. Ингэж байсан чинь арай жоохон товчоо хардаг юм уу, нэлээн тийм доогуур өөр маршрутаар явах тендер зарлагдсан гэсэн нэг ийм зүйл яригдаж байна. Үүнийг та мэдээлэл байвал хариулаад, мэдээлэл байхгүй бол над руу бас яамныхаа албан тушаалтнуудыг яриулж, хариулт өгөх боломж байна уу?

Л.Мөнхбаатар: Туваан гишүүний асуултад хариулъя. ЗТХ-ийн сайд Бямбацогт хариулъя.

С.Бямбацогт: Нүүрсэн яндангүй машинууд үзлэгт тэнцэхгүй ээ. Гэтэл нөгөө нүүрсэн янданг нь хулгайлж аваад зардаг, зарсан янданг нь худалдаж аваад хилээр гаргадаг, үүнийг нь хориглоогүй учраас ийм төвөгтэй байдал үүсчхээд байгаа юм. Яах аргагүй нүүрсэн яндангаа хулгайд алдчихсан, эс үгүй бол өөрсдөө мөнгөний хэрэгцээ гаргаад зарчихсан. Тэгээд үзлэгт орох гээд гэхээр яндан байхгүй. Тэгэнгүүтээ л үзлэгт ороод тэнцүүлээд өг гээд л бөөн хүндрэл, бөөн төвөг чирэгдэл учруулдаг.

Тийм учраас тэр хилээр нүүрсэн янданг гаргахаа больчих юм бол нүүрсэн яндангийн эрэлт алга болчихно. Эрэлт алга болчих юм бол автомашинууд нь нүүрсэн яндантайгаа үзлэгтээ ороод тэнцдэг болчихно. Одоо нүүрсэн яндангүй

нь тэр үзлэгт ороод л тэнцэх гээд л зүтгэхчдэг. Үүнээсээ болоод бөөн төвөг чирэгдэл болдог. Энэ байдлыг л энэ тогтоолын төслөөр хязгаарласнаар үндсэндээ хална. Өөрөөр хэлэх юм бол нүүрсэн яндангийн эрэлт байхгүй болчихоор автомашинуудын нүүрсэн янданг хулгайлж авах, нүүрсэн яндангаа зарж борлуулах шаардлагагүй болчихно гэсэн үг. Ийм байдлаар үндсэндээ агаар орчны бохирдлыг бууруулахад автомашинтай холбоотойгоор.

Приус автомашин Монгол Улсын хэмжээнд нэг 200 гаруй мянган приус автомашин байгаа. Хайбрид машин 400 гаруй мянган хайбрид машин байгаа. Энэ тогтоолын төсөл эдгээрт үйлчилнэ гэсэн үг.

2 дугаарт нь, тэр Дарханы замтай холбоотой асуудал. Саяын тэр цөмрөлт бол нөгөө шар усны үерт идэгдээд, шар усны үерээс болж цөмрөлт үүссэн юм байна лээ. Шар усны үерт идэгдээд тийм олон хоног болж байхад нь тэр зам барьж байгаа компани, хяналтын компаниуд хариуцлагатай хандаагүй, тэр замынхан эргүүл хийж байх ёстой. Шар усны үертэй холбоотойгоор хаана ямар асуудал эрсдэл үүсэхээр байна гэдгийг. Тэгэхгүй байж байгаад энэ чинь гэнэт доогуураа маш хүчтэй шар усны үер олон хоног урсаж байгаад, идээд, цөмрөлт үүссэн юм байна лээ. Үүн дээр гүйцэтгэгч компани хяналтын компаниуд дээр хариуцлага тооцоод эд нар өөрсдийн хөрөнгөөр дахиж маш хурдан хугацаанд засаж байгаа.

Ер нь Дарханы зам улсын комисс хүлээж аваагүй байгаа. Намайг ажил авахад нийт Дарханы замын энэ 200 гаруй километр замын 50 хувь нь л хийгдсэн байсан. Шороон замаар явдаг Монголчуудыг бас үнэхээр бухимдуулдаг ийм зам байсан. Одоо ингээд үлдсэн нэг жил гаруй хугацаанд үндсэндээ үлдсэн 50 хувь нь, өөрөөр хэлэх юм бол 5, 6 жилийн хугацаанд 50 хувь нь хийгдсэн байсан бол бид нар 1 жил гаруй хугацаанд үлдсэн 50 хувь нь хийгээд дуусгаад, энэ жил хүлээж

авах гээд улсын комисс ажиллавал хүлээж авах гээд ажиллаж байгаа. Улсын комисс хүлээж авснаас хойш 3 жилийн хугацаанд баталгаат засварын хугацаа үйлчилнэ. Тийм болохоор одоо энэ цөмрөлт үүссэнтэй холбоотой гэдэг юм уу, бусад байдлаар зам гарч байгаа тэр засвар үйлчилгээ бол бүгд гүйцэтгэгч компани өөрийнхөө хөрөнгөөр засах, янзлах ийм үүрэгтэй, ингэж явж байгаа.

Тийм болохоор Улсын комисс хүлээж авснаас хойш 3 жилийн хугацаанд асуудал үүсэх юм бол гүйцэтгэгч компаниуд хариуцна. Одоо бол үндсэндээ улсын комисс хүлээж аваагүй байгаа. Болж өгвөл бид нар бол энэ 6 сард Улсын комисс ажиллуулаад хүлээж авахыг бодож ингэж ажиллаж байгаа.

Тэр Батсүмбэрийн замын тухайд аль болох төв суурин газрыг тийм үү ойртуулж, дайруулж, болж өгвөл ингэж зам барих бид нар бодлого барина, бодлого барина. Гэхдээ яг тэгээд наад тохиолдол ... /минут дуусав/

Л.Мөнхбаатар: Хэн хууль санаачлагч нэмж хариулах уу? Бас 2, 3 асуултууд орхигдчих шиг боллоо, тийм ээ. Улсын хил дээр гарахдаа приус машины тэр янданг ямар нэр, барааны тэмдгээр гаргадаг юм бэ гэж асуугаад байна, тийм үү? Түүнийг нь бас тодруулаад хариулчихъя. Хууль санаачлагч Ганзоригийн Тэмүүлэн хариулъя.

Г.Тэмүүлэн: Туваан гишүүний асуултад бас хариулъя. Тэгэхээр яг үндсэндээ яг өнөөдөр улсын хилээр гарч байгаа бараа материал дээр энэ дээр ямар нэг хяналт, тодорхой зохицуулалт бид нар хийх байхгүй болчихоод байна. Өнөөдөр үндсэндээ гарч байгаа юу гэдэг юм улсын хилээр нэвтрүүлэхийг хориглосон бараа, материалын жагсаалтад 1 дүгээрт байхгүй. Энэ гаргаж байгаа хаягдал нэртэй зүйл маань болохоор нүүрсэн яндан буюу катализаторын хаягдал гэдэг нэрээр гаргаад байгаа юм. Тэгээд зөвхөн нэг жилийн дотор 27,5 тонн яг ийм

автомашинны нүүрсэн янданг хаягдал нэрээр гаргаад байгаа юм.

Тэгэхээр ерөөсөө хулгайгаа хаягдал нэрээр хаацайлж гаргаад байна. Тэгэхээр Монголын төр энэ дээр иргэдийнхээ эрх ашгийг хамгаалах үүднээс энэ хууль бус бизнесийг таслан зогсоож, төр нь бас нэг мэддэг, хянадаг байх арга хэмжээг авах бол зайлшгүй шаардлагатай. Ер нь нэлээн бас хугацаа өнгөрчихсөн юм байна. 3, 4 жил лав болчихсон юм байна. Миний мэдэхийн. Энэ дээр бид нар бас анзаардаггүй юм байна. Тэгээд ерөнхийдөө тэр нүүрсэн яндангийн асуудлыг юу болж байна вэ гэхээр яг таны асуудагчлан машины оношилгоо, шинжилгээгээр орохоор яндангүй машин бол тэнцэхгүй, орохгүй. Гэтэл оронд нь сөргүүлээд нөгөө нэг Приус сайн чанарын автомашиных 1 саяас 5 сая төгрөгийн хооронд зарагдаж байгаа. Түүнийг нь худалдаж аваад зараад, буцаагаад нөгөө хүн чинь машиндаа оношилгоонд оръё гэхээр муу чанарын гэх юм уу. Одоо энэ Хятадын тийм нүүрсэн янданг сөргүүлээд түүнд нь нэг 200, 300 мянган төгрөгөөр тавьж өгөөд зөрөөг нь буцаагаад өгчихдөг ийм зүйл байдаг юм байна.

Тэгэхээр нөгөө нэг муу яндан бол мэдээж агаар орчны бохирдлыг шүүхгүй, эргээд хорт химийн бодисоо цацдаг. Хамгийн гол нь энэ асуудал маань юу гэдэг юм, хүний биед хортой хөнөөлтэй утаа бол автомашины утаа л гэдэг зүйл гараад байгаа юм. 50-60см-ийн буюу хүний амьсгалах түвшинд байнгын нөгөө хорт утаа нь дэгдэж байдаг. Хүүхдэд тэр дундаа хамгийн хортой.

Өнөөдөр Улаанбаатар хотын гудамжаар алхахад үндсэндээ нүдэнд харагдахгүй ч гэсэн үнэртдэг болчихоод байна шүү дээ. Хүхрийн хүчил, хорт бодисууд тийм ээ, энэ асуудлыг л бид нар таслан зогсоох үүднээс зайлшгүй энэ ... /минут дуусав/

Л.Мөнхбаатар: Хариулт хангалттай, тийм ээ.

Одоо Улсын Их Хурлын гишүүн Дашдондогийн Ганбат гишүүн асуултаа асууя.

Д.Ганбат: Монгол Улсын Үндсэн хуульд иргэд эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхтэй гээд заачихсан байгаа юм. Тэгээд энэ хуулийн заалт бол Үндсэн хуулийн заалт бол зүгээр нэг цаасан дээр байдаг л ийм бичиг болж хувирсны нэг жишээ нь энэ л дээ. Хуулийг санаачилж байгаа гишүүдэд ингээд сэтгэл гаргаж байгаа нь сайн байна. Энэ бага ч гэсэн энэ асуудлыг шийдэхийн төлөө хичээж байгаа нь сайн байна. Ерөнхий том зургаар нь ингээд аваад үзэх юм бол энэ Монгол Улсын Засгийн газар манай энэ засаг бариад ажиллаж байгаа энэ олонх ямар байна вэ гэдгийг л харуулж байгаа ийм л зүйл л дээ.

Тэгээд иргэд маань амьдрах биш, амьд явахын төлөө л тэмцэл үргэлжилж байна шүү дээ. Энэ нүүрсний яндан байхгүй болсноос болоод хохирч байгаа, нүүрсний янданг нь аваад зарж байна. Энэ бол хүний толгойд багтамгүй зүйл л дээ. Тэгэхээр манай иргэдийн амьдрал ахуй, орчин нь ямар болчихсон, тэд нар ямар байгаа байдалтай байгааг үүдэн энэ ядуурлаас, энэ нөхцөл байдлаас болоод л ийм үйлдэлд шилжиж орж байгаа байх. Ингээд эндээс маш олон хүмүүс хохирч байна. Иргэд, бие давхар эмэгтэйчүүд ураг амьгүй болж байна, энэ хүүхдүүдийн цусанд хүнд металл илрээд эхэлж байна гэх мэтчилний ийм юмнууд ингээд гарч байна. Тэгээд үүний юуг тооцож үзсэн үү?

Тэгэхээр үүний юуг бол нэхэмжлэх хэрэгтэй. Буруутай этгээдүүдээс юм уу, тэр Үндсэн хуулийн зүйл, заалтыг энэ байлгаж чадаагүй энэ Засгийн газраас нэхэмжлэх хэрэгтэй л дээ. Энэ хор хохирлоо иргэд. Энэ чинь манай хууль хуулиар нэхэмжилж барьдаг болдог тийм юм байгаа юу. Энэ хууль дээр үүнийг тусгаж болох уу? Тогтоол дээр.

Энэ Улаанбаатар хот төдийгүй аймгийн төвүүд ч гэсэн бас ийм байдалтай байгаа.

Дээр нь нэмээд хэлэхэд бол анх бол тэр нүүрсний түлшийг хийгээд арай дээрдэж байсан. Түүний хүчинд бас нэлээн олон суудал авсан байх. Энэ МАН. Одоо бол байдал шал өөрөөр эргэсэн. Утаа мэдэгдэхгүй, яах вэ дээ, сайхан байн, энэ тэр гээд байгаа. Үгүй л дээ, тэр үнэр бол үнэхээр тийм гэж хэлэхийн аргагүй тийм үнэр үнэртэж байгаа. Энэ 8 жилийн засаглалын л үнэр байх л даа. Тэгээд зарим нэгэнд нь аятайхан үнэртдэг юм уу, ард түмэнд бол үгүй л юм шиг байна лээ. Надад ч гэсэн үгүй байна. Би Монголын ард түмний 50 хувь нь, 60 хувь нь үхлийн хөндийд л байж байна шүү дээ. Үүнийг нь бага ч гэсэн ингээд багасгах ийм юм бас оруулж ирж байгаа нь сайн байна. Гэхдээ ард иргэдийнхээ амьдралыг дээшлүүлэхгүйгээр ингэж явахгүй ээ. Гэхдээ бид бүхэн бол Приус чинь бол ард түмний унаа байхгүй юу. Бид нар хориглох биш, АН бол ардчилагчид бол дандаа хориглох биш, нээлттэй байх, аль болохоороо ард түмнээ дэмжих ийм бодлого хэрэгжүүлдэг. Тэгэхэд яаж байна. Бүгдийг нь хорих, хаах, боох. Тэгээд бензин бага иддэг ийм Приус унааг бол татварыг нь бид нар багасгасан байхгүй юу. Зориуд бодлогоор. Ажлыг бол ингэж л хийх хэрэгтэй л дээ. Харамсалтай нь бид нар хэзээ ч түүхэндээ олонх болж засаг барьж үзсэн ... /минут дуусав/

Л.Мөнхбаатар: Ганбат гишүүний асуултад хуулийн төсөл санаачлагч Тэмүүлэн хариулна. Үүний дараа Жаргалмаа гишүүн асуулт асуусны дараа санал хураалт явагдана. Гишүүд танхимдаа орж ирээрэй.

Тэмүүлэн хууль санаачлагч.

Г.Тэмүүлэн: Ганбат гишүүнтэй бас таны саяын асуултаудад бас хариулт өгье. Ер нь яалт ч үгүй бид нар нийгмийн эрүүл мэндэд хор хохирол учруулж байгаа энэ аливаа бас нэг зүй бус үйлдэл болоод энэ үйл ажиллагааг бол төр өөрөө хяналт

тавих, чангатгах, таслан цогцлоох зайлиггүй шаардлагатай. Тэгээд энэ үндсэн дээрээ бид нар байж болохгүй одоо юу гэдэг юм, нэг талдаа энэ зүй бус бизнесийг л бид нар таслан цогцлоох үүднээс улсын хилээр хаягдал нэрээр хүмүүсийн юу гэдэг юм, машиных нь тэр нүүрсэн янданг нь хулгайлж, дамлаж, хилээр гаргадгийг нь л хориглох л, энэ улсын хилээр нэвтрүүлэхийг хориглох бараа, бүтээгдэхүүний жагсаалтад нүүрсэн яндангийн хаягдал гэдэг зүйлийг гаргахыг л хориглоё гэдэг зүйлийг бол оруулж ирж байгаа.

Яг таны сая бас хэлсэн ерөөсөө хор хөнөөлт талаасаа бол хүссэн, хүсээгүй энэ ДЭМБ-аас ч тэр, Нэгдсэн Үндэстний байгууллагаас ч тэр тэр ерөөсөө хүний эрүүл мэндэд хамгийн хортой гэж тогтоосон 10 бодисын дотор саяын тэр нүүрстөрөгчийн исэл дээрээсээ 2-т орж байгаа юм. Үүний өмнө юу байна вэ гэхээр ерөөсөө цацрагт идэвхт бодис байгаад байгаа юм.

Тэгэхээр үүний дараа ордог буюу энэ нүүрс төрөгчийн исэл ерөөсөө хүнд үзүүлэх хор хөнөөлөөрөө хамгийн хортой зүйл байгаад байна. Гэтэл өнөөдөр үндсэндээ нийслэл хотод явж байгаа энэ сайн чанарын нүүрсэн яндантай машинуудын бүгдийнх нь яндангуудыг нь бол бараг хулгайлах хэмжээнд ийм орчихсон байна. Бид нар бас үүнийг анзааргагүй орхиж тодорхой хугацаа алдсан байна.

Тэгэхээр одоо зайлиггүй үүнийг хийхгүй бол хамгийн их том хохирогч болж байгаа нь хүүхдүүд болоод байна гэдэг асуудал гарч ирж байна. Яагаад вэ гэхээр хүний амьсгалах түвшин буюу 50-60см-ийн түвшинд нөгөө нэг нүүрсэн яндангүй машин хамаг 200 гаран хорт хийг ялгаруулаад байдаг. Ингээд эргээд хор хөнөөлд нь хүүхдүүдээр хамгийн их хүнд тусаж байгаа учраас бид нар аль болох л шуурхай энэ асуудлыг таслан зогсоож энэ эрэлт хэрэгцээг байхгүй болгох зайлиггүй шаардлага байгаад байна.

Нэг үе бол яах вэ, бид нар утаа гэдгийг гэр хорооллын утаа болоод яндангийн утаагаар тооцоод байдаг байсан. Нүүрсээр тооцоод байдаг байсан. Ингээд утааны улирал дууслаа, урин цаг ирлээ эд нар гээд ярьдаг байсан чинь энэ бол андуу ташаа ойлголт болоод байна. Өнөөдөр үндсэндээ нийслэл бол хотод бараг дулаан боллоо гэхэд өшөө илүү бараг өмхий үнэртдэг, хүхрийн хүчил үнэртдэг. Хорт бодис бараг харагдахгүй мөртөө үнэртэх хэмжээнд ийм болчхоод байгаа зүйлийг л бид нар бас нэг талдаа таслан зогсоох зайлиггүй шаардлагатай.

Энэ утаа, агаар, орчны бохирдолтой холбоотойгоор бол ер нь зайлиггүй цогцоор нь маш олон арга хэмжээг авах ёстой. Үүний нэг л арга хэмжээ нь яалт ч үгүй л энэ болчхоод байгаа. Тэгээд бид нар үүнийг зайлиггүй бас энэ хамгийн том бохирдуулагч нь болсон зүйлийг авах шаардлагатай байна. Судалгаагаар нийтдээ нэг Улаанбаатар орчимд явж байгаа магадгүй энэ 1000 орчим автобустай гээд аваад үзэхэд зүгээр, жилдээ нэг 64 тонн хөө, тортог агаарт цацаж байна гэж байгаа юм. Гэтэл цаана нь энэ 500, 600 мянган нүүрсний яндангүй машинууд түүнээс бүр хэд дахин их давсан хэмжээний хорт утаа болоод хөө, тортог, бохирдлыг цацаж байна гэдэг зүйл байгаад байгаа.

Тэгэхээр энэ үүднээсээ л бид нар хүний эрүүл мэнд, нийгмийн аюулгүй байдал номер нэгд байх ёстой л гэдэг зарчмын үндсэн дээр оруулж ирж байгаа.

Л.Мөнхбаатар: Дашдондогийн Ганбат гишүүн тодруулж асууя. Ганбат гишүүний микрофон өгөөрэй.

Д.Ганбат: Тэгээд машин тэрэг, яндан ярьж байгаа юм чинь бас бензин, шатахууны асуудлыг бас энэ дээр дурдчих нь зүйтэй гэж бодож байна. Бас чанартай шатахуун хэрэглэх хэрэгтэй л дээ. Хямд чанартай. Тэр нефтийн үйлдвэр уул нь аль хэзээний л орчихсон байх ёстой, одоо сураг ч байхгүй л байна.

Нөгөө талаар малчдын яг тариаланчдын хэрэгцээтэй шаардлагатай үед ингээд бензинийг нь тасалчихдаг. Өнгөрсөн намар бол ийм байдал байсан. Удахгүй магадлал маш өндөр байна. Энэ дээр анхаарч ажиллаж байна уу, ямар байна. Чанартай бензин шатахуун оруулж ирж чаддаггүй юм гэхэд арай бензинээр тасалчихмааргүй байна шүү. Үүнийг би зориуд анхааруулаад хэлчихье. Хэлсээр байтал ажлаа хийж чаддаггүй, ийм урьдчилж анхааруулсаар байтал тэр юман дээрээ анхаардаггүй энэ Засгийн газрын нөхөд байдаг шүү. Энэ дээрээ анхаараарай гэдгийг би хэлье.

Л.Мөнхбаатар: Ганбат гишүүн санал хэллээ.

Гишүүд танхимдаа орж ирье. Одоо санал хураалт явагдана.

Одоо Бадарчийн Жаргалмаа гишүүн асуултаа асууя. Дараа нь санал хураалттай шүү. Гишүүд орж суугаарай.

Б.Жаргалмаа: Та бүхнийхээ өдрийн амгаланг айлтгая. Би нэг тодорхой нэг 2 зүйлийг л асууя. Монгол Улсын төрөөс ер нь 2010 оноос хойш агаар орчны бохирдлыг бууруулахын тулд шат шатандаа маш олон хууль тогтоомж, үндэсний хөтөлбөрийг хүртэл баталж гаргасан болов чиг ер нь хэрэгжилт нь тун хангалтгүй байгаа нь өнөөдрийн үүсээд байгаа нөхцөл байдлаас бас харагдах байх гэж бодож байна. Бид үнэхээр 2019 онд түүхий нүүрсийг нийслэл рүү оруулж ирэхгүй байх энэ шийдвэр гарснаас хойш харьцангуйгаар бас сайн мэдээтэй байсан. Агаар орчны бохирдол буурсан, хүхэрлэг хийн тийм ээ, нөхцөл байдал харьцангуй сайжирсан гэж байгаа болов чиг эргээд агаар орчны бохирдлын хэмжээ бас аюулын түвшинд оччихсон, хүний амь нас эрсдэх энэ нөхцөл байдал бас үүссэн хэвээрээ байгаад байгаа.

Тэгэхээр ер нь бол агаар орчны бохирдолд нөлөөлж байгаа хүчин зүйлийн нэг 10 хувийг нь эзэлж байгаа автомашинаас гарах хорт утааны

талаар бид нар ярьж байна. Тийм ээ, үнэхээр хил гаалиар гарахыг хориглосон барааны жагсаалтад багтдаггүй тул нөгөө хулгайн замаар болон бусад замаар иргэдийн автомашинаа, приусээс нь хулгайлаад хил гаалиар гаргачихдаг. Сая Тэмүүлэн гишүүний хэлж байгаагаар нэг бараг 3-5 саяар үнэлэгдчихдэг энэ хэмжээний нүүрсэн яндангийн тухай бид нар яриад байна л даа.

Нүүрсэн янданг яг хилээр гаргааа болиод тогтоол гаргаад бид нар үйлдвэрт ашигладаг болох юм байна л даа. Хэрвээ үнэхээр нүүрсэн яндан нь ашиглагдахаа больчихсон иргэн энэ үйлдвэрт нүүрсэн яндангаа тушаая гэвэл ямар үнээр авах юм. Зүгээр би сонирхоод асууж байгаа юм. Тийм ээ, үнэхээр улсын эдийн засагт гэдэг юм уу нөхцөл байдлаас шалтгаалан бид нар агаар орчны бохирдолдоо зарцуулсан төсвийг харах юм нийтдээ 456,1 тэрбум төгрөг зарцуулсан байна л даа. Тэгэхээр эдийн засгийн үр дүн иргэдэд үзүүлж байгаа хор уришитай бас тодорхой хэмжээнд дүйх ёстой болов чиг энэ дүн сайн мэдээллийг үзүүлэхгүй байгаа нь жоохон харамсалтай байгаад байгаа.

Тэгэхээр яг иргэд өөрсдөө нүүрсний яндангаа тэр үйлдвэрт чинь өгье гэвэл үйлдвэр нь ямар үнээр авах юм. Яагаад би ингэж асуугаад байна вэ гэвэл үнэхээр тийм ээ, тэр үйлдвэр тодорхой хэмжээнд гаргааа больчихсон юмыг устгахын тулд авч байгаа бол тодорхой хэмжээнд иргэддээ үнэ хөлсийг нь өгөөд авдаг байх ёстой гэж би бодож байна. Өнөөдрийн байдлаар зүгээр энгийн хэрэглээний батарей 2,5 тонныг устгаж чадахгүй хадгалж байна гэдгийг хог хаягдлын холбооны хүн хэлсэн байна. Чинзориг гэдэг хүн. Тэгэхээр яг энэ тооцоолол иргэд маань бас тодорхой хэмжээний эдийн засгийн болон эрүүл мэндийн сайн нөлөөллийг авчрах ёстой гэдэг энэ зүйлийг би асуух гээд байна л даа. Тэмүүлэн гишүүнээс.

Нөгөө талаар Чойжилсүрэн сайд байгаа учраас би асууя. Манай СХД-ийн 20 дугаар хороонд байрладаг

сайжруулсан түлшний үйлдвэрийг зүүн бүсийн үйлдвэр лүү буюу Налайх руу нүүлгэнэ гэсэн ийм мэдээлэлтэй байсан. Энэ жил бас иргэд маань үнэхээр утаа тоос, тортогдоо дарагдсан хэвээрээ л өнгөрлөө. Зүгээр би яг Хүний эрхийн Үндэсний комиссоос гаргасан Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 23 дахь илтгэлээс тоон жишээ авч хэлээд байгаа юм. НЭМҮТ-ийн энэ тандалтын мэдээллээр 2017-оос 23 онд нийтдээ 103 хүн энэ нүүрсний улмаас тийм ээ, сайжруулсан түлшний улмаас амь насаа алдсан гэдэг ийм тоо байна л даа. Тэгэхээр би энэ СХД-т байгаа энэ сайжруулсан түлшний үйлдвэрийг нүүлгээд өгөөч ээ, иргэд тэнд хордоод байна гэдэг энэ зүйлийг яриад байгаа юм. Иргэд маш ихээр өргөдөл өгдөг. Миний нэр дээр ч өргөдөл өгдөг, ХЭҮК-т ч гэсэн өргөдөл өгдөг, тийм ээ. Тэгэхээр энэ үйлдвэрийг нүүлгэх боломж нь ер нь хэр байна вэ. Сайжруулсан түлшнийхээ найрлага орцонд шинжилгээ хийсэн үү. Бид нар нүүрсний түр хороон дээр ажиллаж байхад сайжруулсан түлшний үйлдвэр дээр тодорхой хэмжээний зөрчил гарсан. Тэр зөрчлүүд ер нь арилсан уу, үгүй юү гэдэг дээр сайд аа, асууя. Би яагаад тэгж асуугаад байна вэ гэвэл зүгээр л 162 сая төгрөгийн гурил буюу тийм ээ, нөгөөдөх барьцалдуулагч устгах хэмжээнд оччихсон байсан ийм тоон мэдээ гарсан шүү дээ. Тийм ээ, энэ дээр ер нь арга хэмжээ авч чадсан уу үгүй юү гэдэг дээр та нэг тайлбар хэлээч. Энэ 2 асуултдаа хариулт аваадахъя.

Л.Мөнхбаатар: Жаргалмаа гишүүний асуултад Чойжилсүрэн сайд хариулна. Дээр нь хууль санаачлагч бас хариулах уу, дараа нь нэмэх үү, тийм ээ. Тэгье. Чойжилсүрэн сайд хариулъя.

Гишүүд байраа эзлээрэй.

Б.Чойжилсүрэн: Жаргалмаа гишүүний асуултад хариулъя. Гишүүдийнхээ өглөөний амрыг эрье. Жаргалмаа гишүүн ээ, өнгөрсөн жилийн 23 оны 12 сарын 31-нээр тасалбар болгоод Орчны бохирдол бууруулах

үндэсний хороог шилжүүлсэн байгаа. 2 функцийг нь. Улаанбаатар хотын агаар орчны бохирдлын асуудлыг Улаанбаатар хотын Засаг дарга хариуцаж байгаа. Бусад орчны бохирдлын асуудлаар Байгаль орчны сайд дээр ингээд 2 тусдаа учраас ЭХЯ хариуцахгүй байгаа учраас би та бүхэнд танд хариулах бололцоо алга байна. НЗД болон Байгаль орчны яамнаас тодруулна гэсэн үг.

Л.Мөнхбаатар: Хууль санаачлагч нэмж хариулъя. Ганзоригийн Тэмүүлэн хариулъя.

Г.Тэмүүлэн: Энэ юу байгаа юм, Жаргалмаа гишүүн ээ. Нөгөө энэ бид нар улсын хилээр нэвтрүүлэхийг хориглох, тарифын бус хязгаарлалт тогтоох бүлэг барааны жагсаалт батлах тухай гээд энэ тогтоолын хавсралт дээр ерөөсөө л саяын тэр нүүрсэн яндангийн хаягдал буюу катализатор хаягдал гэдэг зүйлийг улсын хилээр гарахыг нь хориглох жагсаалтад л оруулж байгаа юм.

Тэгэхээр энэ яах вэ гэхээр нэг талдаа өнөөдөр нүүрсэн яндан гэдэг бол машинд байх ёстой зүйл болчхоод байгаа юм. Яндан дээр байдаг нөгөө агаар орчны бохирдлыг тэр 200, 300 гаруй хорт химийн элементүүдийг шүүдэг л байх ёстой зүйл. Инженерийн ухаанаар бүтээгдсэн, машинд байдаг л эд зүйл байгаад байгаа юм. Тэгэхээр ерөөсөө машинд илүү зүйл гэж угаасаа байхгүй зүйл байхгүй юу. Байх л ёстой зүйлийг манайх юу болж байна гэхээр нөгөө нэг тэр нүүрсэн янданд суурилагдсан байдаг үнэт металл гэдэг юм уу, цагаан алт гэдэг юм уу, палади гэдэг юм уу тэр зүйл нь өөрөө дэлхийн зах зээл дээр үнэтэй учраас түүнийг юу гэдэг юм өөрсдийнхөө эрүүл мэндийн төлөө ч гэдэг юм уу тодорхой цөөхөн хэдэн төгрөгийн төлөө түүнийг хулгайлж аваад цааши нь хил дамнаж дамлаж зардаг л энэ хууль бус хулгайг таслан зогсёе л гэдэг зүйл байгаад байгаа юм. Түүнээс юу гэдэг юм энэ нүүрсэн янданг бид нар машинд нь байлгая, тухайн өмч эзлэгч өмчөөрөө хохирохгүй байлгах нөхцөлийг бүрдүүлье.

Эцсийн дүндээ Улаанбаатар хотын болоод төв, суурин газруудын агаар орчны бохирдлыг бууруулъя гэдэг энэ зүйлийг байгаа шүү. Та үүнийг бас нэг тийм сайн ойлгож аваарай. Түүнээс нүүрсэн янданг бид нар нөгөө буцаагаад гаргахгүй болчихвол өөр энд тэнд үйлдвэрт өгөх барих гэсэн зүйл байхгүй. Эргээд зүй бус нь эрэлт хэрэгцээ дамлан наймаалах, хулгайлах энэ зүй бус тогтолцоо л байхгүй болно л гэсэн үг болчхож байгаа юм.

Л.Мөнхбаатар: Яах юм, тодруулах юм уу, та. Бадарчийн Жаргалмаа гишүүн тодруулж асууя.

Тодруулгын дараа санал хураалттай, гишүүд орж ирье.

Б.Жаргалмаа: Би яагаад ингэж тодруулж асуусан юм бэ гэвэл Тэмүүлэн гишүүн ээ, тогтоолын төсөл боловсруулах явцдаа бас түрүүний нөгөө үйлдвэр байгуулагдсан гэдэг, аюултай хог хаягдлын үйлдвэрийг аюултай хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэрийн талаар таныг мэдээлэл өгсөн учраас улсын хэмжээнд бас тийм байгаа энэ аюултай хог хаягдлын тоонд ороод байдаг энэ батарейн асуудал бас тодорхой хэмжээнд судлагдсан болов уу гэдэг үүднээс асуусан.

Нөгөөтээгүүр иргэд маань нөгөө үнэтэй гэдгээрээ бас нөгөө хилээр гаргаад байсан юм чинь ашиглах боломжгүй болчихдог юм болов уу гэж бодохгүй юу. Нүүрсэн янданг чинь. Тэгэхээр иргэд маань түүнийгээ бас үйлдвэрт чинь тушааж болох уу л гэж асууж байгаа юм. Баярлалаа.

Л.Мөнхбаатар: Тодруулгад хариулах юм уу? Нэмж хариулах зүйл байгаа юм уу? Хариулт тодорхой байна. Тийм ээ, санал хэллээ гэж ойлголоо.

Гишүүд байраа эзэлье. Санал хураалт явагдана. Гишүүд тогтвортой сууя. Чинзориг гишүүн байраа эзэлье, санал хураалт явагдах гэж байна.

Энэ санал хураалт явагдсаны дараа I хуулийн төслийн хэлэлцэх эсэхийг шийднэ. Түүний дараа Мэргэжлийн холбоодын эрх зүйн байдлын тухай хууль 25 санал хураалт явагдана. Тийм учраас гишүүд тогтвортой сууж саналаа өгье.

Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Үг хэлэх гишүүн байна уу? Алга байна.

Байнгын хорооны саналаар “Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураая. Санал хураалт.

57,1 хувиар санал дэмжигдлээ.

Бейсен гишүүнийг дэмжсэнд тооцлоо.

Төслийг хэлэлцэх нь зүйтэй гэж гишүүдийн олонх үзсэн тул төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэнд тооцон, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлээ. Тэмүүлэн даргад шилжүүлээ.

11.29 цаг

Дараагийнхаа асуудалд оръё. Дараагийн асуудалд оролцох хүмүүс Амарбаясгалан сайд ирсэн үү. Ажлын хэсгийн гишүүдийг дуудаарай. Ирчихсэн байгаа юу.

Уламжлалт МАА-д тулгамдаж байгаа буюу уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэнэ.

Ажлын хэсэг орж ирж байх хооронд би бас нэг зүйлийг энд хэлье гэж бодож байна

Улсын Их Хурлаар хэлэлцэж байгаа зарим нэг хуулийн төслийн талаар бас иргэд, олон нийтийн дунд бас ташаа мэдээллүүд яваад байгаа учраас үүнийг бас залруулах нь зүйтэй гэж бодож байна. Миний хувьд бас Улсын Их Хурлын гишүүнийхээ хувиар нэлээн олон хуулийн төслийг бас гишүүдийн хамтаар санаачилж, өргөн мэдүүлээд хэлэлцүүлээд явж байгаа. Монгол Улсын Их Хурлын тухай хууль, Их хурлын чуулганы дэгийн тухай хууль, Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль, Газрын тухай хууль гээд ийм хуулиудыг төслийг хэлэлцүүлээд явж байна. Үүнээс гадна бас нэг хуулийн төсөл санаачилсан нь бол энэ Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд нэмэлт оруулах ийм хуулийн төслийг санаачилсан. Энэ нь ямар учиртай хууль вэ гэхээр ШЕЗ-өөс бол санал нь гарсан ийм хууль байгаа юм. ШЕЗ бол Улсын Их Хурлаас байгуулагддаг Үндсэн хуульд заагдсан байгууллага. Ингээд ШЕЗ-өөс 06 дугаар сарын 14-ний өдрийг шүүхийн өдөр болох ийм санал санаачилга гаргаж, ирүүлснийг нь Улсын Их Хурлын гишүүн Мөнх-Оргил бид 2 хамтдаа санаачлан бас өргөн мэдүүлсэн.

Энэ хуулийн талаар бас нэг тодорхой ташаа буруу мэдээллүүд бас явагдаад байгаа учраас үүнийг бас залруулах нь зүйтэй гэж үзэж байна. Нийтээр тэмдэглэх баярын болоод тэмдэглэлт өдрийн хууль бол уг нь 2 агуулгатай ийм хууль. Нийтээр тэмдэглэх баярын өдөр гэдэг нь бол улс орны хэмжээнд нийтээрээ амардаг баяр болгон тэмдэглэдэг цагаан сар, улсын их баяр наадам, олон улсын эмэгтэйчүүдийн баяр гэдэг юм уу, хүүхдийн баяр гээд тэмдэглэлт өдрүүд.

Нөгөөдөх нь бол зүгээр тэмдэглэлт өдөр гэсэн үйл явдал байдаг. Энэ бол зүгээр тодорхой нийгмийн давхарга, ажил мэргэжлийг онцлогуудыг харуулсан зүгээр нийтээрээ тэмдэглэж занхисан л ийм өдрүүд байгаа юм. Одоо ахмадын өдөр гэдэг юм уу, архивчдын

өдөр, улсын бүртгэлийн ажилтны өдөр, багш нарын өдөр, эмч нарын өдөр гэдэгтэй адилхан энэ дээр бол шүүгчдийн өдөр гэж нэмье гэсэн ийм санаачилга л гарсан. Энэ бол олон нийтэд энэ өдөр бол огт амардаггүй, зүгээр тухайн байгууллага, ажилтан албан хаагчид нь өөрсдийнхөө хүрээнд тэмдэглэдэг ийм тэмдэглэлт өдөр юм.

Тэгэхээр энэ өдрийг яагаад 06 сарын 14-ний өдрийг сонгосон бэ гэхээр 1926 онд БНМАУ-ын аливаа шүүн таслах газруудыг байгуулах тухай ийм дүрэм гаргаад ингээд дүрмээс зохицуулж явж ирсэн нь 1993 оны 06 сарын 14-ний өдөр анх удаагаа хуулиар зохицуулагддаг болсон.

Шүүхийн тухай хууль бол 1992 оны шинэ Үндсэн хуульд нийцүүлээд 1993 оны 06 дугаар сарын 14-ний өдөр шүүх байгуулах тухай хууль Шүүхийн тухай хууль батлагдан гарсан энэ түүхэн тэмдэглэлт өдөр байгаа юм.

Ийм учраас бас анх удаагаа бас хараат бус бие даасан шүүхийн тогтолцоо бий болсон өдөр нь 06 сарын 14-ний өдөр учраас энэ өдрийг Шүүхийн өдөр болгон тэмдэглэх нь зүйтэй юм гэсэн ШЕЗ-ийн санал санаачилгыг ингээд дэмжин ингээд санаачилсан ийм зүйлүүд байгаа юм. Энэ өдөр бол олон нийтээр амардаггүй, зүгээр тухайн байгууллагын тэмдэглэлт өдөр өө гэдгийг бас энд тодруулан хэлье.

Энэ мэдээлэл нь бас жаахан буруу ташаа яваад байгаа юм. Бүх нийтээрээ 06 сарын 14-нд амрах юм гэнэ. Ерөнхийлөгч Хүрэлсүхийн төрсөн өдрөөр улс даяар амардаг болох нь эд нар гэсэн ийм буруу ташаа мэдээллүүд яваад байгааг бол залруулах нь зүйтэй гэж үзэж байна. Энэ нь шүүх болоод шүүгчдийн өдрийн хувьд түүхэн тэмдэглэлт анхны бие даасан хуультай болсон ийм өдөр нь байгаа юм гэдгийг энд бас тодруулан хэлье гэж бодож байна.

Ингээд хэлэлцэх асуудалдаа оръё.

Хуулийн танилцуулгыг, хууль санаачлагчийн илтгэлийг Монгол Улсын сайд, ЗГХЭГ-ын дарга Дашизэвэгийн Амарбаясгалан танилцуулна. Таныг индэрт урьж байна.

Д.Амарбаясгалан: Эрхэм Улсын Их Хурлын дэд дарга, Улсын Их Хурлын гишүүд ээ, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого Алсын хараа 2050-ийн тогтвортой хөдөө аж ахуй, 8.3-д хөдөө аж ахуйг байгальд ээлтэй уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон, эрсдэл даах чадвартай, нийгмийн хөгжлийн чиг хандлага, хэрэгцээ шаардлагад нийцсэн, хариуцлагатай, бүтээмж өндөр, тогтвортой үйлдвэрлэлтэй эдийн засгийн тэргүүлэх салбар болгон хөгжүүлнэ гэсэн зорилт дэвшүүлсэн.

Энэхүү зорилтын хүрэх хүрээнд нүүдлийн уламжлалт өв соёлыг хадгалсан, экологид ээлтэй, органик мал аж ахуйг тогтвортой эрхлэх, хөдөө аж ахуйн эрчимжсэн үйлдвэрлэлийг төрөлжүүлж, кластер, логистик, санхүүгийн түрээсийн үйлчилгээг хөгжүүлж төлөвшүүлэх, хөдөө аж ахуйн салбарын хүний нөөцийг бэлтгэх, чадавхжуулах, хөдөлмөрийн үнэлэмжийг нэмэгдүүлэх, тэдгээрийн тогтвор суурьшилтай ажиллаж, ая тухтай амьдрах нөхцөл, нийгмийн баталгааг сайжруулах, хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний гадаад зах зээлийг тэлж, зарим нэр төрлийн түүхий эд, бүтээгдэхүүний импортыг халж, экспортыг нэмэгдүүлэх зэрэг арга хэмжээг 2030 он хүртэл авч хэрэгжүүлэхээр зорьсон.

Мал аж ахуйн ДНБ-ий 10,5 хувийг, ажиллах хүчний 24,6 хувийг бүрдүүлж байгаа Монгол Улсын нийгэм, эдийн засгийн тогтвортой байдал, цаашидын хөгжилд чухал үүрэгтэй салбар юм. Гэвч дэлхийн дулаарлаас үүдэн сүүлийн 80 жилд агаарын жилийн дундаж температур 2,36 градусаар нэмэгдэж, хур тунадасны хэмжээ 7 хувиар буурч, 3-аас 4 жил тутамд ган зуд тохиож байгаа нь мал аж ахуйн салбарт томоохон

сорилт хүндрэлийг бий болгож байна. Сүүлийн 70 гаруй жилд манай оронд 13 удаагийн зудын улмаас нийт 45 сая толгой мал зүй бусаар хорогдсон бөгөөд 2010 онд нийт малын 22 хувь нь хорогдож, 8,6 мянган малчин өрх малгүй болж байсан.

Энэ оны өвөлжилт хаваржилтын хүндрэлийн улмаас 04 дүгээр сарын 08-ны өдрийн байдлаар улсын хэмжээнд нийт 9,6 хувь буюу 6,3 сая мал хорогдоод байна. Малынхаа 70 хувийг алдсан 1521 өрх, 80 хувийг алдсан 732 өрх, 90 хувийг алдсан 326 өрх, огт малгүй болсон 380 өрх байна. Иймд гамшигийн эрсдэл бодитой бий болсон нөхцөл байдал, гамшигт өртсөн малчдын амьжиргааг дээшилүүлэхэд чиглэсэн арга хэмжээг цаг алдалгүй авах шаардлагатай байгааг тус тус харгалзан Монгол Улсын Засгийн газраас Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж буй уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн төслийг санаачлан боловсруулан хэлэлцүүлж байна.

Хуулийн төслөөр мал аж ахуйн салбарыг уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөлд тэсвэртэй болгох, эрсдэлийг бууруулах, давах, туулах арга хэмжээг тодорхойлсон. Түүнчлэн малчид амьжиргаагаа дээшлүүлэх, нийтлэг хэрэгцээгээ хангах, мал аж ахуйн бүтээгдэхүүний эдийн засгийн өгөөжийг нэмэгдүүлэх хүрээнд сайн дураар хамтрах, хоршоонд нэгдэх санаачилгыг дэмжих замаар мал аж ахуйн салбарыг тогтвортой, үр ашигтай хөгжүүлэхэд чиглэсэн арга хэмжээг мөн тусгалаа.

Мөн малчдын хоршоонд нэгдсэн малчинд Зээлийн батлан даалтын сан 100 хүртэл хувийн баталгаа гаргаж, арилжааны банкны эх үүсвэрээр зээл олгох, малчны анхан шатын болон дунд шатын хоршооны загварыг бүс нутгийн онцлогтой нийцүүлэн тодорхойлох, малын тэжээл, таримал ургамлаа өөрсдөө тарих боломжийг бүрдүүлэх, төрийн дэмжлэгт хамрагдсан малчны хүлээх үүргийн талаар тусгалаа.

Хуулийн төсөлтэй холбогдуулан Газрын тухай хууль, Зээлийн батлан даалтын хууль, Хориооны тухай зэрэг хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулсан болно. Хуулийн төслийг хэлэлцэж дэмжиж өгөхийг хүсье. Анхаарал хандуулсанд баярлалаа.

Л.Мөнхбаатар: Амарбаясгалан сайдад баярлалаа.

Төслийн талаарх БОХХААБХ-ны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Гомпилдоогийн Мөнхцэцэг танилцуулна. Таныг индэрт урьж байна.

Г.Мөнхцэцэг: Улсын Их Хурлын дэд дарга, эрхэм гишүүд ээ, Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 04 дүгээр сарын 10-ны өдөр Улсын Их хуралд өргөн мэдүүлсэн Уламжлалт мал аж ахуй тулга дундаж буй уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалан сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслийг хэлэлцэх эсэх асуудлыг БОХХААБХ 2024 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Хууль санаачлагч уламжлалт мал аж ахуйн салбарыг уур амьсгалын өөрчлөлтийг сөрөг нөлөөллөөс хамгаалах, учирч болзошгүй эрсдэлийг бууруулах, даван туулах арга хэмжээг тодорхойлох, малчны хамтын санаачилга, хоршооллыг дэмжих, тэдгээрийн мал аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих, улмаар малын чанар, ашиг шим, малын гаралтай бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх замаар мал аж ахуйн салбарыг тогтвортой хөгжүүлэх зорилгоор хуулийн төслийг боловсруулсан байна.

Хуулийн төслийг иргэдийн оролцоог хангах, санал авах зорилгоор Улсын Их Хурлын Ди парламент мн цахим сайтад байршуулсан болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үеэр Улсын Их

Хурлын гишүүн Ц.Идэрбат малчдын зээл зээлийн хүүгийн талаар Засгийн газрын зохицуулалт хийсэн эсэх, малын индексжүүлсэн даатгалын нөхөн төлбөрийг малчдад хэзээ олгох талаар, малын тэжээл тариалах зориулалтаар олгох 5 га газрын хэмжээг тогтоосон үндэслэл, малчдын хөдөлмөр эрхлэлтийг хялбарчлах тоног төхөөрөмжийн гаалийн татварыг хөнгөлөх боломжтой эсэх, Улсын Их Хурлын гишүүн Б.Бейсен малын тэжээлийн үйлдвэрийг хэрхэн дэмжих, отрын бүс нутагт эм, эмнэлгийн тусламж үйлчилгээг үзүүлэх шаардлагатай талаар, Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ нэр бүхий 5 гишүүнээс өргөн мэдүүлсэн Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хэрхэн уялдаж байгаа талаар, Улсын Их Хурлын гишүүн Г.Ганболд уг хуулийн төслийн зарим заалт Төсвийн тухай хуулийн холбогдох заалттай хэрхэн нийцэж байгаа, Улсын Их Хурлын гишүүн төсөв батлах бүрэн эрхтэй уялдаж байгаа эсэх, Зээлийн батлан даалтын сангийн эх үүсвэрийн талаар эрсдэлд орсон малчдад нөхөн төлбөр олгох асуудлыг зохицуулах эсэх, Улсын Их Хурлын гишүүн Ц.Туваан Малчин өрхийн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөлтэй хэрхэн уялдуулах, хоршоонд ажиллах боловсон хүчний асуудлаар судалгаа хийсэн эсэх, хоршоодод олгох зээл, малжуулах хөтөлбөрийн санхүүгийн эх үүсвэр, малчдын бэлтгэсэн түүхий эд, бүтээгдэхүүний үнийг өсгөхөд ямар бодлого барьж байгаа талаар асуулт асууж, хариулт авсан байна.

Улсын Их Хурлын гишүүн Г.Мөнхцэцэг байгаль цаг үеийн нөхцөл байдал, хэрэгцээ шаардлагын үүднээс боловсруулсан энэхүү хуулийн төслийг дэмжиж байгаагаа илэрхийлээд, Зээлийн батлан даалтын сан болон Хөдөлмөр эрхлэлтийн сангаас үзүүлэх зээл, дэмжлэг, хоршоо, малчин өрхийн малын тэжээл тариалах газар сонгох асуудлыг хэрхэн зохицуулсан талаар салбарын бусад хууль зохицуулалттай хэрхэн уялдуулах, Улсын Их Хурлын гишүүн

Т.Энхтүвшин хуулийн төслийг баталсны дараа иргэд, олон нийт, малчдад сурталчлан таниулах ажлыг сайтар зохион байгуулах, говь, хангайн бүсийн нөхцөл байдалд уялдуулан хадлан, тэжээл бэлтгэх зэрэг арга хэмжээг зохион зохион байгуулах, малын үүлдэр угсааг сайжруулах үүднээс орон нутгийн ХАА-н газрын дэргэд мөн цөм сүргийг байгуулах боломжтой эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Ц.Анандбазар хуулийн төслийг дэмжиж байгаагаа илэрхийлээд, бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд нийцүүлэн бүс бүрд тэжээлийн аж ахуйг байгуулах боломжтой эсэх, Улсын Их Хурлын гишүүн Ц.Цэрэнпунцаг Зээлийн батлан даалтын сангийн төсөв хөрөнгийг цаашид хэрхэн бүрдүүлэх, зээл олгох шаардлага, нөхцөлийг тодорхой болгох, бэлчээрийг зүй зохистой ашиглах, хамгаалах асуудлыг Зээлийн батлан даалтын сангийн бодлоготой уялдуулах талаар зохицуулалт туссан эсэхийг асуулт асууж, хариулт авсан болно.

Түүнчлэн Улсын Их Хурлын гишүүн Х.Болорчулуун малчид цаг агаар, уур амьсгалын хүндрэлийг даван туулах гол арга зам нь хоршиж үйл ажиллагаа явуулах бөгөөд тэжээлийн ургамал хамтарч тариалах газрын асуудлыг иуурхай шийдвэрлэх, Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж байгаа бөгөөд таримал ургамлын асуудлыг газар тариалангийн хуулиар зохицуулж байгааг анхаарч холбогдох өөрчлөлтийг хийх, сум, орон нутагт байгаа малчдын хоршоо, холбоо тухайн газар тариалангийн талбайгаас давуу эрхтэйгээр тариалах боломжийг нээж өгөх, тусгай хамгаалалттай газар нутаг, өвөг дээдсээс уламжилж ирсэн мал аж ахуйгаа эрхэлж байгаа иргэд, малчин өрхийн эрх ашиг хязгаарлагдмал байгааг анхаарч, тэдний өвөлжөө, хаваржааны газрыг гэрчилгээжүүлэх, хаягжуулах асуудлыг шийдвэрлэх, малжуулах асуудлыг үр дүнтэй болгоход анхаарах зэрэг саналыг хэллээ.

Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж буй уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалан сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 86,7 хувь нь үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж буй уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Зээлийн батлан даалтын сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, Хоршооны тухай хуульд зарим хэсгийг хүчингүй болгосонд тооцох тухай, Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Тогтоолд нэмэлт оруулалт оруулах тухай хууль, тогтоолын төслийг хэлэлцэх эсэх талаар БОХХААБХ-ны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Л.Мөнхбаатар: Мөнхцэцэг гишүүнд баярлалаа.

Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя. Өнөөдрийн чуулганы нэгдсэн хуралдаанд хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан оролцож байгаа гишүүдээ танилцуулъя.

Монгол Улсын сайд, ЗГХЭГ-ын дарга Дашизэвэгийн Амарбаясгалан, Сангийн сайд Болдын Жавхлан, ХХААХҮ-ийн сайд Хаянгаагийн Болорчулуун, ХХААХҮ-ийн дэд сайд Мөнгөнцогийн Ганхүлэг, ЗГХЭГ-ын дэд дарга Ургамлын Бямбасүрэн, Монголбанкны Мөнгөний бодлогын газрын захирал Баярсайханы Баярдаваа, ЗГХЭГ-ын Хууль, эрх зүйн газрын дарга Чулуунбаатарын Дондогмаа, Сангийн яамны Төсвийн бодлогын газрын дарга Мижиддоржийн Санжаадорж, Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын даргын

албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Лувсандоржийн Сонор, Сангийн яамны Санхүүгийн хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга Солонгын Тулга, ХХААХҮЯ-ны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Цэндгомбын Болорчулуун, ХХААХҮЯ-ны Хуулийн хэлтсийн дарга Энхбаатарын Цолмонжаргал, ЖДҮ-ийн газрын дарга Ядамсүрэнгийн Эрдэнэсайхан, Зээлийн батлан даалтын сангийн гүйцэтгэх захирал Сарантуяагийн Цогтсайхан, ЗГХЭГ-ын референт Осоржавын Дөлгөөнтуул, ЗГХЭГ-ын референт Даваасүрэнгийн Батсүрэн нар оролцож байна.

Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд нэрсээ өгье. Туваан гишүүн орох юм уу? Туваан гишүүнээр тасаллаа, асуулт.

Одоо Улсын Их Хурлын гишүүн Нанзадын Наранбаатар асуултаа асууя.

Н.Наранбаатар: Гишүүдийнхээ энэ өглөөний амгаланг эрье. Энэ өвөл бол ер нь их хүнд өвөл байлаа. Сүүлийн 20, 30-аад жил тохиогоогүй ийм зудтай, цастай, хүндрэлтэй ийм өвөл байсан. Тэгээд сая Их Хурлын гишүүнийхээ тайланг танилцуулаад аймгийнхаа тойргийнхоо сумдаар ажиллалаа, малчидтайгаа уулзлаа. Тэгээд хэд хэдэн асуудал ярьж байна. Энэ дээр та бүхэн ямар арга хэмжээ авах гэж байна вэ гэж их асууж байна.

1 дүгээрт, энэ зээлийн асуудал дээр хүн бүхэн асууж байна. Малчны зээлийг яах вэ, тэглэх боломж байгаа юу, тийм зүйл яригдаж байна уу, хойшлуулсан нөхцөлд хүүг нь яах вэ, зээлийн хүү нэмэгдэж байгаа. Энэ зээлийн хүүг яаж зохицуулж байгаа вэ гэдэг ийм асуудал. Тодорхой хэмжээгээр бас бүгдийг нь тэглэхгүй юм гэхэд зарим нэг хэсгийг нь төрөөс төлөх ийм боломж байна уу гэдэг нэг ийм зээлтэй холбоотой.

Тэгээд цаашидаа энэ малжуулах төслийг яаж явуулах гэж байна вэ. Зээл Засгийн газраас бидэнд зээл өгөхөд цаашаа энэ барьцаа хөрөнгөгүй болсон нөхцөлд яаж зээлийг олгох вэ, ямар зохицуулалт байна вэ гэдэг. Ийм асуудал ярьж байна.

2 дугаарт, энэ залуу малчид улам цөөрч байна. Мал маллах хүнгүй болж байна. Тийм учраас залуу малчдыг дэмжих ямар арга хэмжээ авахаар та бүхэн ярьж байгаа вэ гэдэг. Ийм асуудал ярьж байна.

Мөн дараагийн дугаарт түүхий эд үнэгүй байгаа. Түүхий эдийг боловсруулах үйлдвэр цаашидаа түүхий эдийг үнэд хүргэх талаар ямар ажил хийх гэж байна, хийсэн тодорхой ажил байна уу гэдэг асуудал ярьж байна.

Дараа нь мал махаа борлуулах дээр арга хэмжээ авахгүй бол ченжүүдийн гарт бид чинь хамгийн хямдаар өгөөд, ингээд цаашаагаа ченжүүд өндөр үнэтэй зардаг ийм асуудал байна. Тийм учраас үүнийг яаж зохицуулах вэ гэдэг асуудлыг ярьж байгаа.

Дараагийн дугаарт энэ малын эмч, зоотехникч нарыг цаашидаа сайн бэлдэх ийм шаардлагатай байна. Энэ дээр төр засгаас тэр малчдын хүүхэд, ялангуяа сурахад нь сургалтын төлбөрийн дэмжлэг юмнууд байна уу, боловсон хүчнийг цаашидаа яаж бэлдэх ёстой вэ гэдэг ийм зүйлүүдийг бол асууж байна.

Тийм учраас та бүхэн энэ зүйлүүд дээр тодорхой шийдэхээр төлөвлөж байгаа ажлуудаасаа бас танилцуулбал сайн байна.

Л.Мөнхбаатар: Наранбаатар гишүүний асуултад хариулъя. Амарбаясгалан сайд хариулъя. Амарбаясгалан сайдын микрофоныг өгье.

Д.Амарбаясгалан: Наранбаатар гишүүний асуултад хариулъя. 2024 оны зуд ер нь ихээхэн хэмжээнд хүндрэлтэй, өмнөх жилүүдтэй харьцуулахад маш их

хүйтэн, цас ихтэй жил болж ингэж гарч байгаа. ОБЕГ-ын урьдчилсан үнэлгээ, олон улсын байгууллагуудын урьдчилсан дүгнэлтээр энэ жил 16-18 сая мал хорогдох эрсдэлтэй гэж ингэж үзсэн байгаа.

Тийм учраас Засгийн газраас энэ оны 1 дүгээр сарын төгсгөлөөс эхлээд малчдадаа тулгамдсан асуудал дээр нь дэмжлэг туслалцаа үзүүлж, малын хорогдлыг зохих хэмжээгээр бууруулах ийм бодлогыг авч хэрэгжүүлж, ингэж ажиллаж ирсэн. Энэ хүрээндээ ер нь энэ цас зудын нөхцөл байдал жилээс жилд улам бүр хүндэрч байна. Уламжлалт МАА-д уур амьсгалын өөрчлөлтөөс үзүүлж буй энэ сөрөг нөлөөлөл бол дааж давахад бэрх болж байна. Тэгэхээр үүнийг цаашдаа ийм байгаль цаг уурын өөрчлөлт, нөхцөлийг даван туулах чадвартай МАА болгож хөгжүүлэх замаар даван туулах ёстой юм. Тийм учраас Засгийн газар энэ гамшигийн үед бол энэ хуулийг өргөн барьж цаашдаа Засгийн газар хөтөлбөрийг хэрэгжүүлж ажиллах нь зүйтэй гэж ингэж үзсэн.

Энэ хүрээндээ таны асуусан залуу, түүхий эдийн үнэ өртгийг нэмэгдүүлэх, махаа борлуулах, ченжийн тогтолцоог халах, малын эмчийн тогтолцоог бодитой бий болгох зэрэг дээр тодорхой хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулж ажиллах шаардлага тулгарч байгаа. Өнөөдрийн энэ хэлэлцэж байгаа хууль батлагдсанаар энэ хөтөлбөр, төлөвлөгөөг хэрэгжүүлэх боломж нээгдэнэ гэж ингэж үзэж байгаа. Энэ хүрээндээ 2 асуудлыг шийдвэрлэхээр зорьж байна.

1 дүгээрт, малчид нийлж нэгдэж, сайн дурын үндсэн дээр хоршоо байгуулах, байгуулагдаж байгаа хоршоондоо хөрөнгө оруулалтын хөнгөлөлттэй зээлийг авч бүтээгдэхүүн гаргах энэ боломжийг бол нээж өгөхөөр 1 дүгээрт нь зорьж ажиллаж байна. Энэ зорилгын хүрээнд нэмүү өртөг шингээх зорилгоор олон төрлийн анхан шатын аж ахуй

эрхлэх боломж бүрдэнэ гэж ингэж Засгийн газрын зүгээс үзэж байгаа.

2 дахь асуудал буюу энэ малчдын зээлтэй холбоотой асуудал бас хөндөгдөж байна. Яг зээлийн асуудал бол Засгийн газраас гарсан тогтоол хэрэгжээд эхэлсэн байгаа. Уг тогтоолоор малчдын арилжааны банкнаас авсан зээлийн төлөх хугацааг 1 жилээр хойшлуулах, 1 жилийн хугацаанд хуримтлагдсан хүүгийн зардлын 75 хувийг Засгийн газар төсвийн эх үүсвэрээс төлж барагдуулах ийм шийдвэр гараад ингээд Монголбанк, арилжааны банкттай харилцан тохиролцоод үйл ажиллагаа бол явагдаад эхэлсэн.

Тэгэхээр яг бодитоор газар дээрээ зээлийн төлөлтийн хугацаа хойшлох нөхцөл нь бүрдсэн байгаа гэдгийг хэлье.

Л.Мөнхбаатар: Содномын Чинзориг гишүүн асуултаа асууя.

С.Чинзориг: Би асуулт асуухгүй. Зүгээр санал хэлчихье гэж бол бодож байна. Засгийн газрын гишүүн нөгөө Засгийн газраас өргөн барьсан хуулийн төслийг зарчмын хувьд бол дэмжиж байгаа юм.

Гэхдээ миний хэлэх гээд байгаа санал бол ер нь бид энэ нүүдлийн мал аж ахуйг уламжлалт аргаар нүүдлийн мал аж ахуй эрхлэх боломжгүй болчихлоо гэдэг нь олон жилийн энэ байгаль, цаг агаарын энэ өөрчлөлт, энэ ган зуд, энэ гамшигийн нөхцөл байдлаас харагдаад байна л даа. Би бол байнга л хэлээд байгаа юм. Манай нөгөө өвөг дээдсийн ярьдаг хаяа багтвал бууж, хамар хатгавал иднэ гэдэг зарчмаар энэ мал аж ахуйн бодлого чинь үйлдвэрлэл явахаа больчихлоо гэж. Тэгэхээр энэ Их Хурлаас, Засгийн газраас ер нь мал аж ахуйн талаар баримтлах бодлого, малчдын талаар баримтлах бодлого гээд цоо шинэ энэ цаг үедээ нийцсэн энэ нэг бодлогыг л яаралтай бас гаргах л асуудал их чухал байх юм. Яах вэ, энэ хэлэлцэж байгаа асуудал бол бараг л ч цаг үеийн шинж чанартай, бараг л нэг

удаагийн үйлчлэлтэй шахуу гэж хэлэхээр ийм хуулийн төсөл бол байгаа юм.

Малчдын чинь өмнө шийдвэр, мал аж ахуйн үйлдвэрлэлийн өмнө шийдмээр олон асуудлууд байна шүү дээ. Энэ бэлчээрийн асуудлыг яаж шийдэх юм. Мал маллагааны энэ арга барилаа яаж өөрчлөх юм. Энэ нүүдлийн мал аж ахуйн уламжлал онцлогоо хадгалсан мал аж ахуйн талаар баримтлах шинэ бодлого үнэхээр их чухал байна. Олон жил ярьж байгаа мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний боловсруулалт хийх, малчдын орлогыг нэмэгдүүлэх асуудлаа яаж шийдэх юм. Тэжээлийнхээ үйлдвэрлэлийг яаж нэмэгдүүлэх юм. Малын эрүүл мэнд, үржил селекцийн ажлыг яаж шинэ шатанд гаргаж хийх, шинэ энэ нөхцөл байдалтайгаа уялдуулж явуулах вэ эд нар гээд мал аж ахуйн талаар үйлдвэрлэлтэй холбоотой асар олон шийдэх шийдлээ хүлээсэн асуудлууд бол байна.

2 дахь асуудал. Энэ малчдын талаар авах арга хэмжээг ч гэсэн бид нар нэг цоо шинэ бодлого гаргаж явуулахгүй бол ерөөсөө л болохгүй байна. Малчдын энэ залуу халааг яаж бэлдэх юм. Залуу малчдад яаж мал маллагааны уламжлалт арга ухааныг заах, ядаж л байгалийнхаа шинж байдлаар нь манай ард түмэн чинь цаг агаараа шинжсн ирсэн уламжлалтай ард түмэн. Үүнийг нь энэ залуу малчдад яаж өвлүүлэх юм. Малчдын залуу халааг яаж бэлтгэх юм.

Нөгөө талаасаа малчдын хөдөлмөр чинь асар их биеийн хүчний зарцуулалт ихтэй хөдөлмөр. Малаа маллах, малаа услах, хадлан тэжээлээ авах, хонио хяргах, ноослох, самнах гээд бүгд дандаа гар ажиллагаатай. Биеийн хүчний асар их зарцуулалттай ийм хөдөлмөр. Үүнийг яаж бас хөнгөвчлөх юм, яаж механикжуулах вэ эд нар гээд асуудлууд.

Нөгөө талаасаа мал маллана гэдэг бол амаргүй хүнд хөдөлмөр. Байгаль, цаг агаарын асар их хүнд нөхцөлд, эрсдэл дор бас мал аж ахуйн үйл үйлдвэрлэл явуулдаг.

Хамгийн амь насанд, эрүүл мэндэд эрсдэл өндөртэй ажлын байр бол энэ мал маллах л байна шүү дээ. Төв суурин газрын бид яах вэ. Цасан шуурга нүдлээ, хүйтэн усан бороо орлоо гэвэл цонхоо хаагаад л, тэгээд л суучихдаг. Хөдөөгийн малчид хүйтэн усан бороо асгарсан ч, цасан шуурга нүдсэн ч амь насандаа, эрүүл мэнддээ хохирол учрахыг үл анзаараад л хэдэн малынхаа хойноос явдаг. Үүнээс малчид маш эрүүл мэндээрээ, амь насаараа хохирдог гээд энэ бүгдээс нь бас урьдчилан сэргийлэх, хамгаалах, ямар бодлого явуулах вэ гэдэг асуудлууд л тийм бодлогын шинжтэй асуудал маш их, асар их үгүйлэгдээд байгаа юм.

Тийм учраас миний хэлэх гээд байгаа санал бол энэ уламжлалт аргаар энэ мал аж ахуйн үйлдвэрлэл явуулах боломжгүй болчихлоо. Энэ цаг үедээ нийцүүлсэн мал аж ахуйн үйлдвэрлэлийг шинэ харилцааг зохицуулсан цоо шинэ бодлого, малчдын талаар баримтлах цоо шинэ бодлого яаралтай Их Хурлаас, Засгийн газраас гаргах шаардлагатай байгаа гэсэн ийм бас байр сууриа л илэрхийлж, үг хэлж байгаа юм.

Л.Мөнхбаатар: Чинзориг гишүүн санал хэллээ. үг хэллээ.

Ширнэнбаньдын Адьшаа гишүүн асуултаа асууя.

Ш.Адьшаа: Энэ Монгол Улсын Засгийн газраас оруулж ирж байгаа малчдын асуудал, уламжлалт мал аж ахуйн асуудлын талаар өргөн барьсан энэ асуудлыг зарчмын хувьд дэмжсн байгаа юм. Тэгэхдээ энэ асуудлыг энэ хуулийн хүрээнд өнөөдрийн оруулж байгаа асуудлын хэмжээнд өнөөдөр Монголын малчдын асуудал малын асуудлыг шийдэх шийдэл энд харагдахгүй байна, харагдахгүй байна.

Өнөөдөр ингээд малчдад зээл олгоё, зээлийн асуудлыг шийдье гээд сая энэ цас зудын үеэр гарсан энэ хохирлын асуудлыг зээлээр шийддэг л юм байгаа биз. Гэтэл цаана нь маш том асуудал байгаа.

Малчдын асуудал. Ялангуяа залуу малчдын асуудал. Бид нар чинь өнөөдөр 70 сая малтай гэж яриад байгаа шүү дээ. Энэ 70 сая малыг малладаг малчин хаана байна. Малчин хаана байна. Энэ малчдыг төрийн бодлогын хүрээнд эдийн засгийн бодлогоор дамжсан ямар бодлого явуулах гэж байна. Ингээд нэг цас зуд болоод мал энэ тэр нь хоргодоод ийм эрсдэл гарахаар нэг түр зээл өгөөд, зээлийн хүүгээс нь чөлөөлөөд явна гэвэл энэ бодлого биш ээ. Энэ бол түр зуурын 1 удаагийн арга хэмжээ.

Дээр нь өнөөдөр энэ малыг эрүүлжүүлэх, малыг бүртгэлжүүлэх асуудал дээр ямар бодлого явуулах юм. Өнөөдөр Монгол Улсын малыг бүртгэлжүүлэхгүй, эрүүлжүүлэхгүй, чөлөөт бүс бий болгохоос болоод өнөөдөр бид нар гадаадын зах зээл дээр Монгол малын махыг, Монгол малын мах, махан бүтээгдэхүүн бусад зүйлийг гаргахад өнөөдөр хоригт орсон байгаа шүү дээ. Энэ талаар ямар бодлого явуулж байна?

Дээр нь бид нар энэ уламжлалт аргаар өнөөдөр байгаль цаг уурын нөхцөлд өнөөдөр энэ мал аж ахуйг авч явна гэдэг энэ эрсдэлд учирсан. Өнөөдөр хөдөөгийн малчид тооны хойноос явдаг, чанарын асуудлыг яах юм. Өндөр үр ашигтай мал үржүүлэх, түүнийг нутагшуулахад Засгийн газраас эдийн засгийн бодлогын хувьд ямар бодлого явуулах юм. Үүнийг хэн хийдэг юм. Дээр нь малын энэ өвс тэжээл бэлтгэх асуудал дээр ямар бодлого явуулах юм. Одоо баруун аймагт бол нэг пресс өвс бол 30 мянган төгрөг байна, 30 мянган төгрөг байна. Энэ 30 мянган төгрөгийн 20 мянга нь тээврийн зардал байгаа, 20 мянга нь. Энэ асуудал өнөөдөр Дорнодоос баруун аймаг руу өвс зөөгөөд бүтэхгүй ээ.

Дээр нь бол өнөөдөр энэ Засгийн газар энэ Хөдөө аж ахуйн яам дандаа энэ ард түмнээ хууран мэхэлсэн юм хийж байна. Энэ гурил тэжээлийн гаалийн татвар тэглэнэ гээд 12 сараас Болорчулуун ингээд л яриад л байдаг. Одоо тэглэнэ. Одоо энэ чинь хаана байгаа юм.

Ингээд хууран мэхэлсээр байгаад энэ чинь дууслаа шүү дээ. Ингээж ард түмнээ хууран мэхэлдэг.

Энэ гурил импорт, юу гэнэ ээ. Гурилын үйлдвэр эрхлэгчид гэдэг энэ хүмүүс чинь өнөөдөр мафи болчихсон, ард түмнээ үнэтэй гурилаар шулан мөлжиж л байвал энд бусад хүний асуудал байхгүй байна шүү дээ. Тэгээд Оросоос, гадаадаас гурил оруулж ирэхээр юу нь болохгүй байгаа юм. Оросын аюул гэж ийм юм ни ар тараадаг. Энэ асуудал дээрээ ямар байр суурьтай байна вэ? Сонсьё. Үүнийг шийдэхгүйгээр бид нар өнөөдөр энэ малчдын асуудал, малын асуудал, эрүүл хүнсний асуудлыг ярих үнэхээр боломжгүй байгаа шүү.

Өнөөдөр нэн ялангуяа энэ Амарбаясгалан сайд та энэ гурилын тэжээлийн импортыг тэглэнэ гэсэн энэ хууль өргөн бариад нэг бол зүгээр ард түмнийг тайвшруулах гэсэн юм уу? Нэг бол танай энэ олонхын бүлгийн чинь гишүүд тэр гурил, тэжээлийн ашиг сонирхлын зөрчилтэй энэ компаниудын барьцаанд байгаа юм уу?

Дээр нь ингээд гурил, тэжээлийн асуудлыг яагаад шийдэж болохгүй байгаа юм. Бид нар урьд нь энэ гурил импорт өчнөөн хөнгөлөлттэй зээл олгож, татвар төлөгчдийн мөнгийг идэж ... /минут дуусав/

Л.Мөнхбаатар: Амарбаясгалан сайд асуултад хариулъя.

Д.Амарбаясгалан: Адьшаа гишүүний асуултад хариулъя. Гурилтай холбоотой асуудлыг асууж байна. Засгийн газар гурилын импортын татварыг тэглэх, тэглэхдээ хугацаагүйгээр тэглэх тогтоолын төслийг өргөн барьсан. Улсын Их Хурал дээр ирээд 45 хонож байгаа. Ажлын хэсэг ажиллаж байгаа гэж ингээж ойлгож байгаа. Үүнийг маш яаралтайгаар баталж өгөх шаардлага бодитой байна гэдэгтэй Засгийн газар санал нийлсэн. Ялангуяа инфляцад гурилаас үзүүлж

байгаа нөлөө, гурилан бүтээгдэхүүнээс үзүүлж байгаа нөлөө өөрөө өндөр хувьтай байдаг. Яг Монголчуудын тухайд гурил, улаан буудай тариалангийн салбар үндсэндээ вакум орчинд орчихсон. Үнэ өртөг харьцангуй өндөр үнээр ард иргэдэд худалдаалж байгаа энэ нөхцөл байдлыг засаж залруулах ёстой гэж ингэж үзэж байгаа. Мэдээж хэрэг дотоодын үйлдвэрүүдийг дэмжих бодлогыг Засгийн газар хэрэгжүүлнэ. Гэхдээ үйлдвэрүүдийг ашигтай байлгахын тулд ард иргэдээр үнэтэй гурил худалдан авч, гурилан бүтээгдэхүүн өндөр үнээр хэрэглэх нөхцөлийг бол яавч байлгаж болохгүй гэсэн энэ зарчмаар асуудалд хандаж байгаа. Тэгээд энэнд анхаарал тавьж байгаа Адышаа гишүүнд талархлаа.

Та бас бүлгийнхээ гишүүдэд энэ дээр дэмжлэг үзүүлж, ажиллах тал дээр нь зөвлөх нь зүйтэй байх. Ард иргэд өндөр үнэтэй гурил хэрэглээд байна гэж ингэж харж байгаа.

2 дахь асуудал. Өнөөдрийн уур амьсгалын өөрчлөлтөөс уламжлалт мал аж ахуйд тулгамдаж буй сөрөг нөлөөллийг бууруулахаар өргөн барьж байгаа хууль үндсэн зорилго нь мал аж ахуйн салбар илүү эдийн засагжих, илүү либералчлагдах, цаашилаад энэ салбараас ДНБ-д үзүүлдэг нөлөөллийг нэмэх, эдийн засгаа солонгоруулах ийм том бодлогыг хэрэгжүүлэх зорилготойгоор оруулж ирж байгаа юм. Би таны яг ярьсны эсрэг яримаар байна. Цаг үеийн шинжтэй нөхцөл байдал тулгамдахаар төр засгаас нэг хэдэн төгрөг тараагаад асуудлыг шийдвэрлэж байгаа мэтээр асуудалд хандаж ирснийг энэ удаа Засгийн газар засах гэж зорьж байна.

Малчдыг нэг удаагийн шинжтэй дэмжлэг туслалцаа үзүүлээд асуудлыг нь шийдэж чаддаггүй юм байна гэдгийг өнгөрсөн цаг хугацаанд ард иргэд ч харлаа, Засгийн газар ч харлаа, Улсын Их Хурал ч өнөөдөр бас үүнийг бүрэн ойлгох хэрэгтэй байх гэж бодож байна. Харин малчид маань өөрсдөө анхан шатдаа нэмүү өртгийг шингээх, бизнес эрхлэх тэр

боломжийг олгох зорилготойгоор өнөөдөр энэ хуулийн төслийг боловсруулж орж ирж байгаа.

Нэг удаагийн шинжтэй хууль ч гэсэн энэ хууль өөрөө мал аж ахуйн салбар байгаа цаг үед хэрэгжих боломжтойгоороо батлагдана. Нэг жилийн хугацаанд юм уу, 3 жилийн хугацаанд зориулж баталж байгаа зүйл биш. Энэ хууль цаашидаа мал аж ахуйн салбарыг сэргэлтэд аваачих зорилгыг агуулж байгаа. Малчид хамгийн эргэлт багатай бизнесийг хийж байна. Тэгэхдээ өнөөдөр арилжааны банкнаас зээл аваад тэр бизнесээ хийгээд, авч байгаа зээл нь жилийн 20-24 хувийн хүүтэй, өндөр хүүтэй. Тэгвэл энэ хууль батлагдсанаар жилийн 6 хувийн хүүтэй, урт хугацааны хөнгөлөлттэй зээлийг авч, арьс ширээ анхан шатад ... /минут дуусав/

Л.Мөнхбаатар: Тодруулах юм уу. Адышаа гишүүн тодруулж асууя.

Ш.Адышаа: Би Болорчулуун сайдаас тодруулж асууя. Энэ гурилын тэжээлийн импортын татварыг тэглэх тухай 12 сараас ярьж байсан. Энэ танай энэ Засгийн газрынхаа бодлогыг дэмжиж байгаа юм уу, дэмжихгүй байгаа юм уу? Яагаад ингэж уурлаад байна, Болорчулуун. Ашиг сонирхлын зөрчил байгаа юм бол үнэнээ хэл. Ингэж өнөөдөр ард түмнээ хүнсний хангамжийн асуудал, хямд үнэтэй гурил оруулж ирэх гэхээр яагаад болохгүй байгаа юм. Энэ хүмүүстэйгээ хариуцлага тооц л доо. Тэгээд ингээд энэ та нар өнөөдөр 62 хүн байгаа шүү дээ. 62 хүн 45 хоногийн хугацаанд энэ асуудал яагаад ярилцаад шийдэж болдоггүй юм. Ингэж болмооргүй байна. Энэ дээр хариулт авъя. Би Болорчулуун сайдаас асуучихъя.

Л.Мөнхбаатар: Амарбаясгалан сайд хариулъя. Дараа нь бол ажлын хэсгээс нэмж хариулж болно. Гэхдээ одоо Амарбаясгалан сайд хариулъя. Ажлын хэсгийн ахлагч.

Д.Амарбаясгалан: Энэ гурилын импортын татварыг тэглэх асуудал дан ганц Хөдөө аж ахуйн яамны асуудал биш байгаа юм. Сангийн яам, Эдийн засгийн хөгжлийн яам зэрэг яамнууд оролцож байгаа учраас энэ тогтоолын төслийг ЗГХЭГ-аас өргөн барьсан байгаа юм.

Энэ мал аж ахуйн бодлогын асуудлыг ч гэсэн өнөөдөр олон салбарын оролцоотой учраас салбар дундын зохицуулалтыг хийх зорилгоор Хэрэг эрхлэх газар энэ хуулийн төслийг бас өргөн барьж оруулж хэлэлцүүлж байгаа.

Гурилын импортын татварыг тэглэх, хугацаагүйгээр тэглэх энэ асуудлыг Засгийн газар бодлогоо асуудлаа нэг талдаа шийдвэрлээд, өргөн барьсан. Засгийн газар кабинетын зарчмаар ажилладаг учраас Улсын Их Хуралд өргөн баригдсан энэ тогтоолын төсөл хэлэлцэгдээд, Улсын Их Хурал дээр гарсан ажлын хэсгийн санал, дүгнэлтийг үндэслээд шийдвэрлэнэ гэж ойлгож бид хүлээж байна.

Яагаад хугацаагүйгээр тэглэх, хугацаагүйгээр мөн тэглэх асуудлыг оруулаад ирэв ээ гэдэг асуудал энд бас давхар яригдаад байгаа юм. Ер нь манай гурилын үйлдвэрүүд, улаан буудайн зах зээл 2 үндсэндээ вакум орчинд орчихсон байна. 400 мянган тонноос илүү улаан буудай тариалах боломжгүй. Тэр 400 мянган тонн улаан буудайнаас 340000-ыг нь гурилын үйлдвэрүүд худалдан авч, гурил үйлдвэрлэдэг. Энэ нөхцөл нь өөрөө улаан буудайн үнэ өртөг өсөх, улаан буудайн салбарт ашиг орлого олох боломжийг нь хязгаарладаг.

Нөгөө талдаа цөөн тооны хэдэн үйлдвэрүүд өндөр зардалтайгаар ажиллаад, бүтээгдэхүүн өндөр өртөгтэй гардаг. Хэрэглэгчид тэр гарсан өндөр өртгийг нь төлдөг ийм л тогтолцоо бий болчихсон учраас үүнийг цэгцлэх бодлогыг Засгийн газар авч хэрэгжүүлж байгаа.

Тариалангийнхаа салбарыг энэ хүрээндээ хамгаалах бодлогоо агуулаад

энэ 3 дахь өдрийн Засгийн газрын хуралдаанаар дотоодын хэрэгцээг хангаад илүү гарсан улаан буудайг экспортод гарах бодлогыг хэрэгжүүлэх үүрэг чиглэлийг ХХААХҮ-ийн сайдад үүрэг чиглэл болгосон.

Мөн тухайн жил гарах улаан буудайн 4 дүгээр зэрэглэлийн буудайн доод үнийг тогтоож зарлаж байх үүрэг чиглэлийг бас өгсөн байгаа. Ингээд тариалангийн салбарыг бол нэг талдаа хамгаалалтад авч байна ... /минут дуусав/

Л.Мөнхбаатар: Гүйцээгээд хариулчих юм уу? Амарбаясгалан сайд гүйцээгээд хариулчих. Бас энэ асуулт их олон удаа давтагдаж магадгүй учраас.

Д.Амарбаясгалан: Гурилын үйлдвэрүүдийг үнэ өртгөө зах зээлийн өрсөлдөөний зарчмаар үнийн хөөргөдлөө буулгах энэ асуудлыг бол Засгийн газраас шаардлага болгож тавьж байгаа.

Ер нь дэлхийн зах зээл дээр, хилийн цаана гурилын үнэ ямар байгааг та бид бүгд харж байгаа. Монгол Улсад тэр үнээс 3-4 дахин өндөр үнэтэй борлуулагдаад байгаа, худалдаалагдаад байгаа асуудлыг бас Засгийн газраас тогтоож, энэ асуудлыг шийдвэрлэх ёстой гэсэн ийм байр сууриар хандаж байгаа.

Яагаад хэмжээгүй хугацаагүй тогтоолыг гаргая гээд байгаа юм бэ гэхээр ер нь хэмжээ заагаад, хугацаа тавиад, гурил импортлох зөвшөөрлийг олгохоор тэр цаг хугацаанд нь тааруулаад гурилын үйлдвэрүүд үйлдвэрлэлээ багасгадаг. Үнэ өрсөлдөөний зарчмаар буурах нөхцөлийг бүрдүүлдэггүй учраас Засгийн газар ийм арга хэмжээг авах нь зөв юм гэж үзсэн.

Үнийн хөөргөдөл өрсөлдөөний зарчмаар буураад ирсэн тохиолдолд дараачийн хамгаалалтын бодлогыг Улсын Их Хурал, Засгийн газрын түвшинд авч хэрэгжүүлэх бүрэн боломж нээлттэй

байна гэж ингэж бол Засгийн газраас үзэж байгаа гэдгийг хэлье. Баярлалаа.

Л.Мөнхбаатар: Адьшаа гишүүн тодруулж асууя.

Ш.Адьяа: Энэ гурилын импортын гаалийн татварыг хугацаагүйгээр тэглэнэ гэдэг чинь маш зөв асуудал байгаа шүү дээ. Үүнийг би маш зөв гэж бодож байгаа юм. Тэгэхээр ингээд тэр яг л үнэн юм ярьж байна. Тэгэхдээ үүнийг л бид шийдэх ёстой, ярих биш шийдэх ёстой. 45 хоног ингээд яриад байна гэдэг ийм асуудал байж болохгүй ээ. Та нарт бол ард түмэн итгэл хүлээлгэж, 62 суудал өгсөн. Тэгээд ингээд энэ ашиг сонирхлын зөрчлийн барьцаанд орчихоод, ард түмнийхээ хямд үнэтэй гурил малчдаа тэжээлээр хангая гэхээр энэ болохгүй байдаг ийм юм юман дээр бид дүгнэлт хиймээр байна. Миний хувьд ард түмний төлөөллийн хувьд энэ нэг маш зүйтэй санал гэж би байнга ярьж, үүнийг дэмжиж байгаа. Энэ асуудлаа л хурдан яаралтай оруулж ирье. Ингэж шийдэх нь зөв өө гэж бодож байгаа. Энэ асуудлыг маш хурдан хугацаанд л шийдье, үүнийг шийдлээ л бид түргэн шийдэх ёстой л гэсэн ийм байр суурь ... /минут дуусав/

Л.Мөнхбаатар: Адьшаа гишүүн дэмжиж үг хэллээ.

Одоо ер нь Жадамбын Бат-Эрдэнэ гишүүн бас үг асуулт асууна. Ингэхдээ тэр гурилын үнийг буулгахтай холбоотойгоор байгуулагдсан ажлын хэсгийнхээ явцыг бол бас мэдээлэл өгчих нь зүйтэй байх. Иргэд олон нийтийн дунд бас нэлээн хүлээлт үүсээд байгаа учраас энэ дээр нь тодорхой мэдээлэл өгчхөөрэй гэж хэлье.

Жадамбын Бат-Эрдэнэ гишүүн асуултаа асууя.

Ж.Бат-Эрдэнэ: Уламжлалт мал аж ахуйд уламжлалт уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах тухай гээд хуулийн төсөл орж ирж байна. Хуулийн төслийг

үндсэндээ дэмжиж байгаа. Энэ жил маш хүнд өвөл, хавар болсон, та бүхэн бүгд мэдэж байгаа. Энэ зуд турхан малчид маань ер нь хүнд тусдаг шүү дээ. Энэ жилийн хувьд 6,3 сая мал хорогдсон юм байна. Тэгэхдээ зуд турхан малчдад маань ийм бас тустай байна гэж үнэндээ бас санаанд орсонгүй ээ. Үндсэндээ тус хийчихлээ л гэж би бодож байгаа. Энэ зуд турхан. Яагаад гэхээр энэ малтай холбоотой асуудал, мал аж ахуйтай холбоотой асуудалд ер нь шинэчлэл хийх ёстой зайлиггүй шинэчлэл хийх ёстой гээд бид нэлээн ярьсан шүү дээ. Жишээ нь, Шинэ хөдөө хөтөлбөр гээд. Миний хувьд 2017 оноос л хойш ингээд хэрэгжүүлээд явсан. Олон гишүүд маань үүнийг дэмжээд ер нь явж байгаа. Тэгээд цаашидаа бид нар ерөөсөө мал аж ахуй, энэ хөдөө аж ахуй дээр шинэчлэл хийх ёстой гэдэг зүйл рүү ингээд орчхож байгаа байхгүй юу даа.

Тэгээд энэ жилийн зуд турхан яагаад тус болоод байна гээд тэгэхээр үнэхээр бид нар нөгөө 10 ширхэг өвс бариад л нөгөө малчид руугаа очих биш Засгийн газар маань арай ондоо түвшинээс харья гэж байгаа юм байна. Шинэчлэл хийе гэж байгаа юм байна. Мал аж ахуйгаа сууриар нь өөрчилье. Хагас эрчимжсэн мал аж ахуй руу орёе гэж байгаа юм байна. Тийм болохоор дэмжиж байгаа юм. Бүр 2 гараа өргөөд дэмжиж байгаа шүү. Жишээ нь энэ 10 га газрыг малчдадаа олгоёе гэж байгаа юм байна. Ямар ч байсан хоршоолох хэлбэрээр. Ер нь цааш цаашидаа хоршоолох хэлбэрээр явах нь, уучлаарай 5 га шүү. Тийм.

Хоршоолох хэлбэрээр цаашидаа бол явах нь үнэхээр зөв хувилбар. Жишээ нь манай аймаг дээр жишээ нь Сайхан сум дээр бид нар 20 өрх нийлж байгаад хоршоо байгуулаад, тэгээд засаг захиргаанаас нь тодорхой 100 гаран га газар ингээд олгосон. Энэ хоршоонд орсон хориод өрх маань өнөөдөр гэхэд ногоон тэжээл тариалаад, яг өөрсдөд нь амьдралд нь тус дэм болоод ингээд тэр хавийнхаа нутаг орныхондоо ч бас

илүүдлээ ингээд зарж борлуулаад ингээд явчхаж байгаа байхгүй юу.

Тэгэхээр бид нар эрчимжсэн хагас эрчимжсэн мал аж ахуй руу орно гэдэг маань нөгөө нөгөө бид нарын нэг буруу ойлголт яваад байгаа шүү дээ. Бүх малаа аваачаад ингээд хаичих л юм шиг бодоод байгаа юм, үгүй шүү дээ. Хамгийн гол асуудал бол энэ малын борлуулалт дээр яаж нөлөөлөх юм. Тэгээд хадлан тэжээлээ яаж авах юм, яаж хорших юм, таримал ургамлаа яаж тарих юм, түүнийг нь яаж дэмжих юм.

Цааидаа малынх нь борлуулах схемийг нь бид нар яаж боломж бололцоогоор нь дэмжих юм. Түүхий эд бэлдэх тогтолцоогоо бид нар өөрчлөх ёстой болж байна. Сум болгон дээр тэр мал нядлах нядалгааны цэгүүд бий болох хэрэгтэй болж байна. Ариун цэвэр хангасан ийм цэгүүд бий болох хэрэгтэй болж байна. Магадгүй хоршоод өөрсдийн мал нядлах цэгтэй байгаад эсвэл тодорхой хэмжээнд хоршоод нийлж байгаад малаа махны үйлдвэрүүддээ тушаадаг байгаад, махны үйлдвэрүүд нь цаашаагаа бэлтгэн нийлүүлэлтийг нь хангаад цаашаа өшөө борлуулалтаа нэмэгдүүлээд ингээд малчдын амьжиргаа дээшээ болох энэ нөхцөлийг жишээ нь энэ хуульд заагаад орж ирж байна л гэж ойлгоод байгаа юм.

Тийм болохоор сая хэллээ шүү дээ. Ер нь малчид хадлан тэжээлээ бэлдэх, таримал ургамлаа тариалах ийм боломж бололцоо энэ дотор нээгдэж байна л гэж байгаа юм. Тэгээд энэ дээр тэр түүхий эд бэлдэх тогтолцоог зайлшгүй сайжруулах хэрэгтэй. Энэ дээр өшөө ямар нөгөө хоршоогоо яаж дэмжвэл ийшээ орох боломж бололцоо байна. Таримал ургамлаа нэгдэж тарьдаг ийм тогтолцоог зайлшгүй хийх хэрэгтэй болчхоод байна.

Тэгээд мал борлох малаа, мал, махаа борлуулах энэ тогтолцоог маань яаж дэмжих вэ. Энэ дээр малчид маань яаж нөгөө нэг хоршоогоо дэмжиж, эндээ

хоршоод нь хамтраад цаашаа нэг тогтолцоогоор нэг сувгаар мал махаа борлуулдаг байх юм уу. Нэг иймэрхүү иймэрхүү зүйлүүд нэлээн шинэчлэл хийж байж бид нар энэ хуулийн үр дүн гарах гэж байгаа гэж би их найдаж байгаа. Орж ирж байгаа хуулийг үндсэнд нь дэмжиж байгаа юм.

Гурилтай холбоотой асуудал дээр ... /минут дуусав/

Л.Мөнхбаатар: Хариулт өгчих юм уу? Үг байгаа. Гэхдээ дэмжсэн 3, дэмжээгүй 3 нь л үг байна шүү дээ, хэлэлцэх эсэх учраас тийм ээ.

Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулъя. Амарбаясгалан сайд хариулъя.

Д.Амарбаясгалан: Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулъя. Ер нь Засгийн газар хөдөө аж ахуйн салбарыг шинэ түвшинд гаргах зорилгыг агуулж, энэ хуулийг оруулж ирсэн, тантай бас санал нэг байна. Бас оруулж ирж байгаа хуулийн төслийг бас бүрэн ойлгож, дэмжиж байгаад талархал дэвшүүлж байна.

Ер нь энэ хөтөлбөрийг боловсруулж, энэ хуулийн төслийг гаргахдаа Засгийн газраас томилогдсон ажлын хэсэг орон нутгаар бас нэлээдгүй явж ажилласан. Жишээлбэл, Булган аймгийн хэд хэдэн сумд байгуулагдсан малчдын бүлэг, зарим хоршооны үйл ажиллагаатай танилцаад явсан.

Таны саяын хэлсэн Шинэ хөдөө хөтөлбөр бол сүүлийн жилүүдэд их амжилттай хэрэгжээд, малчид нийлж, нэгдэж бүлэг болж, хамтдаа тулгамдаж байгаа томоохон асуудлыг шийдвэрлэх ёстой юм байна гэдэг энэ ойлголтыг ихээхэн хэмжээнд авсан байна лээ. Энэ бол таны хувьд сүүлийн 5, 6 жил бас хэрэгжүүлсэн сайн хөтөлбөр байна гэж Засгийн газрын зүгээс бас талархууштай хүлээж авч байгаа.

Тэнд дутагдаж байгаа нэг зүйл бол хөрөнгө оруулалт хийж, анхан шатдаа мал нядалгаа, арьс түүхий эд, анхан шатын тордолтын цех, ногоон тэжээлээ тарьж ургуулах, хадлан тэжээлээ уураг тэжээлийн хангалтыг нь бүрэн хэмжээнд хийж чадахуйцаар бэлтгэх гэх мэт олон асуудал дутагдалтай байгаа юм. Тэгэхээр Засгийн газар энэ хуулийн төслийг өргөн бариад, хөнгөлөлттэй хөрөнгө оруулалтын зээлийг олгох энэ бодлогыг нь дэмжиж өгч байгаа.

Засгийн газраас оруулж ирж байгаа энэ бодлогыг Монголбанк, арилжааны банкнууд, Зээлийн батлан даалтын сан, Үндэсний давхар даатгал, хувийн даатгалын компаниуд, хоршоологчдын нэгдсэн холбоо, Малын бэлчээр ашиглалтын холбоо зэрэг холбоод, ТББ, эрдэмтэн судлаачид бүрэн дэмжиж, санал нэгдэж, ингэж оруулж ирж байгаагаараа илүү их тийм онцлогтой байгаа.

2 дугаарт, хоршоолж нэгдсэний үндсэн дээр энэ хөнгөлөлттэй зээлд хамрагдах хөшүүрэг боломжийг энэ хуулиараа бид гаргаж өгнө. Цаашидаа Засгийн газраас баталж хэрэгжүүлэх хөтөлбөрөөр тэр зүйлийг маш тодорхой зарлана. Ингэснээрээ богино хугацаанд мал аж ахуйн салбарыг сэргэлтийг бий болгох, өнөөдөр ДНБ-д үзүүлж байгаа 10 орчим хувийн нөлөөллийг 30 орчим хувьд ойрын 10 жилийн хугацаанд хүргэх боломжийг нээх зэрэг агуулгыг агуулснаараа илүү онцлогтой болж байгаа гэдгийг хэлмээр байна.

Ер нь энэ хөтөлбөр арга хэмжээг авахгүйгээр цаашидаа мал аж ахуй өөрөөрөө сэргэнэ ээ гэдэг хүлээлт хот, хөдөө хаана ч байхгүй болж ирж байна. Цаашидаа зудын энэ нөхцөл байдал жил дараалаад бий болох юм бол өнөөдөр бид хэдийгээр 60 орчим сая малтай байгаа ч гэсэн 2 жил, 3 жил дараалсан энэ хүндрэл бэрхшээлийн ард дээр 20, 30 сая малтай үлдэж чадах уу, үгүй юү гэдэг асуулт бидэнд ирж байгаа учраас энэ арга хэмжээг яаралтай авч хэрэгжүүлэх нь зөв

юм гэж Засгийн газраас үзэж оруулж ирж байна.

Хөдөө аж ахуйн салбарт хөнгөлөлттэй зээлээр дамжуулаад энэ хөрөнгө оруулалтын хийх боломжийг олгож өгснөөр тогтвортой ХАА-н салбарын нийлүүлэлтийг ... /минут дуусав/

Л.Мөнхбаатар: Бат-Эрдэнэ гишүүн тодруулж асууя.

Ж.Бат-Эрдэнэ: Таны оруулж ирж байгаа хуулийн хамгийн гол түлхүүр ерөөсөө хөнгөлөлттэй зээл гэж хараад байгаа юм. Хөнгөлөлттэй зээл. Тэгээд хөнгөлөлттэй зээлийн чинь ард талд нөгөө малчид маань жишээ нь зээл авах гээд юу тавих вэ дээ. Нэг 5 малаа л тоолуулдаг. 5 мал нь Хаан банкандаа бүртгэлтэй байгаад байдаг. Тийм болохоор энэ ард талд нь оруулж ирж байгаа Зээлийн батлан даалтын санг оруулж ирж байгаа чинь ер нь маш чухал харагдаад байгаа юм. Тэгэхээр энэ чинь ерөөсөө энэ зээл олгох, хөнгөлөлттэй зээл өгөх, тэгээд Батлан даалтын сан ард талд нь зогсох энэ механизм чинь хамгийн гол түлхүүр болж байна л гэж хараад байгаа юм л даа.

Тийм болохоор та бүхний тооцоолол дээр ер нь хэдий хэмжээний жишээ нь улс орны хэмжээнд энэ мал аж ахуйг хөл дээр нь босгох, малчид маань хөл дээрээ босох боломж бололцоо нь олгоход ер нь зээлийн тоо гэх юм уу, энэ нууц биш байх гэж бодож байгаа. Ер нь тооцооллоор хэдий хэмжээний зээл, ямар хөнгөлөлттэйгээр олгох юм шиг байна. Энэ тооцооллын бас нэг тодруулж өгөөч гэж хүсэж байна. Баярлалаа.

Л.Мөнхбаатар: Тодруулгад нэмж хариулъя. Амарбаясгалан сайд хариулъя.

Д.Амарбаясгалан: Урт хугацаандаа 5 их наядын хөтөлбөрийг хэрэгжүүлэх ёстой гэж ингэж зорьж байгаа. Мэдээж мал аж ахуйн салбарын өнөөгийн хөгжил, байгаа нөхцөл

байдалтай уялдуулаад нэг дор энэ их хэмжээний мөнгө орж шингэх боломж байхгүй. 2024 оны тухайд арилжааны банкны өөрийн эх үүсвэрээр Төрийн банк, Хаан банк зэрэг арилжааны банкны өөрийн эх үүсвэрээр 500 орчим тэрбум төгрөг мал аж ахуйн салбарт хөрөнгө оруулалтын хөнгөлөлттэй зээл хэлбэрээр орох боломжтой гэж ингэж үзэж байна. Улсын Их Хурал дээр энэ хууль нэн яаралтай горимоор хэлэлцүүлж байгаа учир шалтгаан ч мөн адил үүнтэй холбоотой. Цас зудын нөхцөл байдал яг ийм байгаа цаг үед ард иргэд, малчид өөрсдөө нийлж, хоршиж, мал аж ахуйн салбарыг шинэ түвшинд гаргах зайлшгүй шаардлагатай гэж ойлгож хүлээж байгаа энэ цаг үе дээр энэ шийдвэр гарч хэрэгжих нь, эхлэх нь их туйлын ач холбогдолтой гэж Засгийн газрын зүгээс үзэж байна.

Хоршоо гээд ингээд ярихаар ард иргэд бас хуучин хоршооны загварыг бас их барьж үзээд байдаг. Хөрөнгөөрөө нийлээд нэгдээд хоршоо байгуулах юм байна гэж ойлгоод өнгөрсөн хугацаанд хоршоо нэлээдгүй олон тоогоор байгуулагдсан байна. Жишээлбэл, зөвхөн мал аж ахуйн салбарт 1571, нийт байгуулагдсан хоршоодын тоо 5000 гаруй хоршоо байгуулагдсан. Эдгээр хоршоод хөрөнгө оруулалтын эх үүсвэр байхгүйн улмаас амжилттай үйл ажиллагаа явуулж байгаа нь маш цөөн байна.

Тэгэхээр хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг нь нээгээд хоршиж ажиллах боломжийг нь бий болгож өгье гэж байгаа. Ингээд хөрөнгө оруулалтын зээл олгоё гэхээр барьцааны хангалт шаардлагыг хангахгүй байгаа учраас энэ хөрөнгө оруулалтаа авч чадахгүй. Тийм учраас Засгийн газар Зээлийн батлан даалтын сан зээлийн хэмжээнээс хамаараад 100 хүртэл хувиар батлан даах боломжийг өнөөдрийн энэ хуулийн зохицуулалтаар оруулж ирж байгаа юм. Нэг ёсондоо 20 хүртэл сая төгрөгийн зээлийг 100 хувийн батлан даалтаар авах боломжийг нь нээж өгч байгаа юм. 50

хүртэл сая төгрөгийн зээл нь 80 хувийн хүртэл хувийн ... /минут дуусав/

Л.Мөнхбаатар: Хариулт тодорхой юу, тийм ээ.

Хоршооны тухай хуулийг Нямаагийн Энхболд гишүүн бид 2 санаачилж батлуулсан. Энэ хугацаанд сая Амарбаясгалан даргын хэлсэн 1500 гаруй хоршоо байгуулагдсан. 5000 гаруй хоршоо нийтдээ бол байгуулагдсан байгаад байгаа юм. Гэхдээ энэ бидний санаачилсан хуулийн хэрэгжилт бас төдийлөн бас тодорхой үр дүнд хүрч байгаа болов чиг яг эдийн засгийн хөшүүргийн байхгүйн улмаас бас тодорхой саад бэрхшээлүүд учраад байсан юм. Энэ асуудал нь бол энэ хуулиар шийдэгдэнэ ээ гэж ойлгож байгаа. Ингэх юм бол шинэ хоршоо, чинээлэг малчин, шинэ хөдөөшинэ айл гэсэн энэ томоохон энэ зорилтууд маань бол ингээд шийдэгдээд явах боломж бүрдэж байна гэж үзэж байгаа юм.

Одоо Улсын Их Хурлын гишүүн Буланы Бейсен асуултаа асууя.

Б.Бейсен: Энэ уламжлалт мал аж ахуйд тулгамдаж буй уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах тухай төсөл болон өргөн мэдүүлсэн хуулийн төсөл, тогтоолыг дэмжиж байгаа.

Гэхдээ одоогийн байдлаар ер нь бид нар зуд, байгалийн ийм хүчин зүйлийг даван туулах нөхцөл туйлын хангалтгүй байна. Би малчин айлын хүүхэд учраас энэ жил болгон ийм байдалтай байвал бид нар алдагдал, янз бүрийн юунд орно л доо. Гэхдээ малын хашаа 2, 3 өдөр шуурлаа гэхэд тэр уур амьсгалын өөрчлөлттэй битүү хашаатай байх ёстой. Малчдыг орон сууцжуулахгүй бол ерөөсөө сая эсгий гэр хар харсан биз дээ. Та бүгд. Яндан нь харагдаж байна. Тэгээд тэр цас нь хайлна. Тэгэхээр чинь амьдрал тун хэцүү болох талтай байна шүү дээ. Тийм учраас энэ тодорхой хэмжээний төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлээд, буцалтгүй тусламж ч юм уу үүнийг гаргах хэрэгтэй.

Тэгэхдээ үүнийг гаргах нөхцөл энэ сая сүүлийн нэг асуулт байна. Энэтэй холбоотой. 21,22,23, 24 онд УОК-оос Монгол Улсын Засгийн газраас энд хэчнээн тэрбум төгрөгийн юу зарцуулсан бол. Зудын байдалд. Хэрвээ үүнийг энэ бэлдчихсэн байвал тэнд хэмжээний хохирол учрахгүй л дээ.

Малын тэжээл бэлдэх асуудлууд байж байна. Эртхэн шиг бэлдэхгүй яг зуд болохоор л үздэг. Үүнийг эрт бэлдээд яахгүй бол байдал тун хүнд байна. Жишээлбэл Баян-Өлгий аймагт би нэг ганц юм ярья. Өвлийн бэлтгэл ажил, малын зудын бэлтгэл ажлын тендерийг эрт зарлах ёстой байсан. Аймгийн удирдлагын буруутай үйл ажиллагаанаас болоод 01 сарын 30, 02 сарын 25-нд зарлаж байгаа шүү дээ, тендерийг нь. Засгийн газар бас эндээ хяналт хийхгүй бол ерөөсөө иргэдийн хуралдаа ч эд нар авч хэлэлцээгүй. Жишээлбэл 1,1 тэрбум төгрөгийн малын тэжээл, хэвгийн асуудлыг 02 сарын 25-нд зарлаж байгаа. Зуд болсон үед нь.

Нөгөө талаар энэ өвс 01 сарын 30-нд 350 сая төгрөгийн өвс. Энэ мэтийн тухайн салбарын удирдлагууд орон нутгийн удирдлагуудын хариуцлагагүй байдлыг сүүлдээ Засгийн газар руугаа чихдэг. Засгийн газар ийм улсууддаа хариуцлага тооцож баймаар юм, ерөөсөө.

Тийм учраас энэ дээр анхаараад сая энэ сүүлийн хэдэн жилд хэчнээн төгрөгийн УОК, Засгийн газар, Хөдөө аж ахуйн яамнаас шинэ төгрөгийн зардал гарсан бол? Үүний тооцоог хэлж өгөөч?

Малын тэжээлийн асуудал дээр мөн адилхан. Үүнтэй холбоотой бас нэг 2 санал байна. Энэ отрын бүс нутагт явуулын, яг зудын байдалтай үед нь мал төллөх үед нь явуулын эмнэлэг ажиллуулах, туулах чадвар сайтай машинтай, урьд нь соц нийгмийн үед дайчилгаагаар ажилладаг байсан. Цалин өгөөд эмч нар ажиллуулдаг. Явуулын аптека ажиллуулдаг. Мал төллөж байгаа үед чинь тэгээд хүн болгон түүнийг

тусламж авч чадахгүй, явах боломжгүй шүү дээ. Тэгээд дараа нь яачихна биз, 1, 2, 3 сар л байгаа биз.

Дараа нь Ногоон нуурын тэжээлийн аж ахуй гээд соц нийгмийн үед ажиллаж байсан. Үүнийг сэргээх боломж байхгүй юм уу. Талбай нь бэлэн байж байна. Хивэг үйлдвэрлэж байсан. Тухайн хувьчилж авсан компани барилга нь одоог хүртэл хоосон барилга л байж байх юм. Техникийг нь дараагаар зарчихсан. Үүнийг сэргээчихвэл тэгээд баруун аймагт бас тус дэмтэй болно шүү дээ. Хэдэн жил Баянхонгор, Говь-Алтайн зудтай үед Ногоон нуурын хадланчид нь өвөлжингөө хаддаг юм шүү дээ. Хадаад дуусдаггүй. Тэгээд наашаагаа нүүсэн. Энэ дээр анхаарах боломж байна уу?

Л.Мөнхбаатар: Бейсен гишүүний асуултад хариулъя. Амарбаясгалан сайд хариулъя.

Д.Амарбаясгалан: Мэдээж 1992 оноос хойш мал хувийн өмч өө гэдэг ийм байдалтай явж байна. Мэдээж Үндсэн хуулиараа малаа хамгаалах нь төрийн үүрэг ээ гээд бас ингээд заагдаад явж байдаг. Тэгээд энэ хүрээндээ мал аж ахуйн салбарыг дэмжих бодлогыг гаргахдаа голдуу халамжийн төрлийн бодлого гаргаж явж ирсэн байна. Үнэгүй хуц ухна аваачиж тарааж өгдөг, үнэгүй машин техникээр хангах гэж үздэг, үнэгүй хашаа хороог нь засах гэж үздэг. Тэгээд үр дүнгээр нь өнөөдөр малчдын амьдрал амьжиргаа дээшлээгүй, яг л байдгаараа байна.

Өнөөдөр нэг малчин өрхийн дундаж орлого сая 500 мянга, дундаж зардал 2 сая 100 мянган төгрөг болсон. Ийм байдалтай байна. Үндсэндээ дунджаар малчин сар болгон 600 мянган төгрөгийн алдагдалтай амьдарч байна. Тэгэхээр үүнийг бид ул углуургаар нь асуудлыг шийдвэрлэх зорилго тавихгүйгээр цаг үеийн шинжтэй хашаа хороог нь засах, үнэ төлбөргүй үйлчилгээ үзүүлэх, бэлэн мөнгө тараах гэх мэт арга хэмжээг авсны үр дүн бол цаашидаа

гарахгүй нь нэгэнт тодорхой болж байгаа юм.

Тэгэхээр Засгийн газар энэ удаа малчдад хөрөнгө оруулалт хийж, бизнес эрхлэх, алдаж онох тэр боломжийг зээлийн бодлогоор дамжуулж хийх нь зүйтэй гэж үзэж байгаа юм. Ямар стандартын хаашаа хороотой байхыг мэдээж энэ 40 градусын хүйтэнд яаж тэсвэртэй байх вэ гэдэг стандартыг Хүнс, хөдөө аж ахуйн яам гаргаж байх ёстой. Түүний хөрөнгө оруулалтыг малчид маань өөрсдөө хоршиж, нэгдэж, өөрийн үйл ажиллагааны хүрээнд хийж авч явах боломжийг нь нээж өгч байгаа юм. Мэдээж энэ хууль батлагдаад бүх малчин өрх хоршоонд нэгдээд явчихгүй. Энэ урт хугацаандаа жил болгон нэг 10 хувь, 15 хувь нь хамрагдах байдлаар ахих боломжтой гэж байгаа юм. Энэ үед гарах алдаа дутагдлаа засаад, улам бүр сайжруулаад явах боломжийг бүрдүүлнэ ээ гэж ингэж зорьж байна.

Өнөөдөр Монгол 1 малын дундаж ДНБ-д үзүүлж буй өртөг нь 31 доллароор хэмжигдэж байна. Энэ хөтөлбөр амжилттай хэрэгжиж чадвал 10 жилийн дараа 200-300 долларт хүрэх боломжтой гэж энэ салбарыг хөгжүүлсэн бусад улсын жишгийг харахад бидэнд тодорхой загвар жишээ харагдаж байна. Тэгэхээр 1 ёсондоо хөдөө аж ахуй ялангуяа мал аж ахуйн салбарт илүү либерал бодлогыг хэрэгжүүлж, иргэд, малчид өөрсдийнхөө өмчлөлийн малыг нэмүү өртөг шингээх тэр хөрөнгө оруулалтыг хийх боломжийг нь нээж өгснөөрөө асуудал шийдэгдэнэ ээ гэж үзэж байгаа юм.

Тэжээлийн аж ахуй мөн адил. Хувийн аж ахуйн нэгж, хувьчлаад авчихсан байгаа аж ахуй хоршоо байгуулаад тэжээлийнхээ аж ахуйг эрхлэх, хөрөнгө оруулалт хийх боломжийг ийм хэлбэрээр нээж өгч байгаа юм. Ингэснээрээ малчид сумаараа, багаараа өвс тэжээлээ бэлтгэдэг байх, малдаа нэмүү өртгийг шингээх тэр боломжийг нь гаргаж өгнө.

Л.Мөнхбаатар: Булганы Бейсен гишүүн тодруулж асууя. 1 минут.

Б.Бейсен: Би бол энэ 22, 23, 24 онд УОК, Монгол Улсын Засгийн газар, Хөдөө аж ахуйн яамнаас хэчнээн тэрбум төгрөгийн зардал гарсан. Түүрүүн нэг 3,5 их наяд төлөвлөж байна гэж сонссон уу, үгүй юү. Би гол нь энэ манайхаас чинь их цас орж байгаа тэр Казахстаны юун дээр чинь хаашаа бол ер нь орон сууц, хаашаатай малчдын битүү хаашаатай байж, хэдэн хоногийн шуургыг давж, цасан шуурга давчихдаг. Манай энэ зурагтаар харж байхад нэг сараалж хаашаа л байгаа биз дээ. Тэгээд цасанд дарагдчихаад байна. Тэр эсгий гэр байна. Зарим нь зүгээр нэг гялгар ууттай малын юунууд байна. Энэ ёстой, үүнийг хэзээ ч тэсэхгүй. Байнгын тийм юмтай болчихвол хөнгөлөлттэй зээл юм уу, буцалтгүй тусламжийн хөтөлбөр юм уу, тэр Засгийн газрын барьж байгаа бодлогыг дэмжиж байна л даа.

Тийм учраас тийм тодорхой хэмжээний юмтай болохгүй бол болохгүй байх гэж бодож байна. Сая нөгөө хэчнээн хэмжээний ... /минут дуусав/

Л.Мөнхбаатар: Тодруулгад хариулъя. Амарбаясгалан сайд хариулъя.

Д.Амарбаясгалан: Монгол Улсын Засгийн газар малчдаа чинээлэг малчин байлгах бодлогыг үндсэндээ барьж байгаа гэж хэлж болно. Ингэхийн тулд бизнес эрхлэх, анхан шатдаа өртөг шингээх тэр боломж нөхцөл бүрийг нээлттэй болгож өгч байгаа гэж ингэж ойлгоно. Ер нь цаашидаа мал аж ахуйн салбарыг аль болох чөлөөлж өгснөөр үр дүн, эдийн засагт үзүүлэх нөлөө, мал дээр амьдарч байгаа малчин өрхийн амьжиргааны түвшин дээшлэх, тэр битгий хэл залуу үе хөдөө мал дээр хоршиж бизнес эрхэлж, илүү сайн сайхан амьдрах боломжийг нь нээж өгөх хөтөлбөр гэдэг талаасаа энэ асуудлыг харах нь зүйтэй гэж ингэж бодож байна.

2 дахь асуудал. Энэ УОК-ын зүгээс цас зудын нөхцөл байдалтай холбогдуулж Онцгой комисс тодорхой зардал мөнгө гаргаж ажилладаг. 2024 оны тухайд яг мал аж ахуйн салбарт зориулж цас зудад зориулж, 20 орчим тэрбум төгрөг зарсан байна. Байгаль цаг уурын төлөв байдлыг тодорхойлох зорилгоор улсын нөөцөөс 10 орчим тэрбум төгрөгийг гаргаж, урьдчилан мэдээг бодитоор гаргаж авч байх тоног төхөөрөмжөөр Монгол Улсын газар нутгийн зохистой байрлалд байрлуулах ийм шийдвэрийг гаргасан. Үндсэндээ 24 оны зудтай холбоотойгоор УОК-оос 30 орчим тэрбум төгрөг гараад байна гэж.

Л.Мөнхбаатар: Балжиннямын Баярсайхан гишүүн асуултаа асууя.

Б.Баярсайхан: Баярлалаа. 2030 он гэхэд дэлхийд болох байгалийн гамшигт томоохон үзэгдэл 40 дахин нэмэгдэнэ гэж бараг 2 жилийн өмнөөс энэ дэлхийн цаг уурын шинжээчид мэдэгдэж эхэлсэн. Тэгээд яг энэ асуудлын тод жишээ нь өнөөдөр Монгол Улсад нүүрлэсэн зудын асуудал байлаа гэж ингэж харж байгаа.

Өнөөдөр бид 70 сая малтай мөртөө дөнгөж тавхан хувийг экспортод энэ малынхаа ашиг шимийг гаргадаг ийм улс орон. Малчдын өмнө тулгарсан маш олон асуудлууд байна. Залуу халаа тасрах, хавар намартаа нэг 2 удаа идэи тэжээлийн цагаар, ноос ноолуурын цагаар хоёрхон удаа орлого олдог. Гэтэл энэ жилийн цас зудад нэрвэгдсэн энэ айлууд, малчидтай уулзаад явж байхад ямааны махаа 1кг-ыг нь 3500 төгрөгөөр дөнгөж, хонины махаа нэг 5000 төгрөгт хүргэсэн. Гэтэл яг үүнийг хэрэглэж байгаа Улаанбаатар хотын хэрэглэгчид нь 1кг махыг 15 мянгаас 17 мянган төгрөгөөр авч байгаа гээд олон асуудлуудыг нь зохицуулах шаардлагатай гэдгийг харуулж байна.

Тэгээд ялангуяа энэ тэнгэрийн ааши занг харж амьдардаг энэ малчдын маань хувьд энэ цаг уурын өөрчлөлт бол бүр илүү

их гол нөлөөлөх хүчин зүйл гэж ингэж харж байна. Тэгээд надад 3 асуулт байна.

1 дүгээрт нь, энэ Монгол Улсын Ерөнхийлөгчийн хэлээд байгаа бид далайд гарцгүй ч хүнэн гарцтай гэж ярьж байгаа. Хөрш орнуудад маань манай малын амт шимтэй сайхан Монгол малын махыг авах хөршүүд бол байгаа, улс орнууд байгаа. Гэтэл бид нар стандарт гэдэг зүйлийг нь хангахгүй байгаа. Тэгээд энэ хууль батлагдсанаараа бид нар энэ стандартын шаардлагыг бид нар хангаж, бид нарын экспорт нэмэгдэх ийм бодит үр дүн харагдаж байна уу гэдгийг асууя.

2 дугаарт нь, яг саяын миний ярьсан дотооддоо малчдын гараас арай үнэтэй малын махыг авч, нийслэлийн иргэдэд бас арай хямд махыг хангах. Энэ зөрөөг ойртуулах уу.

3 дугаарт, энэ Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль байгаад байгаа юм. Одоо мөрдөгдөж байгаа хуулиар малчдыг хоршоонд нэгтгэхгүй байх шалтгаан нь ерөөсөө энэ НӨАТ-ын хууль дээр байгаад байгаа. Энэ дээр малчин болон мал бүхий этгээдийн борлуулсан түүхий эдийг татвараас чөлөөлсөн ч гэсэн энэ хоршоонд нэгдэж байгаа малчид маань нийтдээ хоршоогоороо дамжуулаад 50 сая төгрөгийн борлуулалт хиймэгц хоршоо нь НӨАТ төлөгч болчихоод байгаа.

Тийм учраас сар бүр НӨАТ-ын тайлан гаргах дарамт, энэ НӨАТ-ын энэ татварт малчид маань туйлдаж байгаа учраас энэ түүхий эдийг борлуулах гол саад учруулдаг гэж ингэж үздэг. Тэгэхээр энэ хоршоодыг дэмжих чиглэлээр энэ батлагдах хуульд холбогдох хуулиудад бас нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай гэж ингэж үзэж байна. Ингээд энэ 3 асуултад хариулт авъя. Баярлалаа.

Л.Мөнхбаатар: Баярсайхан гишүүний асуултад хэн хариулж байх вэ? Болорчулуун сайд хариулах уу? Болорчулуун сайд хариулъя. Хэн хариулах вэ? Болорчулуун сайд хариулж байх уу? Болорчулуун сайд хариулж байя. Ажлын

хэсгээс хариулах юм уу? Амарбаясгалан сайд хариулъя.

Д.Амарбаясгалан: Энэ малчид анхан шатдаа өртөг шингээх боломжийг бүрдүүлэх зорилготойгоор өнөөдрийн хуулийн төсөл бас хөрөнгө оруулалтын зээл олгох хэлбэрээр орж ирж байгаа. Энэ асуудал үндсэндээ стандартад шаардлага хангасан бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хийх, дотоодын хэрэгцээг хангах, цаашилаад экспортод гарах, нэгдэх боломжийг гаргаж авах боломжтой гэж үзэж байгаа юм.

2 дугаарт, дотоодын нийлүүлэлтийн тогтвортой байдлыг хангаж чадна. Монголчуудын хувьд намар 10, 11 сард мах нядалж, шинэ мах зах зээлд нийлүүлдэг. Бусад бүх саруудад шинэ экологийн эко махыг хэрэглэх боломж жишээ нь бүрддэггүй. Яг энэ нөхцөл байдлаас хамаараад жишээ нь махны үнэ жилийн 4 улирал өөр өөр өндөр үнэ өртөгтэй байдаг нөхцөл тодорхой бий болчихсон.

Тэгэхээр анхан шатдаа ийм хэлбэрийн үйлдвэрлэлийг тогтвортой тогтмол эрхлээд ирэхээр махны нийлүүлэлт бол жишээ нь тогтмол, үнэ ханш тогтвортой байх нөхцөлийг хангаж чадаж байгаа.

2 дахь зүйл нь, ганц мах гэлтгүй ер нь малын түүхий эд, арьс шир, бүтээгдэхүүн анхан шатдаа тордолт, тодорхой хэмжээний анхан шатын боловсруулалт хийх боломж нь бүрдэж чадна. Үүнийгээ хийгээд эхлэхээр энэ түүхий эд бүтээгдэхүүн зах зээл дээр гарах, дараачийн шатын үйлдвэрлэлд шилжих, нэмүү өртөг шингэх, экспортод гарах нөхцөл шаардлагуудыг хангаж ирнэ.

Өнөөдөр Монгол Улсын Засгийн газрын зүгээс түүхий эд, арьс ширийг экспортод гарах хориг тавьчихсан байсан зүйлийг бол чөлөөлчихсөн байгаа. Гэсэн хэдий ч манай урд хөрш, хойд хөрш шууд импортоор авах гарцыг нээхгүй байгаа юм. Шалтгаан нь анхан шатын

боловсруулалт хийгээгүй байна, нян бактерийн устгал хийгдээгүй байна гэдэг асуудал энэчээ яригддаг.

Тэгэхээр энэ бүх зүйлийг анхан шатдаа хийж хэрэгжүүлэх боломж нь бүрдэнэ ээ гэж ингэж үзэж байгаа.

НӨАТ-ын асуудлыг бид бас их болгоомжтой хандах ёстой гэж ингэж үзэж байгаа. Сангийн яамны зүгээс НӨАТ-тай холбоотой бодлогыг хэрэгжүүлэхдээ аливаа нэг салбарыг онцгойлж авч үзэхээс илүүтэй энэ тогтолцоог гажуудуулахгүй байх бодлогыг барих нь зүйтэй гэж ингэж үздэг. Тэгэхээр яг Сангийн яам аль салбар дээр НӨАТ-ын чөлөөлөлтийн асуудал хөндөгдөх нь эдийн засагтаа сөрөг нөлөөлөл үзүүлэхгүй вэ гэдэг энэ бодлогыг гаргасны үндсэн дээр Засгийн газар үе шаттай хэрэгжүүлэх боломжтой гэж үзэж байгаа.

Л.Мөнхбаатар: Тодруулах уу. Балжиннямын Баярсайхан гишүүн тодруулж асууя.

Б.Баярсайхан: Энэ цас зудын үеэр малчидтайгаа уулзаад явж байхад өнөөдөр мал ахуйн салбарыг өөрчлөх үндэсний шинэ бодлого зайлигүй хэрэгжүүлэх ёстой. Цаашидаа бол ингээд бид нар туйлдаад амь нас, эрүүл мэндээ ч гэсэн дэнчин тавиад ингээд амьдрах боломжгүй, бэлчээрийн хувьд ч гэсэн нөөцгүй гэдгээ хүлээн зөвшөөрч Засгийн газраас өөрчлөлт, шинэчлэлт хийхийг бол хүлээж байгаа. Тэгээд би энэ малчдыг төлөөлж бас төрийн түшээгээр ажиллаж байгаа хүний хувьд сая энэ цас зудын байдлаар шуурхай ажиллаж, малчдад тусламж дэмжлэг үзүүлсэн Монгол Улсын Засгийн газарт баярлаж, талархсанаа бас илэрхийлж байна. Хамгийн гол нь нэг удаагийн ажил болгоод орхихгүйгээр үндэсний хэмжээнд мал аж ахуйн салбарыг өөрчлөх, шинэчлэх, хөгжүүлэх ийм хуулийн төслийг маш маш богино хугацаанд боловсруулж ингэж орж ирж байгаад баяртай байна. Тэгээд энэ хуулийн төслийг дэмжиж байна.

миний тодруулах асуулт л энэ хоршоодыг энэ хууль батлагдсан ... /минут дуусав/

Л.Мөнхбаатар: Болорчулуун сайд энэ асуултад хариулчихъя.

Х.Болорчулуун: Баярсайхан гишүүний асуултад хариулъя. Энэ хоршооны хууль батлагдсанаараа малчдын чанарт өөрчлөлт орох уу, ялангуяа мал махны борлуулалтад чанарын өөрчлөлт орох уу, олон улсын шаардлагыг хангах уу гэсэн асуудлыг тавьж байна. Тийм ээ.

Тэгэхээр ер нь хоршоолсноороо малчид маань тэжээлээ, ногоон тэжээлээ нэгдэж нийлж тарьдаг болох, тэжээлээ хамтдаа бэлтгэдэг болох ийм боломж нь улам бүр бүрдэж ирэх юм. Ер нь Монгол Улс гадагшаа мах экспортлохдоо дэлхийн стандартын шаардлагыг одоогоор үнэхээр үндсэндээ хангаж чадахгүй байгаа.

Тийм ч учраас нийт гаргаж байгаа махныхаа 80 хувийг Хятад улс руу 80 градус чанах байдлаар гаргадаг. Энэ үнийн хувьд бол хямдхан 3,5-4 доллар байдаг. Түүхий мах нь бол бүрд 3 доллар байдаг. Гэтэл олон улсын чанарын шаардлага хангасан тэр нэг шүүрхийгээр нь идэх боломжтой тийм шаардлага хангасан эрүүл гэдэг нь баталгаажсан мах 6-8 долларын дундаж үнэтэй байдаг ийм олон улсын жишиг байна.

Тэгэхээр бид нар цаашидаа бол малчдынхаа мал махны борлуулалтын үнийг өсгөх, экспортлох энэ боломжийг л төр биелүүлэх ёстой, хангах ёстой. Үүний тулд ХХААХҮЯ, Мал эмнэлгийн газар бол мал эмнэлгийн дэглэм бүхий эрүүл бүс, тусгаарлагдсан аж ахуйг байгуулах Засгийн газрын тогтоол гарсан байгаа. Үүний дагуу бол ажиллаж байгаа гээд хэлэх байгаа. Энэ бол бидний цаашидаа мал махаа үнэтэй гадагшаа экспортлох, малчдын орлогыг нэмэгдүүлэх, тооны хойноос биш чанартай сайн мал мах бэлтгэж гарах гол арга зам юм гэдгийг хэлье.

Л.Мөнхбаатар: Улсын Их Хурлын гишүүн Дамдинсүрэнгийн Өнөрболор асуултаа асууя.

Д.Өнөрболор: Засгийн газраас оруулж ирж байгаа энэ хуулийн төслийг бол дэмжиж байгаа юм. 4 сарын эхний байдлаар улсын хэмжээнд нийт 6,3 сая мал хорогдсон байна. Нийт малын 9,6 хувийг эзэлж байгаа юм байна. Тэгэхээр ер нь бол мал аж ахуйн салбарт гамшиг тохиолджээ гэж бол үзнэ ээ. Энэ мэт энэ гамшиг өнөөдөр зуд зурхны нөхцөл байдлаас 13 удаа тохиолдсон байх юм байна. Тэгээд цаашид ер нь энэ байгаль цаг уурын нөхцөл байдлаас шалтгаалаад цаашидаа ч энэ эрсдэл үүсэж явна.

Тэгэхээр энэ нийт ажиллах яг энэ салбарт хүчний 21,6 хувь, ДНБ-ий 10,5-хан хувийг үйлдвэрлэж байгаа юм байна. Гэтэл манайхтай адилхан улс орнуудын хувьд бол ДНБ-ий бүтээмж бол бараг харьцуулиггүй тийм өндөр байна. Энэ агуулгаараа энэ гишүүдийн яриад байгаа ер нь цаашид үндэсний хэмжээний реформын шинжтэй энэ зохицуулалтуудыг цогцоор нь авч хэрэгжүүлэх нь чухал юм байна гэдэгтэй санал нэг байна.

Нөгөөтээгүүр энэ 3000-аад малын хорогдолтой малчин өрхийн асуудал байгаа. Тэгэхээр энэ асуудал дээр яг тухайлсан ямар арга хэмжээг авч хэрэгжүүлж байгаа юм бэ? Яг иргэдтэй, малчидтай ингээд газар дээр нь уулзалт хийгээд зохион байгуулаад явахаар үндсэндээ нөхөн төлбөрийн асуудлаас гадна энэ өвс тэжээлээс гадна тийм ээ, илүүтэй ер нь энэ малчин өрхийг малжуулах асуудал аягүй чухал асуудал байна гэж санал хэлээд байна л даа. Тэгэхээр энэ тал дээр яг тухайлсан яг ямар арга хэмжээ авч байна вэ гэдгийг асууя.

Нөгөөтээгүүр одоо яг энэ хуулиар энэ малчдын малын тэжээлийг тариалах газрын асуудлыг шийдэхээр орж ирж байгаа нь маш чухал асуудал. Гэхдээ

Амараа дарга аа, би нөгөө энэ хуулийн нэршил юм уу нэр томъёо дээр нь ер нь анхаарахгүй бол болохгүй юм байна гэсэн саналтай байгаад байна л даа. Яагаад гэхээр энэ уламжлалт мал аж ахуйд тулгамдсан асуудал гээд ороод ирэхээр ер нь малчин өрх хэр нь, энэ газар тариалангийн бүс нутагт эрчимжсэн мал аж ахуй эрхэлж байгаа улсууд нь яах юм бэ.

Энэ эрчимжсэн мал эрхэлж байгаа малчдын малын тэжээлийн газрын асуудал бас л энэ хуулийн гадна үлдэх нь ээ. Саяхан энэ өнгөрсөн 7 хоногт Малчин өрхийн холбооны эрх зүйн байдлын тухай хууль орж ирсэн. Би бас л энэ асуудлыг хөндөж хэлсэн. Өөрөөр хэлэх юм бол эрчимжсэн мал аж ахуй эрхэлж байгаа энэ малчдын асуудал үндсэндээ гадна үлдээд байна. Гэтэл малчдын амьжиргааг дээшлүүлнэ ээ гэдэг бол угаасаа малын ашиг шимийг сайжруулж байж л амьжиргаа нь сайжирна гэсэн асуудал байгаа шүү дээ. Энэ малын ашиг шим сайжруулахын тулд бол хагас эрчимжсэн ч байдаг юм уу, эсвэл эрчимжсэн мал аж ахуйтай уялдаж бодлогоо зохицуулах асуудал байж байгаа.

Тэгэхээр энэ тэгээд энэ малын тэжээлийг тариалах энэ арга туршилага ер нь тариалангийн бүс, тэр дундаа үйлдвэрлэл талдаа аваад үзэх юм бол энэ нэн ялангуяа тариалангийн бүс, төвийн бүсээс илүү гаргах боломжтой байгаад байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ малчид, малчин өрхүүдийн асуудлыг орхигдуулмааргүй байна. Ер нь ингээд хуулийн гадна жсоохон орхигдчих гээд байгаа нөхцөл байдал ингээд сүүлийн үед ингээд ажиглагдаад байна.

Тэгэхээр энэ дээр нийт малчин өрхийн асуудлыг ишийдэж байгаа бол эрчимжсэн мал аж ахуйг эрхэлж байгаа энэ газар тариалангийн бүсэд тийм ээ, үйл ажиллагаа явуулж байгаа улсуудын асуудал, эрх ашгийг бас давхар ингэж авч явах нь бол чухал байна гэж бол харагдаж байна л даа.

Нөгөөтээгүүр Амарбаясгалан сайдын энэ эрсдэлийг даатгуулах асуудалтай би санал нэг байгаад байгаа. Гэхдээ нөгөө малчдын эрсдэлийг бууруулах, эрсдэл даах чадварыг нь нэмэгдэх тухай асуудал байгаа болов чиг энэ малын индексжүүлсэн даатгалд хамруулаад ингээд орхих асуудал биш байгаа байгаад байгаа байхгүй юу.

Л.Мөнхбаатар: Асуултад хариулъя. Амарбаясгалан сайд хариулъя.

Д.Амарбаясгалан: 2024 оны улсын төсөвт Хөдөлмөрийн хамгааллын сайдын багцад Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан дээр төсөв батлагдсан байгаа. 107 орчим тэрбум төгрөг байдаг. Энэ мөнгөнөөс малгүй болсон малчин өрхийг малжуулах хөтөлбөрийг хэрэгжүүлэх зориулалттай бас одоогийн байдлаар 22 тэрбум зарцуулах боломжтойгоор явж байгаа. Мэдээж малаа 70 хувиас дээш алдсан малчин өрхийг малжуулах хөтөлбөр гэдэг бол зайлигүй тулгамдсан цаг үеийн асуудал болж таарна.

2 дахь асуудал бол энэ Шинэ хоршоо хөтөлбөр гэж өнөөдөр энэ уламжлалт мал аж ахуйд тулгамдаж буй уур амьсгалын өөрчлөлтөөс үүсгэж буй энэ сөрөг нөлөөллийг бууруулах зорилготой орж ирж байгаа хууль. Энэ хүрээнд бүх төрлийн малчин, мал бүхий иргэд энэ дээр хамрагдах бүрэн боломжтой. Гагцхүү хоршоонд нэгдэж, хамтдаа шинэ хөрөнгө оруулалт хийж, мал аж ахуйн салбарыг шинэ түвшинд гаргах зорилгыг л агуулах зорилготой. Өртөг шингээх, үйлдвэрлэл эрхлэх, мал нядлах, ноос ноолуураа боловсруулалт хийх, түүхий эдийг анхан шатын боловсруулалт хийх зэрэг нөхцөлийг бүрдүүлсэн тохиолдолд арилжааны банк өөрийн эх үүсвэрээс зээл олгох боломжтой.

Засгийн газар энэ ишийдвэр гаргалтад оролцоно. Цаашаа үйл ажиллагааг Зээлийн батлан даалтын сан, арилжааны банк, хувийн даатгалын компаниуд авч явах бүрэн

зохицуулалттайгаар энэ хийгдэж хэрэгжих боломжтой гэж ингэж үзэж байгаа. Би түрүүн хэлсэн, энэ зориулалтаар мал аж ахуйн салбарт хоршоо болж ажиллах нөхцөл боломжийг дэмжих зорилготойгоор 500 орчим тэрбум төгрөг орох боломжтой. Энэ нь түрүүн давтаж хэлэхэд арилжааны банкны өөрийн эх үүсвэрээр бий болох зээл юм л гэж ингэж тайлбарлая.

Тэгжээл тариалах энэ тэжээлээр бүс нутгаа, сумаа, багаа хангах тэр нөхцөл боломж маш их элбэг бий болсон байна. Өчигдөр Засгийн газраас зохион байгуулаад 21 аймагт хоршооны үйл ажиллагаа явуулж байгаа 160 орчим хоршооны төлөөллийг бас хүлээж авч уулзаж, туршилага солилцлоо. Хөтөлбөр танилцуулж, санал бас авсан байгаа. Ингээд харахад ногоон тэжээл тарьдаг, газар нутаг сум багаа ногоон тэжээлээр хангадаг хоршоод бас нэлээдгүй бий болсон байна. Гэхдээ мөн адил тэдэнд өнөөдөр хөрөнгө оруулалтын дутагдал байсаар байна. Хөрөнгө оруулалтын дутагдлаас болоод 1 га-аас авч байгаа ногоон тэжээлийн хэмжээ, ногоон тэжээлд нь зориулаад тарьж байгаа төрөл зэрэг хумигдалтай хомсдолтой хэвээрээ байна. Тэгэхээр энэ хөрөнгө оруулалтын боломж нээгдсэнээр уураг тэжээлийг хангалттай хэмжээнд тарьж ургуулах, бүс нутгаа хангах тэр боломж нөхцөл бий болно гэж ингэж харж байна.

Л.Мөнхбаатар: Ганзоригийн Тэмүүлэн гишүүн асуултаа асууя.

Г.Тэмүүлэн: Зарчмын хувьд би энэ байгаль, цаг уурын өөрчлөлттэй холбоотой, тэр дундаа бас сая өнгөрсөн өвлийн хугацаанд зудын хүндрэлийн нөхцөл байдал бас улс орны хэмжээнд үүссэнтэй холбогдуулаад Засгийн газраас оруулж ирж байгаа энэ зудын эрсдэлийг бууруулах арга хэмжээний тухай энэ хуулийн төслийг бол зарчмын хувьд бол дэмжиж байгаа. Би хувь хүн талаасаа ч гэсэн малчны тухай хуулийн төслийг тун удахгүй ер нь ирэх 1 дэх өдөр гэхэд өргөн барина. Энэ дээр ер нь бид нар цаашид бас

энэ бодлогын өөрчлөлт, хандлагын өөрчлөлтийг хийж, мал аж ахуйн салбарыг цаашид аливаа учирч болох энэ зуд болоод байгаль, цаг уурын эрсдэлээс хэрхэн хамгаалах вэ гэдэг дээр тодорхой бодлогын том суурь өөрчлөлт хийх энэ хуулийн төслийг өргөн барьж байгаа. Энэ дээр яг бас зориулаад ер нь зүгээр бид нар төрөөс малчдын энэ бас үйл ажиллагааг дэмжихтэй холбоотой хэрхэн ер нь зохистой дадлуудыг бий болгох юм. Цаашид ер нь банк, санхүүгийн байгууллагууд ч гэсэн мал аж ахуйн энэ үйл ажиллагаанд орж ирэхдээ бас ямар шалгуур, шаардлагыг харгалзаж, нэн хөнгөлөлттэй болон хөнгөлөлттэй зээл олгох юм, малжуулах төсөл хөтөлбөрт бас ямар малчид хамрагдах ёстой юм ч гэдэг юм уу тодорхой энэ шалгууруудыг бол бүр нарийвчилж зааж тусгайлж оруулж ирж байгаа.

Тэгэхээр бид нар бас тэр хүрээндээ яах вэ, аль аль хуулиудаа уялдуулаад ингээд явах нь зарчмын хувьд зөв байх гэж харж байгаа.

Би нэгд өөрөө Төсвийн байнгын хорооны даргын хувьд энд орсон 2 заалтыг зарчмын хувьд дэмжихгүй байна. Энэ 6.1.9. жилийн батлагдсан төсвийн нэгдсэн төсвийн нийт зарлагын хэмжээг нэмэгдүүлэхгүйгээр төсөв хоорондоо төсвийн ерөнхийлөн захирагч хооронд хөрөнгийн болон урсгал зардал хооронд төсвийн зохицуулалт хийх гэдэг энэ заалтыг бол нэгд дэмжихгүй байгаад байгаа юм. Яагаад вэ гэхээр яах вэ, төсвийн захирагч хооронд зохицуулалт хийлээ гэхэд хөрөнгө бол урсгал зардал хооронд төсвийн зохицуулалт хийх нь бол би хуулиараа хориотой асуудал.

Дээрээс нь хэрэв юу гэдэг юм. Энэ хуулийг хэрэгжүүлэхэд Төсвийн тухай хууль болон Тогтвортой байдлын тухай хууль зөрчилдвөл зөвхөн энэ нэг удаагийн энэ хуулиа дагаж мөрдөнө өө гэдэг заалт орж ирж байгаа юм. Тэгэхээр үүнийг би зүгээр Сангийн сайд байгаа, Сангийн яамныхан маань бас яг ямар байр суурьтай байгаа юм бэ? Би мэдээж энэ 5

их наяд гэнэ үү, эсвэл нэг жилд 1 их наядын эх үүсвэр шаардлагатай байвал бид нар түүнд нь зохицуулсан, таарсан зохицуулалтыг ер нь жоохон хийгээд явчхаж болохгүй юм уу? Нэг дор ингээд төсөв дээр өөрсдөө дотроо зохицуулалт хийх, хөрөнгө болон урсгал зардал хооронд зохицуулалт хийх, төсвийн ерөнхийлөн захирагч хооронд зохицуулалт хийх энэ заалт өөрөө энэ жил батлагдсан энэ 27 их наядын төсөв дотор бараг зохицуулалт хийх эрх үүсчих вий дээ. Цар тахлын үед бид нар яг энэ Засгийн газарт бол онцгой бүрэн эрхийг хийгээд, Улсын Их Хурал, Засгийн газар магадгүй шуурхай шийдвэр гаргаж чадахгүй ч гэдэг юм уу. Энэ нэн яаралтай худалдан авалт хийхэд л энэ хуулийг гаргаж байсан бол магадгүй энэ маань бас Ковид 2 гэсэн ийм нэг төсвийн хууль зохицуулалт хийх эрхүүдийг батлагдсан төсөвт зохицуулалт хийх эрхүүдийг Засгийн газарт бүрэн олгосон хууль болчих вий л гэсэн болгоомжлол байгааг байна.

Тэгээд энэ хууль нь энэ саяын тэр 6.1.9, 6.2 дахь заалтыг чинь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэл мөрдөнө гэж авч байна. Тэгээд яах вэ, магадгүй саяын тэр малжуулах болоод нэн хөнгөлөлттэй зээлтэй холбоотойгоор эх үүсвэр шаардлагатай гаднаас зээл тусламж авах гэж байгаа бол жишээ нь хугацаа нь заавал ч үгүй ийм 12 сарын 31 хүртэл байх шаардлагатай юм уу? Магадгүй сарын хугацаанд л зөвхөн мал аж ахуйтай холбоотой саяын Хөдөө аж ахуйн сайдын багцын хүрээнд гэдэг юм уу, эсвэл юу гэдэг юм Сангийн сайд багц дотроо ч гэдэг юм уу зохицуулалт хийх эрхийг нь өгөхгүй бол бид нар ер нь нийтдээ л ярьж байгаа зүйл чинь энэ төсвийн сахилга бат, хяналт, хариуцлага. Төсвийн зүйл заалт бүрээр Улсын Их Хурал баталж олон нийтийн хяналттайгаар баталдаг л гэдэг ийм зарчмуудыг л ярьж байгаа болохоос энэ маань Төсвийн тухай хуулийг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийг цаашилаад магадгүй Улсын Их Хурлын Үндсэн хуулиар олгогдсон онцгой эрхэд ч

гэсэн нөлөөлөх л асуудал үүсэх вий гэсэн болгоомжлол байгаа юм.

Л.Мөнхбаатар: Тэмүүлэн гишүүний асуултад Сангийн сайд Болдын Жавхлан хариулъя. Жавхлан сайдын микрофоныг өгөөрэй.

Б.Жавхлан: Тэмүүлэн гишүүний асуултад хариулъя. 6.1.9 дээр оруулсан заалт ер нь онцгой үед хэрэглэж явж ирсэн ийм практик л даа. Хамгийн ойрын жишээ гэх юм бол ковидын үед бид ийм заалттай ковидын хуультай 2 жил явсны үр дүнд энэ ковидын энэ том цар тахлыг бид маш эрсдэл багатайгаар давж ирсэн. Магадгүй энэ заалтууд байгаагүй бол 40 гаруй мянган, 50 гаруй мянган хүний амь эрсдэх ч ийм аюул байсан. Бусад Азийн орнуудын жишгийг харах юм бол. Бид төсөв дээрээ боломжтой үед цаг алдалгүй маневр хийж, шаардлагатай вакцины болон бусад онцгой үед санхүүжилтүүдийг цаг алдалгүй төрийн үйлчилгээг залгуулж ирсний үр дүнд өнөөдөр бид ковидоос аль эрт бусад улсуудаас өмнө салчхаад ингээд сууж байгаа юм.

Тэгэхээр энэ удаагийн энэ өвлийн зуд маань ковидоос дутахааргүй ийм гамшиг авчирч байгаа ийм зүйл болж байгаа. Энэтэй бид бүгдээрээ нүүр тулж байгаа. Тийм учраас бид нар заавал төрөөс онцгой нөхцөлд ийм арга хэмжээ авах шаардлагатай болж ирж байгаа. Мэдээж төсөв мөнгө хэрэгтэй болно.

Харин одоогоор төсвийн гүйцэтгэл маань яг төлөвлөснийхөө дагуу явж байна. Өөрөөр хэлбэл тодотгол хийх нөхцөл байдал хараахан үүсээгүй. Хууль маань өөрөө ийм маш нарийн заалттай. Үндсэн концепц нь төсөв мөнгө дутвал бид тодотгол хийдэг ийм тогтолцоотой. Харин энэ удаа бид нар энэ тогтолцоогоо эвдэлгүйгээр өөрөөр хэлбэл төсвийнхөө хөл дүнг эвдэлгүйгээр Их Хурлаар батлагдсан төсвийнхөө орлого, зарлага дотроо зарим сайд нар дээрээ хэмнэлт гаргах ийм байдлаар Хүнс, хөдөө аж ахуйн яамны ерөнхийлөн захирагч сайдын багц

дээр энд зориулсан зөвхөн энэ хуулийн зарцуулалтад зориулсан эх үүсвэрийг төсөв дотроо, төсөв дотроо шүү. Их Хурлаас баталсан төсөв дотроо ингэж зохицуулалт хийчихвэл хамгийн зөв юм болов уу гэж ингэж харсан юм. Яах вэ хөрөнгийг урсгал руу хийхгүй байж болно. Түүн дээр бол Тэмүүлэн даргатай би санал 100 хувь нийлж байна. Харин урсгалаас хэмнэлт хийгээд урсгал дээр нь өөр сайд дээр нэмж тавьснаар энэ байдлаа зохицуулах л ийм л заалт юм байгаа юм. Өөрөөр хэлбэл яг төсвийн хувьд тодотгол хийнэ гэдэг ч юм уу, тийм тогтворгүй байдал үүсэхээс зайлсхийж байна гэсэн үг. Өөрөөр хэлбэл Улсын Их Хурлаас баталсан ... /минут дуусав/

Л.Мөнхбаатар: Сангийн сайд Болдын Жавхлан гүйцээгээд хариулчихъя.

Б.Жавхлан: Тэр төсвөө л нэг ёсондоо хамгаалж байгаа юм. Цаг хугацааны хувьд 12 сарын 31 гэдэг нь маань ийм юм байгаа юм. Энэ бол нэг удаа хэрэгжээд дуусчих төсвөө, хууль биш. Энэ цаашаа үргэлжлээд явна. Тийм учраас 25 оноос цааш үргэлжлэхийг нь бол бид нар 25 оныхоо төсөв дээр тавиад явчихна.

Тийм учраас энэ жил гарах зээлүүд дээр, энэ жил гарах зээлүүд ч чинь одоо бол ингээд л гараад эхэлнэ. 4, 5 сараас гараад эхэлнэ. Энэ бүтэн жил гарна шүү дээ, 12 сарын 31 хүртэл гарна. Яах вэ 12 сарын 31 хэрвээ хол байвал 7 сарын 01 ч гэдэг юм уу, нааш нь татаж бол болно л доо. Энэ хугацаа тийм хатуу байх шаардлага байхгүй. 7 сарын 01 гэдэг ч юм уу ингээд татаж болно. Зарчмын хувьд төсвөө яг хөл дүнгээр нь барьж хамгаалаад, Улсын Их Хурлаас баталсан зарлагын дүнгээ өөрчлөлт оруулахгүйгээр бусад сайд нар бусад ерөнхийлөн захирагч нар дээрээ хэмнэлт хийх замаар энэ төслөө, энэ ярьж байгаа малчид руу чиглүүлж байгаа энэ арга хэмжээгээ амжилттай хийе ээ л гэж байгаа юм. Тийм, тийм санаа шүү.

Л.Мөнхбаатар: Тэмүүлэн гишүүн тодруулж асууя.

Г.Тэмүүлэн: Би зорилгыг нь бол ерөөсөө буруутгахгүй. Бид нар малжуулах гэнэ үү, тодорхой энэ мал юугүй болчихсон малчдыг дэмжих, тодорхой юу гэдэг юм төрөөс дэмжлэг тусалцаа үзүүлэх нэг бодлогын шийдэл гаргах зайлигүй шаардлагатай. Тогтвортой байдлын тухай хууль дээр би бас нэг ийм заалт байгаад байгаа байхгүй юу. Нөгөө 8 дугаар зүйлээр төсвийн тусгай шаардлагыг түр түдгэлзүүлэх тохиолдол гэж заачихсан. Хэрэв гамигийн аюулын хор уршиг, онцгой нөхцөл, үр дагаврыг арилгахад төсвөөс нэмж шаардах санхүүжилтийн хэмжээ нь тухайн ДНБ-ийн 5 буюу түүнээс дээш хэмжээнд хүрэхээр бол шууд хэрэглээд явчих фракц байгаад байгаа юм.

Тэгэхээр би магадгүй гамигийн хор хэмжээнд хэр хэмжээнд хүрчихсэн юм бол, үүнийг та тооцож үзсэн үү? Тийм бол энэ хуулиараа бас хийчхэж болоод байгаа юм.

Дээрээс нь би саяын таны хэлсэнтэй бол зөвхөн нэг удаагийн хуулиар төсвийн харилцааг зохицуулж болно гэж үзэж байгаад чинь бол санал нийлэхгүй байгаад байгаа юм. Яагаад гэхээр Төсвийн хуулиар чинь төсвийн тухай хуулийн 3.4 чинь төсвийг зөвхөн Төсвийн хуулиар зохицуулна гэдгийг бид нар чинь хуулийнхаа хүрээнд л ойлгож яриад байгаа шүү дээ. Тэгэхээр би нэг удаагийн хуулиар ингэж зохицуулах бол өөрөө буруу жишиг шүү дээ. Тэгэхээр би бол зарчмын хувьд ... /минут дуусав/

Л.Мөнхбаатар: Тэмүүлэн гишүүний асуултад хариулъя. Сангийн сайд Болдын Жавхлан.

Б.Жавхлан: Ер нь яах вэ, онцгой үед хэрэглэдэг ийм заалт учраас хэрвээ энэ хуулиа барихгүй бол бид нар зохицуулалт хийж чадахгүй болчихно. Тийм 6.1, 9 2-ыг оруулах шаардлагагүй болчихно л доо. Яг энэ хуулиа барихгүй бол. Тийм учраас яг онцгой үед төсөв дотроо төсвөө хэтрүүлэлгүйгээр Их

Хурлаас баталсан хөл дүндээ өөрчлөлт оруулахгүйгээр зохицуулалт хийх арга нь ер боломж нь ерөөсөө л энэ юм байгаа юм. Бусад үед мэдээж Төсвийн хуулиа бол бариад явалгүй яах вэ. Энэ удаа бол энэ барьж байж зохицуулалт хийхгүй бол тийм боломж байхгүй. Ийм зүйл заалт оруулах ч шаардлагагүй л болчхож байгаа юм л даа.

Тэр зээл, тусламжтай холбоотой зүйл бол огт байхгүй. Энэ дээр зээл тусламж авч юм уу, эсвэл одоо байгаа зээл тусламжийн хүрээнд бол шийдэх ийм зориулалтууд байхгүй байгаа.

Л.Мөнхбаатар: Яах юм тодруулах юм уу? Тэмүүлэн гишүүн тодруулж асууя.

Гишүүд ээ, ер нь асуудлаа шуурхайлна.

Г.Тэмүүлэн: Төсөв хооронд зохицуулна гэдэг ч энэ эрх чинь уг нь ганцхан улсын төсөв, орон нутгийн төсөв хооронд л зохицуулалт хийхээс гадна яах вэ, зүгээр Ирээдүй өв сан, Нийгмийн даатгалын сан хооронд л зохицуулалт хийнэ л гэсэн үг л болоод байгаа юм. Тэгээд би ер нь цаашид ямар суурь зарчим баримтлах вэ? Яах вэ, би зүгээр магадгүй 30, 40 тэрбум төгрөгийн санхүүжилт, энэ санхүүжилтийг босгоход, зээл тусламжийг босоход шаардагдаж магадгүй л дээ. Бид нар түүнийг жишээ нь өөр эх үүсвэрээр шийдвэрлэх гарц гаргалгаа гаргаж болохгүй юм уу, хэдүүлээ? Бас нэг заавал ч үгүй эсвэл зүгээр шулуухан бас нэг тодотгол хийгээд үүнийг хийж болж байна. Яг тухайн бага хэмжээний зардал дээр. Тэгэхгүй би 30, 40 гэдэг юм уу, одоо тэрбум байна уу, эсвэл 500 тэрбум төгрөгийн санхүүжилт босохоос үүнээс үүдээд 27 их наядын төсөв дээр энэ онд батлагдсан төсөв дээр өөр хооронд нь төсвийн ерөнхий захирагч хооронд зохицуулалт хийх том эрхийг нээгээд өгчих вий дээ. Дараа нь бас хариуц ... /минут дуусав/

Л.Мөнхбаатар: Өнөөдөр бол яах юм? Тодруулгад хариулах юм уу. Шаардлагатай юу? Өнөөдөр бол хэлэлцэх эсэх асуудлыг ярьж байгаа. Гэхдээ мэдээж энэ санхүүжилттэй холбоотой асуудал бол энэ хуулийн бас гол амин сүнс нь бол энд байгаа шүү дээ. Гол нь энэ санхүүжилтийн асуудлыг шийдэж байж л энэ хууль хэрэгжиж, энэ хуулийн бодит үр дүн гарна.

Тийм болохоор энэ асуудлыг нэг талаасаа шийднэ. Гэхдээ хууль, эрх зүйн хувьд бол бас ийм зохицуулалтыг нарийвчлан үзэх шаардлага бол байна. Ингэхээр Байнгын хороонд энэ хэлэлцэх эсэхийг нь шийдсэний дараа Байнгын хороонд шилжүүлнэ. Байнгын хороо дээрээ үүнийг энэ олон талаас нь сайн ярья. Энэ дээр Төсвийн байнгын хорооныхон, манай Улсын Улсын Хурлын Тамгын газрынхан бас Хууль зүйн хэлтсийнхэн бас тодорхой дүгнэлтүүд өгөөд, ингээд хамтарч ажиллах нь зүйтэй гэж үзэж байна.

Ингээд гишүүд асуулт асуусны дараа санал хураалт явагдана шүү. Гишүүд орж ирээрэй.

Жигжидийн Батжаргал гишүүн асуултаа асууя. Хэдүүлээ хэлэлцэх асуудал олон байгаа учраас жаахан шуурхай ярья.

Ж.Батжаргал: Баярлалаа. Хуулийн төслийг үзэл баримтлалынх нь хүрээнд дэмжиж байгаа юм. Хэлэлцүүлгийнх нь түвшинд бидэнд анхаармаар юмнууд байгаа. Сая манай зарим гишүүд ч асууж тодруулж, анхаармаар бас хууль хоорондын нийцэл хангамаар ийм зүйлүүд байна гэдэг юм яригдаж байна.

Тэгэхээр ерөөсөө энэ мал аж ахуйн салбарыг байгаль цаг уурын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эрсдэл даах чадамжийг хангах тухай асуудал бидний хамгийн нэг том зүйл байгаад байх шиг байна.

2 дахь зүйл нь ерөөсөө энэ мал аж ахуйн салбарыг өөрөө эдийн засгийн үр өгөөжтэй өрсөлдөх чадвартай салбар болгох тухай асуудал. Тийм учраас мал махыг эдийн засгийн эргэлтэд оруулах тэр гарц шийдлүүдийг нь их тодорхой болгох тухай асуудал. ХАА-н бүтээгдэхүүнийг бэлтгэн нийлүүлэх, боловсруулах түвшинг ахиулахад чиглэсэн бүхэл бүтэн сүлжээ тогтолцоог бий болгох тухай асуудлаар л дамжиж энэ өөрөө энэ МАА-н үйлдвэрлэлийн тогтвортой хөгжлийн асуудал яригдах ёстой юм. Энэ тал дээр энэ хэлэлцүүлгийн түвшинд нэлээн анхаарч, төсөл өргөн баригчийн талаас ч гэсэн энэ тал дээр ер нь яг чухам юу анхаарч, энэ хуульд тусгаж оруулав гэдэг асуудал байна. Малчид маань малынхаа тоо толгойг өсгөе гэж бодохгүй байгаа. Угаасаа тэр улсуудад ажиллах хүчний ч, бэлчээрийн ч аль аль талаасаа хомсдол хязгаарлалтууд нөлөөлөөд байгаа. Гэхдээ I малаас ашиглах ашиг шимийн хэмжээ буураад байгаа. Нэг.

Нөгөө талд үнэ цэнийн асуудлаас хамаараад тоо толгойн өсөлтөөр амьжиргаагаа хангах асуудал нь гол болчхоод энэ асуудал яваад байгаа.

Тийм учраас ер нь төрийн зүгээс бол энэ МАА-н салбарынхаа үр өгөөжийг дээшлүүлэх, эргэлтэд орох, тэгээд өрсөлдөх чадвартай ийм аж ахуй байх талынх нь бодлого зохицуулалт, энэ асуудлыг нь л хийх ёстой гэж би бол энэ талаас нь хараад байгаа. Энэ тал дээр ер нь ямар бодол байна гэж.

2 дахь зүйл. Монгол Улс бол яах аргагүй маш уудам өргөн нутаг дэвсгэртэй, байгалийн бүс бүслүүрүүд нь олон янз, эрс тэс уур амьсгалтай. Тийм учраас нэг загвараар бүгдийг хийх бас боломжгүй. Тэр нь бол үндсэндээ чадахгүйдээ биш болохгүйдээ байгаад байгаа юм. Тэгэхээр малын тэжээлийн тариалалт, үйлдвэрлэлийн асуудал бол магад ч үгүй зарим бүсдээ илүү давамгайлж, түүнийг нь бусад тэр болохгүй байгаа бүсүүд рүү нь хүргэх гэдэг юм уу, борлуулах замаар л асуудлаа

шийдэх ийм л гарц гаргалгаа байгаад байгаа.

Тэгэхээр зэрэг энэ тал дээр энэ малын тэжээлийн ургамлын тариалалт хийж болох энэ бүс нутгуудад ер нь бас нэг дахин судалгаа юмнуудаа хийж, тодорхой бүс талбайн хэмжээнийхээ асуудлыг тооцож, зөв шийдэх асуудал байна уу гэж ингэж хараад байгаа юм. Би бол.

3 дахь зүйл. Байгаль дандаа нэг янзаараа байдаггүй ээ. Тийм учраас өнтэй сайхан жилүүд үргэлжилнэ ээ. Энэ цаг үед өнөө малын тэжээлийн ургамал тариалж байгаа болон үйлдвэрлэл эрхэлж байгаа ААН-үүдийн чинь амьдрах амьжиргаа нь өөрөө асуудал үүсчихдэг юм. Өнөө бий болгосон тэжээл нь борлуулж өгдөггүй, алдагдалд орчихдог. Тэгэхээр энд бий болсон зүйлийг буцаагаад хэрэглэдэг тэр аж ахуйнуудыг нь дагуулж бий болгох ёстой. Энэ нь бордох аж ахуй байх ёстой. Тийм учир ... /минут дуусав/

Л.Мөнхбаатар: Хариулах юм уу. Ер нь бол яах вэ, хуулийн төслийн агуулгуудыг дэмжсэн бас хэлэлцэх явцад анхаарах зүйлүүдийг л хэлээд байх шиг байна шүү дээ. Тийм. Тогтохсүрэн дарга үг хэлэхгүй.

Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүн.

Дуламдоржийн Тогтохсүрэн гишүүн. Дуламдоржийн Тогтохсүрэн гишүүн асуултаа асууя.

Д.Тогтохсүрэн: Баярлалаа. Энэ МАА-н эрсдэлийг бууруулахтай холбоотой хуулийн төсөл орж ирсэн байгаа юм. Энэ их чухал хууль байгаа юм, тийм. Үзэл баримтлалын хүрээнд нь бол дэмжиж байгаа юм. Сүүлийн үед манай энэ ган зудын давтамж чинь их ойрхон болчихсон байхгүй юу. Өмнө нь нэг 5-8 жил, 8-12 жилийн хооронд ган, зудын байсан юм, давтамж нь. Гэтэл одоо 2-4 жил болчихсон байхгүй юу, давтамж чинь өөрөө. Тийм учраас энэ МАА-н эрсдэлийг

бууруулахтай холбоотой асуудал чухал байгаа юм.

Энэ жилийн хувьд бол ийм байхгүй юу. Энэ зүүн 3 аймаг, Архангай аймаг, Төв аймаг, Завхан эд нар чинь зуд биш байхгүй юу. Гамшиг байгаа байхгүй юу. Тийм. Цаашидаа бид нар ер нь энэ тодорхой эрх зүйн хүрээндээ гамшигийн үед яах юм, зудын үед яах юм гэдэг ийм юмнуудыг эд нар тооцож үзмээр байгаа юм. Хараад байхад бол яг гамшиг харагдаж байгаа байхгүй юу. Тийм.

Тийм учраас Засгийн газраас энэ гамшигийн эрсдэлийг бууруулах, цаашид МАА-н үйлдвэрлэлийг өөрчлөх зорилгоор энэ хуулийн төслийг орж ирж байгаа юм. Гол үзэл санаа нь бол би ойлгохдоо нөгөө малчдыг хоорондоо хорших, нэгдэх, хамтрах энэ чиглэлийг дэмжсэн ийм хууль байгаа юм. Энэ их чухал ач холбогдолтой. Ер нь манай малчид бол ингэж байж л бид нар энэ зудын эрсдэл, гамшигийн эрсдэл, цаашидаа МАА-н үйлдвэрлэл өрхийн үйлдвэрлэл болж чадах байхгүй юу. Тийм учраас энэ хоршоогоороо дамжихаас өөр арга байхгүй ээ. Би зүгээр энэ хүмүүс нэг өөр өөр юм бодоод би Жавхлан сайдаас нэг зүйлийг асууя гэж бодоод байгаа юм.

Сая Засгийн газар шийдвэр гаргасан. Малчдын зээлийг хойшлуулах, тэр дотроо 25 хувийг нь өөрсдөөс нь төлүүлэх хойшилсон хугацааны хүүг нь, үндсэн зээлээ хойшлуулаад, зээлийн хүүгийнх нь 25 хувийг өөрөөр нь төлүүлээд, 75 хувийг нь төрөөс гаргая гэдэг ийм Засгийн газрын тогтоол гарсан байна лээ. Тэр түрүүн хүмүүс тэр Төсвийн хуультай холбоотой асуудал яриад байна. 6.1.9-ийг би үүнийг зохицуулах гэж оруулж ирж байгаа заалт болов уу гэж бодож байна. Тэгэхээр Жавхлан сайд нэг тоо хэлчихмээр байгаа юм. Өөрөөр хэлбэл одоо энэ гишүүдийн яриад байгаа тэр 6.1.9, 6.2 хоёрыг оруулж байгаагийн ач холбогдол нь яг энэ зохицуулалтаараа хэдэн төгрөгийн зохицуулалт хийх гээд байгаа юм бэ. Зээлийн хүүгээс өөр зохицуулалт байгаа юм уу, үгүй юү гэдгийг л хэлээд өгчихмөөр

байгаа юм. Тэгэхгүй зарим нь бараг л мөнгө тараах гэж байгаа юм шиг ойлголт ойлголтууд бий болоод байгаа байхгүй юу.

2 дахь асуудал хоршоотой холбоотой 2 хуулийг ууланд би орж ирнэ гэж бодсон чинь орж ирээгүй байх юм, Амараа дарга аа. 1 дүгээрт нь энэ Нэмэгдсэн өртөг албан татварын тухай хууль байгаа байхгүй юу. Одоо Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль дээр хувь малчин өөрөө түүхий эдээ ингээд борлуулбал, үйлдвэрт өгвөл НӨАТ-аас чөлөөлөгддөг юм. Хоршоогоор өгвөл чөлөөлөгддөггүй байхгүй юу.

Тэгэхээр хоршоонд нэгдэх сонирхолгүй байгаад байгаа байхгүй юу. Үндсэн. Тэгээд би энэ хуультай хамт би НӨАТ-ын хууль орж ирэх юм байна гэж бодсон чинь НӨАТ-ын хууль байдаггүй ээ.

2 дахь юм, энэ ЖДҮ-лэлийг дэмжих тухай хууль орж ирэх ёстой юм. Яасан гэхээр борлуулалтын орлого нь 5 тэрбумаас дээш байгаа тохиолдолд, доошоо байгаа тохиолдолд ЖДҮ-ийн сангаас зээл өгдөг байхгүй юу. Тэгээд хоршоонууд зээл авахын тулд бүгд л 5 тэрбумаас доошоо ихэнх нь байгаа. Гэтэл одоо нөгөө төрөөс дэмжээд, зээл өгөөд ирэхээр зэрэг хүссэн, хүсээгүй борлуулалтын орлого нэмэгдэх байхгүй юу.

Тэгээд борлуулалтын орлого 5 тэрбумаас дээшээ болохтой нь зэрэг ЖДҮ-ийн сангаас зээл авч чадахгүй болчихоод байгаа байхгүй юу, хоршоо. Тийм, энэ 2 хуулийг би уг нь дагалдаад ороод ирчихсэн бол хоршооныхоо хөгжилд ч хэрэгтэй. Малчдынхаа ирээдүйн юунд ч хэрэгтэй ийм байсан юм. Тэгээд явцын дунд оруулж ирэх үү. Үүнийг эсвэл Байнгын хороо санаачилж болохгүй дээ, үүнийг одоо. Уул нь үүнийг л оруулж ирэх ёстой байсан юм. Би бас энэ талаар бас асууя гэж бодож байгаа юм. Баярлалаа.

Л.Мөнхбаатар: Тогтохсүрэн гишүүний асуултад хариулъя. Сангийн сайд Болдын Жавхлан хариулъя.

Б.Жавхлан: Баярлалаа. Тогтохсүрэн гишүүн ээ. Ийм юм байгаа юм. Одоо энд ерөнхийдөө нэг 2 асуудал яригдаад байгаа шүү. Малчдын ер нь амь амьжиргаатай холбоотой. Тоогий дарга аа. Наадах чинь 2 асуудал яригдаад байгаа байхгүй юу.

Нэг нь энэ хуулиар зохицуулагдах хоршоодыг зээлжүүлж, түүгээр дамжиж одоо малгүй болсон, зудад нэрвэгдсэн малчдаа малжуулах ийм хөтөлбөр явах нь ээ. 1-д.

2-т, одоо малгүй болоод, зээлийн төлбөрийн чадваргүй болчихсон байгаа малчид дээрээ энэ жил зээлийнх нь хүү дээр нь хөнгөлөлт өгөх асуудал байгаа. Энэ бол энэ хуулиас гадуур байхгүй юу. Хуулиас гадуур юм байгаа юм.

Тэгэхээр яг энэ хуулиар зохицуулах гэж байгаа би дүнг хэлье. Ийм гэсэн үг. 100 тэрбум төгрөгийн зээл гарлаа гэж бодъё. Тэгэхэд 17, 18 хувь, 20 хувийн хүүтэй байлаа гэхэд 14 хувийг нь улсаас хөнгөлөө гэхэд хагас жил тийм үү, хагас жил явна шүү дээ, энэ жил. Тэгэхэд 7 тэрбум. 100-аас 7 тэрбум төгрөг гэсэн үг. 200 тэрбум гарах юм бол 14 болох юм. 300 тэрбум гарах юм бол 21 тэрбум болох, 400 тэрбумын зээл гарах юм бол нэг 28 тэрбум төгрөг гарах нь байна шүү дээ, улсаас. Гэтэл энэ зээл чинь бүтнээрээ нэг өдөр гарахгүй. Одоо тэр хоршоод нь бэлэн биш байна. Таны хэлж байгаагаар малчдааа үүнийгээ ойлгуулах хэрэгтэй. Хоршоожно, тийм зээлдэгч нар бий болно гэсэн үг. Тэгээд банканд хандана. Авах гэсээр байтал энэ чинь бас хугацаа өнгөрөх байхгүй юу. Тэгээд магадгүй 5, 6 сараас эхний зээлүүд л гарч ирж магадгүй. Ер нь бол яг бөөн санхүүжилт нь 3, 4 дүгээр улиралд л гарна. Бараг 4 дүгээр улирал руу очих болов уу.

Тэгэхээр тэр 100 тэрбум чинь бөөндөө гарахгүй, тэр зээлийн хүү ч бөөндөө гарахгүй. Тэгэхээр хамгийн дээд

тал нь яг энэ хуулиар зохицуулагдах нь бол нэг 28 тэрбум орчмын ийм зохицуулалт хийгдэнэ. Тэгвэл үүнийгээ Болорчулуун сайд өөрийнхөө төсвөөс гаргачхаж болдоггүй юм уу гэж асууна. Гэтэл Болорчулуун сайд маань одоо байгаа мөнгөн дээрээсээ эхлээд нөгөө одоо зээл нь муу ангилалд ангилагдах гээд малгүй болчихсон, төлбөрийн чадваргүй болчихсон байгаа малчдааа зохицуулалт хийхийгээ одоо байгаагаасаа гаргачихна. Тэгэхээр энэ хуулиар зохицуулах л зээлд мөнгө нь хүрэхгүй байгаа байхгүй юу.

Тийм учраас өөр сайд нар дээрээсээ засаг дотроо ярьж байгаад, хэмнэлт хийгээд, зарим нэг юмыгаа хойш нь суулгаж байгаад, ингээд л энэ салбарын сайд руу нь зохицуулалт хийх ийм л зорилготой юм байгаа юм. Тэр төсөөлөөд яриад байгаа шиг хэдэн 100 тэрбум төгрөгийн мөнгө тараагаад л, гар дээр нь мөнгө тавих гээд байгаа тийм юм огт байхгүй. Энэ хуулийг унших юм бол маш ойлгомжтой байгаа. Баярлалаа.

Л.Мөнхбаатар: 3 гишүүн асуулт асуусны дараа санал хураалт явагдана. Гишүүд танхимд орж ирээрэй. Санал хураалтыг үргэлжлүүлэн явуулна.

13 цаг болсон байна. Цайны цаг болсон байна. Гэхдээ хуулийн төслийг үргэлжлүүлэн хэлэлцүүлэхээр шийдлээ. Чуулганы нэгдсэн хуралдааныг үргэлжлүүлье.

Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүн асуултаа асууя.

Б.Бат-Эрдэнэ: Хуулийн төслийг дэмжиж байгаа юм. Би Байнгын хорооноос хандаж, би нэг асуулт асуух гээд байгаа юм. Байнгын хороо хэлэлцүүлгийн явцдаа юу гэж үзсэн юм бэ гэж.

1 дүгээрт, би хэлэх зүйл бол энэ удаагийн Улсын Их Хурал, Засгийн газар энэ авлига, хулгайтай хийх тэмцлийг бидний олон жил энэ Их Хурал дээр шаардсан энэ ажлыг бодит үйл хэрэг

болгоод ингээд бүх юмыг ил тод, шилэн, толин ард иргэдийн мэдэх эрхийг хангаж, үүнтэй зэрэгцүүлээд энэ бас л мөн бид нарын олон жил энэ Их Хурал дээр шаардсан ажил энэ баялгийн хуваарилалт, энэ Монгол хүн баялагтаа эзэн байх энэ эрхийг хангаж ажиллаж чадсаны үр дүнд өнөөдөр төлбөр тэнцэл ашигтай, эдийн засагт эерэг ийм өссөн үзүүлэлттэй байгаа юм. Хэрвээ ингэж чадаагүй бол энэ ковид, дайн тэгээд энэ зудын гамшиг үүний ард бол ер нь юу болох бол оо? Бид нарын энэ Оюутолгойгоос өгсүүлээд Таван толгойг 100 жилээр гаднынханд өгчхөж. Оюутолгойг үндэстэн дамнасан компаниудад өгчхөөд ашиглаж эхлээгүй байхдаа 2,3 тэрбум долларын 8 их наяд төгрөгийн өрөнд орчхоод, ирээдүйд 22 их наяд долларын өрөнд орохоор ийм хэмжээний байчихсан юмыг энэ Их Хурал, Засгийн газрын үед л эхний алхмуудыг хийлээ шүү дээ. Тэгээд хэрвээ энэ Оюутолгой энэ Таван толгойг 100 жилээр Хятадын компанид өгчихсөн бол бид ер нь юугаа хэлж, хуйхаа маажиж суух вэ? Эрдэнэтийн 49 хувийг улсын мөнгөөр 400 сая доллар схемтэй шилжүүлээд, ингээд хувийн компани завчихсан. Ийм ийм юм байх юм бол одоо ер нь бид нар энэ хүндрэлийн ард яаж гарах вэ гэдэг ийм асуудлууд байгаа юм.

Тэгэхээр заяатай нь энэ чинь Монголчуудын нэг заяа түшиж, энэ Их Хурал, Засгийн газрын үед чинь үүнийг аваад, Эрдэнэтээс 2 их наяд, Таван толгойгоос гэхэд жишээлбэл 4 их наядыг төсөвтөө аваад ингээд байна шүү дээ. Тэгэхээр би юу хэлэх гэж байгаа вэ гэхээр ерөөсөө гуравхан юм. Энэ зүүн бүсийн 43 сумдаар бид нар явж ажилласан. Өмнө нь шуурхай бүлэг ажилласан. Энд тулгамдаж байгаа гол асуудал энэ Засгийн газрын өмнө нь баталсан байгаа. Маргаашийн асуудал нэг асуудал, ирээдүйн асуудал. Яг өнөөдөр тулгамдчихсан энэ зээл, зээлийн хүүг ойлголоо. Энэ зээлийн хугацаатай холбоотой асуудал энэ ер нь дор хаяж 36 сараар тавьж өгөхгүй бол зээлийн үндсэн

төлбөрөөс нь хугацааг нь хойшлуулах ажлыг ийм асуудал байгаа юм.

Дараагийнх нь энэ гамшигт нэрвэгдчихсэн, энэ чинь байгалийн гамшигт үзэгдэлд нэрвэгдчихсэн ийм ард иргэдийнхээ хохирлыг яаж барагдуулах юм бэ. Энэ дээр Байнгын хороон дээр яригдсан ийм зүйл байна уу? Өмнө нь Засгийн газрын тогтоолоор энэ 3 чиглэлээр бол тогтоол гаргачихсан шүү дээ. Засгийн газар дээр бид нар байнга ярьж байгаа.

Дараагийнх нь юм бол энэ өмнө нь явж ирсэн малжуулах төсөл хөтөлбөр. Тийм ээ, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас хэрэгжүүлдэг энэ төсөл хөтөлбөр 1 дүгээрт, олгож байгаа мөнгөн дүн хэмжээ хариугүй бага. Дээрээс нь мөн ялгаа байхгүй хугацаа шахчихсан. Тэгэхээр зэрэг энэ зээлийн хугацааг сунгахтай холбоотой, нөгөө талынх нь энэ малжуулахтай холбоотой энэ хугацаа хэмжээг нэмэгдүүлэх, дараагийнх нь юм бол энэ гамшигт нэрвэгдсэн иргэдийнхээ хохирлыг барагдуулах дээр ярьсан ийм зүйл байна уу гэдэг юмыг л асуух гээд байгаа юм.

Л.Мөнхбаатар: Байнгын хорооноос асууж байна. Асуултад БОХХААБХ-ны дарга Жигжидийн Батжаргал хариулъя. Батжаргал даргын микрофоныг өгөөрэй.

Ж.Батжаргал: Хуулийн төслийг Байнгын хороо дээр хэлэлцсэн. Хуулийг агууламж талаас нь авч харах юм бол 1 дүгээрт, МАА-н үйлдвэрлэлийн тогтвортой хөгжлийн асуудлыг, харилцааг зохицуулсан асуудлууд бий.

2 дугаарт, 1 удаагийн үйлчлэлтэй тодорхой заалтууд бий. 1 удаагийн үйлчлэлтэй заалт дотор Засгийн газар хөтөлбөр хэрэгжүүлэхээр орж байгаа юм. Тэр хөтөлбөр дотор яг энэ зээл, зээлийн хүү, малжуулалт, хохирол барагдуулалтын асуудлууд тусаж орох юм байна гэж Байнгын хороон дээр гишүүдийн асуулт хариулт, хуулийн

төсөл өргөн ба баригч буюу Засгийн газрын зүгээс хийсэн мэдээлэлд тодорхой тусгагдаж орсон.

Малчдынхаа зээлийг нэг жилийн хугацаагаар үндсэн төлөлтийг нь хойшлуулах, нэгэнт зээл хойшилж байгаатай холбогдоод хуримтлагдах хүүгийнх нь тодорхой буюу дийлэнх хэсгийг нь төрөөс хариуцах ийм тэргүүн ээлжийн зохицуулалт байгаа.

2 дугаарт, энэ малжуулах асуудал тодорхой тоо баримт бүх юман дээр тулгуурлаж яригдах ёстой зүйл юм байгаа юм. Түүнээс өнөөдөр таагаад хэн нэгэн бас ярьчихаж боломгүй байгаа. Тэгэхээр би Засгийн газрын хөтөлбөр гэдэг нь бол үндсэндээ яг энэ тоон дээрээ тулгуурлаад хэчнээн өрх тийм хэмжээний хөрөнгө санхүү шаардлагатай гэдэг энэ асуудал дээрээ тусгагдаж, энэ асуудлаа шийдэхээр эрхээ авч орж ирлээ гэж ингэж ойлгож байгаа.

Тийм учраас энэ дагуу нь шийднэ. Тэгэхдээ тэргүүн ээлжид Засгийн газрын баримталж байгаа чиглэл бол Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан дээрээ байж байгаа хөрөнгийг тэргүүн ээлжид ашиглана гэсэн ийм бодлого чиглэл байгаа юм билээ. Дээр нь нэмж манай хуулийн төсөл санаачлагч хариулт өгөөрэй.

Л.Мөнхбаатар: Амарбаясгалан сайд нэмж хариулъя.

Д.Амарбаясгалан: Малжуулах хөтөлбөр ер нь нэг 3 зүйл байгаа гэж ойлгомоор байгаа юм.

1 дүгээрт, энэ зудад нэрвэгдсэн малчдын өмнө нь авчихсан байгаа хэрэглээний зээлийг яах вэ гэдэг асуудал яригдаад байгаа юм. Үүнийг Засгийн газар тогтоол гаргаад Монголбанк, арилжааны банкттай уулзалт зохион байгуулсан, шийдвэр нь гарсан. Зээлийн эргэн төлөлтийг 1 жилээр хойшлуулна. 1 жилээр хойшлуулсантай холбогдоод хүү хуримтлагдана, энэ хуримтлагдаж байгаа хүүг яах вэ гэдэг асуудал үүссэн.

Тэгвэл Засгийн газрын тогтоолоор энэ хуримтлагдсан хүүгийн 75 хувийг төсвийн мөнгөөр төлнө, 25 хувийг зээл авсан малчин өөрөө төлнө өө гэдэг энэ зохицуулалт хийгдээд, албажаад ажил хэрэг болоод эхлээд явсан байгаа. 2 хоногийн өмнө Засгийн газрын тогтоол хамгийн сүүлийн хэлбэрээр албажсан. Ажил хэрэг болоод эхэлчихсэн байгаа.

2 дахь асуудал. Малгүй болсон иргэдийг яах вэ гэж байгаа юм. Тэгэхээр Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд 2024 оны төсөвт 107 тэрбум төгрөг батлагдсан байгаа. Энэ 107 тэрбум төгрөг дотор өнөөдөр МАА-н салбарт малжуулах хөтөлбөрийг хэрэгжүүлэх зориулалттай 22 тэрбум төгрөг байгаа. Тэгэхээр энэ 22 тэрбум төгрөгөөр энэ зудын нөхцөл байдал, зудад хорогдсон малын тоо, малгүй болсон айл, өрхийн тоо эцэслэн гарсны ард дээр Засгийн газар бодлого гаргаж хөтөлбөрөө хэрэгжүүлж ажиллана гэж байгаа юм.

3 дахь зүйл. Уламжлалт МАА цаашидаа уур амьсгалын өөрчлөлтөөс үүсэж буй сөрөг нөлөөллийг хэрхэн даван туулдаг байх вэ гэдэг асуудал хөндөгдөж байгаа. Тийм учраас дараа дараачийн жилүүдэд ирэх том эрсдэлийг сөрөн давах зорилгоор МАА-н салбарын шинэ түвшинд гаргах энэ бодлогыг Засгийн газар хэрэгжүүлэх үндсэн дээр энэ гамшигийн цаг үе дээр энэ хуулийн төслийг өргөн барьж, өнөөдөр хэлэлцүүлж байна. Хуулийн төсөл батлагдсаны үндсэнд Засгийн газар тусгайлсан хөтөлбөрийг баталж хэрэгжүүлнэ ээ. Энэ хүрээндээ малчдадаа хөрөнгө оруулалтын урт хугацааны хүү багатай зээлийг олгоно гэсэн ийм зорилгыг агуулж явж байгаа.

Л.Мөнхбаатар: Улсын Их Хурлын гишүүн Цэвэгдоржийн Туваан асуултаа асууя.

Гишүүд танхимд орж ирээрэй. Санал хураалт явагдана.

Ц.Туваан: Энэ хуулийн төслийг дэмжиж байгаа. Ер нь бас жоохон

оройтож байгаа. Сөрөг хүчин АН-ын гишүүд бол аль өнгөрсөн оны 11 сараас хойш эхлээд л ярьсан. Тэгээд нэлээн ярьж ярьж байгаад л цаг хугацааны хувьд бол оройтож байгаа гэж ойлгож байгаа. Тэгэхдээ яах вэ, энэ чинь орж ирж байгаа учраас дэмжиж байгаа.

Монголчууд зуд зулагтай гэж ярьдаг. Зудын ар дээр байгалийн шалгарлаар үлдэж байгаа мал амархан өсдөг энэ байгалийн дараагийн эрсдэлүүдэд нэлээн тэсвэртэй болж ирдэг л дээ. Тэгэхээр энэ зудын зулаг бас Засгийн газар, Улсын Их Хурлын шийдвэр болох зүйл рүү ингэж түлхэж өгч байгаад нь бол баярлаж байна.

Энэ дээр яг энэ гамшигийн үеэр бас нэлээдгүй хугацаанд малчидтай газар дээр нь сум, орон нутаг дээр ингээд очиж ажилласан. Тэгэхээр энэ дээр бол нэлээн олон зүйлүүдийг ярьсан. Энэ дотроос бас тоймтой нэг ганц 2 зүйлийг нь хэлье гэж бодож байна.

Зудын үед бол энэ ерөөсөө л тэр цастай, төмөр шилэн зудтай байгаа үед энэ сум, орон нутаг, ялангуяа энэ сумнууд дээр энэ зам гаргах техник хэрэгслийн асуудал нэн тэргүүнд шаардлагатай болсон байна лээ. Цэргийн болон онцгой байдлын техникууд чинь бүгд консервацад зогсож байгаад их хүнд болсон байна. Бензин их идэж байна. Маши олон машины мотор цохисон байгаа.

Тэгэхээр энэ асуудлын хүрээнд уур амьсгалын өөрчлөлтөөс гарч байгаа сөрөг нөлөөлөл яах хүрээн дээр мэдээж малчдаа, малаа бодолгүй яах вэ. Тэгэхдээ үүнээс гарах үр дагавар дээр сумуудын удирдлагууд бол энэ асуудлыг маш их хэлсэн шүү гэдгийг хэлье.

2 дугаарт бол АН-ын бүлгээс санаачлаад малчны зээл тэглэх, малжуулах хөтөлбөр 2-ыг нэлээн чухалчилсан ийм шийдвэрийн төсөл өргөн бариад тэгээд тэрийгээ яаж чадаагүй л дээ, тов тогтоолгож чадаагүй л дээ. Тэгэхдээ яах вэ, энэ асуудал орж ирж

байгаа учраас бас хамтатгаад хэлэлцээд явчихъя. Энэ дээр бол энэ малаа алдчихсан байгаа өрхүүд бүх 1,3 их наядын хэмжээнд нь бол уг нь яриагүй. Яг хэдэн хувийн хорогдолтой байгаа юм. Хотоо бүр харлуулчихсан айлууд, 1 ч малгүй болчихсон айлууд байгаа. Тэгээд 70 хувь гэдэг энэ шийдвэрийг бол би ер нь бол өндөр байна гэж үзэж байгаа. 70 хувиа 10 мал тутмынхаа 7-г хорогдуулна гэдэг бол маш өндөр босго. Тийм ээ. Үүнийг бүх дээрээ тэр малын индексжүүлсэн даатгалын 6 хувь руу хүрдэггүйтэй харьцуулах юм бол энэ бүр их өндөр тоо. Тэгэхээр энэ босгоо жоохон бууруулах боломж байгаа юу? Малынхаа 50 хувь, 50 болон түүнээс дээш хувийг алдсан гэдэг байдлаар ч юм уу, энэ асуудлыг нэг нэлээн тодорхой хэлж өгөөч ээ.

Малчдын зүгээс тавьж байгаа малчин бүрийн бараг амнаас гарч байгаа энэ малын гаралтай бид нарт энэ нэг тухайн цаг үеийн шинжтэй асуудлаасаа гадна бид нарын орлого нэмэгдүүлэх тал дээр бодлогыг яаралтай гаргаж өгөөч ээ. Түүн дотор нь энэ үнэгүй болчихоод байгаа малын түүхий эд боловсруулах бодлогыг яриад байгаа юм. Тэгэхээр нэгэнтээ энэ асуудлуудыг ярьж байгаа энэ цаг үе дээр бид нар энэ малын жалгын нэг хаягдаад байгаа энэ түүхий эдийг үнэ цэнтэй болгох, үнэ тогтворжуулах хөтөлбөр нэрээр хямд болгоод байгаа тэр баригдчихаад байгаа махны үнийн асуудал зэргийг нь бас бид нар яримаар л цаг болчихсон байна л даа. Тэгэхээр иймэрхүү зүйлүүдийг бас нэлээн ярьж байна лээ шүү.

Урьдчилсан тооцоогоор 16-18 сая толгой мал хорогдох тооцоо гарсан. Хэдэн өрх энэ өрх гэж тоо гарч байгаа, өндөр хувьтай малаа алдсан. Тэгэхээр энэ өрхүүд дээр нэг 5-8 сая төгрөгийн асуудал энэ сангаас яригдаад байна л даа. Тэгэхээр энэ тоог нь нэг хэлээд тодорхой ... /минут дуусав/

Л.Мөнхбаатар: Хэлэлцүүлгийн явцад бас анхаарах л асуудлуудыг хэллээ. Тэгээд төгсгөлд нь асуусан асуултад

хариулах уу? Амарбаясгалан сайд хариулъя.

Д.Амарбаясгалан: Зудын эрсдэлд одоогийн байдлаар нэг 4500 орчим малчин өрх 70-аас дээш хувийн малын хорогдолтой болсон байна гэсэн ийм мэдээ авсан байгаа, мэдээ ирсэн байгаа. Энэ 4 дүгээр сар дуусах, 5 дугаар сар дуусах цаг үед энэ тоо хэд хэчнээн болж нэмэгдэхийг одоогоор хэлэх боломжгүй байна. 2010 онд болж байсан их зуднаар 10 мянган малчин өрх их хэмжээгээр малаа хорогдуулсан дүн мэдээтэй байсан. Түүний дараа бас малжуулах хөтөлбөр хийгдэж байсан.

Тэгэхээр энэ малын хорогдлын тоо, үүнтэй холбоотой малын индексжүүлсэн даатгалаас эргэж олгогдох мөнгөн дүн, малаа их хэмжээгээр хорогдуулсан айл өрхийг малжуулах хөтөлбөр зэрэг нь Улсын Их Хурлаас батлагдчихсан байгаа төсвийнхөө хүрээнд зохицуулалт хийгдээд малжуулах хөтөлбөрөө хэрэгжүүлээд явах боломжууд нь байгаа. Ер нь энэ МАА-н салбарын хувьд тулгамдаж байгаа асуудал энэ ган зудын асуудал байна гэдгийг малчид судалгаагаар илэрхийлж байгаа. Засгийн газраас энэ хуулийн төслийг боловсруулах хөтөлбөрийн төлөвлөгөөг боловсруулах үед малчдын дунд социологийн судалгааг хийж үзсэн. Нийт судалгаанд оролцогчдын 69 хувь нь ган зудын нөхцөл байдлыг даван туулна гэдэг бол малчдын хамгийн том бэрхшээл боллоо. Энэ нөхцөл байдлыг даван туулахад эдийн засгийн хувьд хагас эрчимжсэн байдлаар МАА-н салбарын тэсвэр даах байдлыг нэмэгдүүлэхийн хувьд чухал ач холбогдолтой байна гэж ингэж үзэж байгаа юм.

Түүнээс өнөөдөр төрөөс 1 удаа буцалтгүй мөнгөн тусламж үзүүлэх, 1 удаа цаг үеийн шинжтэй арга хэмжээг авч өнгөрүүлэх гэдэг чухал асуудал биш байна. Тэр асуудалтай, асуудалгүй цаашаа явах бол явна. Гагцхүү энэ салбарыг илүү үр ашигтай, үржил шимтэй байх, ядаж мал өнөөдөр бэлчээрийн даац хэтэрчихсэн байгаа

нөхцөлийг засаж, залруулах урт хугацааны бодлого хэрэгжүүлж байж, өөрийн авах ёстой тарга тэвээрээ авах тэр нөхцөлийг бүрдүүлж өгөх зэрэг дээр Засгийн газар бодлого гаргаж ажиллаач ээ гэж байгаа юм.

Манай Монгол Улсын нийт газар нутгийн 72 хувь нь бэлчээрийн МАА эзэлж байгаа юм. Тэгээд энэ өөрөө хэтэрчихсэн байгаа энэ бэлчээрийн МАА-н даац хэтэрчихсэн байгаа нөхцөлийг засаж залруулахгүйгээр мал тарга, тэвээрээ авах боломжгүй болж байна. Мал өөрийн гэсэн өвс тэжээлийг идэж, тарга тэвээрээ авах тэр нөхцөл боломжийг бүрдүүлж өгөхгүйгээр энэ хүндрэлтэй байгаль цаг уурын нөхцөлийг тэсвэрлэх даван гарах боломжгүй байна гэдэг асуудлууд яригдаж байгаа юм.

Тийм учраас Засгийн газраас энэ хөтөлбөрийг боловсруулж, хуулийн төслийг боловсруулж өнөөдөр Улсын Их Хурлаар хэлэлцүүлж байгаа.

Л.Мөнхбаатар: Цэвэгдоржийн Туваан гишүүн тодруулж асууя.

Гишүүд танхимдаа орж орж ирье. Санал хураалт явагдана.

Ц.Туваан: 70 хувиа доошлуулах боломж байгаа юу гэсэн асуултдаа хариулт авъя.

2 дугаарт, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд байгаа тэр 107 тэрбум төгрөгөөс чинь малжуулах хөтөлбөрт нэг 22 ноогдох гээд байгаа, яриагаар. Үүнийг ер нь шийдвэр нь хаана гардаг юм бэ? Энэ мөнгийг нэмэгдүүлэх боломж байна уу? Яагаад гэхээр энэ чинь нөгөө малжуулах хөтөлбөрийг нэг тийм дорвитой байдлаар хийхгүй бол амсуулах байдлаар хийхээр үр дүн бага гарах гээд байна л даа. Тэгэхээр үүний мөнгөний хэмжээг хэлэх боломж байна уу?

Дээрээс нь энэ хууль дагаж гарах энэ мэдээж энэ чинь мөнгөний асуудал яригдаж байгаа. Тэгэхээр энэ ерөнхийдөө

мөнгөө хэдэн их наяд төгрөгийн хэмжээнд энэ зүйл яг обший бүтэн объемоороо гарах вэ гэдэг дүнгээ хэлэх боломж байна уу, багцаалж байгаа ... /минут дуусав/

Л.Мөнхбаатар: Тодруулгад хариулъя. Амарбаясгалан сайд хариулъя.

Д.Амарбаясгалан: Малжуулах хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үндэсний зөвлөл дээр хэлэлцэж шийдвэрлэнэ. Шийдвэрлэхдээ мэдээж хэрэг 2022 оны улсын төсөвт батлагдсан хэмжээнд нийцүүлсэн шийдвэр гарч таар аа. Харин энэ зудаас үүдэлтэйгээр хэд, хэчнээн малчин өрх малгүй болох вэ, хэдэн хувиар хорогдуулсан бэ гэдэг дүн мэдээ гарсны үндсэн дээр уг шийдвэр гарна.

Тэгэхээр урьдчилж мөнгөн дүн, тэдэн малчин өрх хамрагдана гэж хэлж хариулах боломж одоогоор алга байна.

2 дугаарт, ер нь малчин өрхийн амьжиргааг дээшлүүлэх зорилгоор энэ хөрөнгө оруулалтыг дэмжих, хоршиж ажиллах боломжийг бүрдүүлэх энэ зээлийн эх үүсвэрийг бий болгох зорилготойгоор энэ хуулийн төсөл явж байна. Ер нь энэ МАА-н салбарын бодлогыг бид цаг хугацааны хувьд, цаг үеийн шинжтэй шийдвэр гаргахгүй л гэж Засгийн газар зорьж байна. Халамж хэлбэрээр асуудалд хандахгүй, цаашилаад бизнес эрхлэх, МАА-н салбарыг тодорхой хэмжээнд либералчлах бодлогын үүднээс энэ хуулийн төслийг боловсруулж, оруулж ирсэн гэдгийг хэлье.

Л.Мөнхбаатар: Ажлын хэсгийн Амарбат зөвлөх наашаа хүрээд ирээрэй.

Одоо Улсын Их Хурлын гишүүн Бөхчулууны Пүрэвдорж асуултаа асууна.

Дараа нь санал хураалт явагдана. Гишүүд танхимдаа цуглая.

Б.Пүрэвдорж: Өнгөрсөн жил хаваржилт хүндэрсэн. Тэндээсээ огт

сургамж авсангүй. Өөрөөр хэлбэл өнгөрсөн жил Засгийн газрын сайд нар нэг сум болгоноор очоод нэг 20 тонн тэжээл өгдөг. 20 тонн тэжээл нь сумын айлд хүрдэггүй. 1, 1-ээрээ шуудайгаар өгөөд ч хүрдэггүй. Тэгээд 1 буянтны дүр эсгээд явсан, тэр маань тэгээд энэ жил дахиад давтагдаад энэ сургамжаасаа ерөөсөө суралцсангүй. Тэгээд энэ ядаж л 2017-оос 18 оны хооронд өвөлжилт хүндрэхэд Хүрэлсүхийн Засгийн газар өвөлжилт хүндэрсэн аймаг болгонд 5 тэрбумын зээл гаргаад, тэндээсээ хамгийн хямдхан тэжээлийг хангаад ингээд малчид хямдхан тэжээлээрээ малаа хэдэн шуудай ч болсон хамаагүй аваад ингээд ондоо орцгоосон байхгүй юу даа. Тэгээд энэ дээр ерөөсөө сургамж авсангүй. Тэгээд, энэ аймаг болгонд.

Тэгэхээр энэ жил өвөлжилт хүндрэнгүүт малчдын талаар арга хэмжээ авъя гээд АН-ын бүлэг малчдын зээлийг тэглэх тогтоолын төслийг өргөн бариад, тэгээд МАН үүнийг ээлжит бус чуулган хуралдуулсангүй. Тэгээд Засгийн газар 1 арга хэмжээ авах гэж үзлээ. Зээлийг хойшлуулъя гэлээ. 6 сарын 1. Түүнийг нь манай малчид тийм юм байхгүй гэлээ. Тэгэнгүүт больё, тэгвэл зээлийн хүүг нь 75 хувийг нь төлье гэлээ. Түүнийг нь бас эсэргүүцлээ. Тэгэнгүүт энэ малчид ерөөсөө бид нарт санал өгөхгүй юм байна. 8 сая төгрөгийн зээл өгье, хүүгээ өгье гэж баахан явлаа. Тэгж байснаа өнөөдөр ингээд 20-50 сая төгрөгийг олох тухай явуулаад оруулаад ирж байх шиг байна. Тэгээд энэ бол тэгээд л тодорхой арга хэмжээ болж чадахгүй ээ. Түүний оронд энэ 5 их наяд төгрөгийг зарцуулж байхын оронд 1,2 их наяд төгрөгийн тэр зээлийг нь тэглэх ажлыг зохион байгуулах хэрэгтэй. Энэ бол эцсийн шаардлага байх болно. Бусдаар та нар нэг ийм 500 тэрбум төгрөг гаргана л гэдэг тэр яалаа та нар. Тэр эрүүл мэндийг хамгаалах, эдийн засгийг эрчимжүүлэх 10 их наяд төгрөгийн хөтөлбөр гаргаад ковидын үед. Түүний 3 их наяд төгрөгийг нь эдийн засгийн компаниудад зээл олгоно гэсэн. Гэтэл манай Ховд аймагт тэндээс чинь дөнгөж

дөрвөн зуухан сая төгрөгийн зээл авсан юм шүү дээ. Уг нь бол манай Ховд аймагт 75 тэрбум төгрөг ирэх ёстой байхгүй юу даа, тэндээс. Тэгтэл яасан бэ гэхээр эрх мэдэлтэй хүмүүс тэр зээлээсээ бүгдийг нь аваад л, энд банканд байршуулаад л ард түмнээ хүүлээд л, оршуулаад ингээд л өнгөрсөн байгаа. Тэгэхээр үүний араас энэ зүйл чинь бүгдээрээ орох гэж байна.

Тэгэхээр энэ дээр тодорхой шийдлүүд байж байна шүү дээ. Заавал 28 тэрбум төгрөгөөр зээлийн хүүг нь төлөх тухай асуудал ярьж байна. Түүнийг нь бүхэл бүтэн Засгийн газарт эрх мэдэл өгөөд л бүх юуг, хөрөнгийн урсгал зардлыг ингээд төсвийн зохицуулалт хийх замаар шийдэх тэр эрхийг нь Засгийн газар авч байгаа юм байна л даа. Ингээж Их Хурлын эрхэд халдахгүй шүү. 28 тэрбум төгрөг бол заавал өнөөдөр төлчхөж байгаа юм биш. Тэр чинь зээлийн хүү төлөх юм байна. Зээлийн хүүгээ хойшлуулж байгаад хойтон жил төлж болно шүү дээ. Ингээж Их Хурлын эрх мэдэл рүү орж ирж болохгүй. Үүний хүрээндээ асар их зүйлийг нааш цааш нь зувчуулаад ингээд явах тийм эх суурийг бий болгож байна. Парламентын эрхэд ингээж халдахгүй шүү.

Тэгээд ер нь бол энэ нэг их тийм өөдтэй арга хэмжээ болохгүй юм байна. Тийм учраас тэр зээлийн хүү, зээл, зээлийн хүүг тэглэх, 1,2 их наяд төгрөгийн зээлийг тэглэх тэр АН-ын тогтоолын төслийг л заавал хэлэлцвэл, өнөөдөртөө малчид энд чинь сэтгэл хангалуун байна. Бусдаар ирээдүйд 5 их наяд төгрөг өгнө. Тэр нь тэгээд МАН-ын Засгийн газар байх ч юм уу, байхгүй ч юм уу. Өнөөдрийн бодлого явах ч юм уу, явагдахгүй ч юм уу. Ирэх жил энэ хуулиа хүчингүй болгох ч юм уу. Бид нар мэдэхгүй шүү дээ. Ийм байдлаар өнөөдрийн зовлонд унасан тэр малчдыг бол ингээж нэг тийм нэг ийм аргад худлаа ... /минут дуусав/

Г.Занданшатар: Дашизэвэгийн Амарбаясгалан ЗГХЭГ-ын дарга. Монгол Улсын сайд хариулна.

Д.Амарбаясгалан: Пүрэвдорж гишүүний асуултад хариулъя. Би таныг гайгүй либерал үзэлтэй Улсын Их Хурлын гишүүн гэж ойлгоод байдаг юм. Тэгээд ярьж байгаа зүйл чинь болохоор халамж тараах асуудал яриад болж өгөхгүй юм. Ер нь малчдыг цаашидаа жосоохон чинээлэг амьдрах боломж гарцыг нь нээж өгье өө гэдэг агуулгаар Засгийн газар хуулийн төсөл боловсруулж, хөтөлбөр боловсруулж ажиллаж байгаа. Цаг үргэлж хүний гар харж, төрийн шийдвэрийг харж амьдардаг энэ амьдралын тогтолцоог нь өөрчилж өгөх ёстой. Өөрөө өөрсдөөрөө хөдөлмөрлөж, анхан шатдаа өртөг шингээж, амьдрах тэр боломж бололцоог нь нээж өгөх ёстой. Энэ агуулгын үндсэн дээр бид хөтөлбөр, төлөвлөгөөгөө боловсруулаад ажиллаж байна. Жилийн 20-24 хувийн хүүтэй хэрэглээний зээл аваад амьдарч байгаа малчдыг цаашидаа яг энэ хэлбэрээр ажиллаж амьдар гэж орхих боломж алга.

Өнөөдөр нэг дундаж малчны сарын орлого сая 500 мянган төгрөг байна. Дундаж малчны сарын зардал нь 2,1 сая төгрөг байна. Сар болгон 600 мянган төгрөгийн алдагдалтай амьдралаа залгуулж, амьдрах нөхцөл боломж цаашидаа малчдын хувьд хомс байна.

Мөн дээрээс нь байгаль цаг уурын хүндрэл, ган зудын нөхцөл байдлаас хамааралтайгаар малчид мал дээр ажиллаж амьдрах сонирхол маш ихээр буурч байна. Энэ нөхцөл байдлыг илүү эдийн засгийн хөшүүргээр, хөдөөдөө чинээлэг амьдрах боломж нөхцөлийг нь бүрдүүлж өгч байж, бий болгож өгөхгүйгээр Монгол Улс цаашидаа уламжлалт МAA-н салбарыг хадгалж, хамгаалж явж чадах уу, үгүй юү гэдэг асуудал энд тулгарч байгаа гэдгийг бас та бүхэн минь ойлгох нь зөв байх гэж ингээж бодож байна.

Засгийн газраас боловсруулж байгаа уг хөтөлбөрөөр малчдад 3-5 жилийн хугацаанд жилийн 6 хувийн

хүүтэй, эхний 1 жил зээлийн эргэн төлөлтийг нь тэглэсэн байдлаар боломжийг олгож өгье гэсэн хөтөлбөрийг хэрэгжүүлж байгаа. Үүнийг санаачлахдаа бид зөвхөн шийдвэр гаргагчдын түвшинд асуудлыг ярьсангүй ээ. Малчин өрхийн дунд социологийн судалгааг хийж, тулгамдаж байгаа асуудлыг нь тодорхойлж, үүнээс хэрхэн гарах арга замыг нь хамтдаа шийдвэрлэж байгаа юм. Нийт судалгаанд оролцсон малчин өрхийн 69 хувь нь ган зудын нөхцөл байдал хүндрэлтэй байгаа учраас хөдөө мал дээр амьдарна гэдэг ойлголт байхгүй боллоо.

Цаашидаа илүү хагас эрчимжсэн байдлаар анхан шатдаа өртөг шингээх нөхцөл боломжийг бүрдүүлж, ажиллаж амьдрах нөхцөлийг бий болгож өгөөч ээ. Тэгэхгүйгээр 1 удаагийн шинжтэй мөнгө тараах, зээл тэглэх гэх мэт халамжийн бодлогыг авч хэрэгжүүлэхийг дэмжихгүй байна гэдгээ илэрхийлж байгаа юм. Яагаад гэвэл тэр бодлого малчдыг цаг үргэлж ядуу байх нөхцөл рүү шахаж байна гэдгийг малчид өөрсдөө ойлгодог болчихсон байна. Тэгэхээр ийм зүйлээр бол улс төр хийх зохимжгүй болсон байна. Харин илүү эдийн ... /минут дуусав/

Г.Занданишатар: Бөхчулууны Пүрэвдорж гишүүн тодруулж асууна.

Б.Пүрэвдорж: Би тэгээд хамгийн их яг малчны хотонд явдаг учраас би амьдрал дээрээс нь хэлье. Яг өнөөдөр малчин хүмүүс биш тийм ээ, ёстой больё, ёстой энэ цаг зуд нь ч хэцүү юм байна. Дээрээс нь энэ засаг төр нь ч дэмжихгүй юм байна, ёстой больё, нэг хэдэн мал, үлдсэн малаа зарж аваад хот руу оръё гэдэг яг энэ, яг ийм бодол дээр ирчихсэн байгаа. Яг энэ хугарал дээр байна. Энэ хугарал дээр бас тодорхой хэмжээний арга хэмжээ авах гэж танайх, та нарын наад орлож байгаа чинь зөв. Тэгэхдээ Монголчууд нэг тийм айхтар зүйр цэцэн үгтэй иүү дээ. Маргаашийн өөхнөөс өнөөдрийн уушиг дээр гэж хэлдэг учраас бидний тэр 1,2 их наяд төгрөгийн зээлийг тэглээд өгчих өв, бид нар цаашаа явчихъя л гэж байгаа юм. Ийм л юман дээр байгаа.

Би хамаагүй илүү та нарын, та нараас илүү би малчдын амьдрал дотор явдаг хүн. Би өнгөрсөн жил 108 уулзалт хийсний 83 уулзалтад баг дээр уулзалт хийсэн байхгүй юу даа.

Г.Занданишатар: Дашизэвэгийн Амарбаясгалан ЗГХЭГ-ын дарга, Монгол Улсын сайд хариулна.

Д.Амарбаясгалан: Та бас бизнес гадарладаг хүн, тийм ээ. Өнөөдөр зээлээ тэглүүлчхээд, хөрөнгө оруулалтын эх үүсвэргүй, эргэлтийн хөрөнгөгүй малчин яаж хөдөө амьдрах юм гэдгийг та бодох ёстой. Өнөөдөр Засгийн газар өнөөдөр хөрөнгө оруулалт хийх боломжийг нь Зээлийн батлан даалтын сангаар 100 хүртэл хувиар батлан даагаад зээл олгох гэж үзэж байгаа юм. Малчин өнөөдөр хэрэглээний ч бай, хөрөнгө оруулалтын ч бай арилжааны зээл авъя гэхэд барьцаа шаарддаг. Тэр барьцаа юугаа барьцаанд тавиад ямар зээл авч, амьжиргаагаа цааш нь залгуулах вэ. Зөвхөн өнөөдрөөр амьдрал дуусаж байгаа юм биш. Уламжлалт МАА, ХАА-н салбар өнө мөнхөд орших ёстой. Энэ Монголын энэ өв уламжлал устаж үгүй болох ёсгүй. Тийм учраас Засгийн газар ХАА, МАА-н салбарыг шинэ түвшинд гаргах, өнөөдөр ДНБ-д 10,5 хувийн нөлөө үзүүлж байгааг цаашидаа бид богино хугацаанд яаж 30 хүртэл хувийн нөлөө үзүүлдэг болгох вэ? Малчны сарын дундаж орлого сая 500 мянган төгрөг байгаа бол үүнийг яаж богино хугацаанд 5 сая төгрөг, түүнээс дээш хэмжээнд хүргэх вэ? Хөдөө амьдарч байгаа малчин өрх амьжиргааны баталгаажих түвшинээс доогуур орлоготой гэж үнэлэгддэг биш Монгол Улсын чинээлэг, дундаж давхаргыг бүрдүүлдэг хэсгийн төлөөлөл яаж байх вэ? Малчин хүн зөвхөн малчин гэдэг тодотголоор биш, малчин хүн бизнесмен гэдэг тодотголоор амьдрах тэр цаг үе рүү бид шилжүүлэх хөтөлбөрийг хийж өгч байгаа юм.

Ингэхээр малчид нийлээд, хоршоод хамтдаа анхан шатын хоршоо хэлбэрээр аж ахуйг байгуулаад, нэмүү өртгийг

шингээдэг болох тэр боломжийн төлөө ажиллаж байна. Өнөөдөр та малчны хотонд очоод үзэх юм бол нэг жил хагас тэжээсэн үхрээ сая төгрөгөөр зарж байгаа. Тэгэхэд Улаанбаатар хотод үхрийн мах 20 мянган төгрөг гээд бодоход тэр үхэр 5 хүртэл сая төгрөгийн үнэтэй болж ирж байна гэсэн үг. Гэтэл энэ 5 сая төгрөгийн 1 сая төгрөг нь л малчны хотонд үлдээд бусад нь бусад түвшинд яваад байна. Үүнийг тал хувийг нь малчны хотонд үлдээдэг больё ... /минут дуусав/

Г.Занданшатар: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Үг хэлэх. Дараа нь санал хураалт явна. Үг хэлэх дэмжсэн, дэмжээгүй 3 гишүүн. Үг хэлэх гишүүн байвал тасаллаа. Дэмжсэн 3, дэмжээгүй 3 гишүүн л үг хэлнэ.

Эхлээд Гонгорын Дамдинням гишүүн үг хэлнэ.

Г.Дамдинням: Уламжлалт МАА-д тулгамдаж буй уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн төсөл дэмжиж байгаа. Би ийм төрлийн хууль тогтоомжуудын үр нөлөөгөөр өдий зэрэгтэй явж байгаа гэж боддог, өөрийгөө. 90-ээд оны эхэнд манай аав, ээж 2 бас хөдөө гарч мал маллаж байгаад, зудад өртөж малгүй болж байсан. Тийм, ингээд зээл авч, төлөөр нь төлөх байдлаар амьдралаа бас дахиж нэг буцааж босгож ирж байсан юм.

Тэгэхээр энэ хуулийн үндсэн санаа энэ байгалийн энэ хүнд цаг уурын шалгуурыг даалгүй, нурж унаж байгаа, яалт ч үгүй дийлэхгүй байдалд орж, хэцүү байдалд орсон малчдаа бас нэг дахин нэг өөд нь татах энэ том бодлого явж байгаа юм. Тэгэхээр энэ хуулийг дэмжинэ.

Сая өөрийнхөө сонгогдсон тойрог Дархан-Уул аймаг болон бас хажуугийн Сэлэнгэ аймгуудаар орж, малчин ард иргэдтэй уулзаж явлаа. Малчин ард иргэдтэй орж уулзаж явахад бас энэ

хуулийг маш их сураглаж асууж байна. Ялангуяа энэ хоршоод дээрээ яг ямар хэлбэрээр зээл өгөх юм бэ? 1 дүгээрт.

2 дугаарт, энэ малын тэжээлээ тариалах газрыг хэзээ өгч эхлэх вэ. Энэ маш хэрэгтэй юм байна шүү гэдэг саналыг их ярьж байна лээ. Тэгэхээр үүнийгээ бүгдээрээ бас нэг шуурхай батлаад тэгээд журам, дүрмээ дагаж гарах дүрмүүдээ, журмуудаа гаргаад ард иргэддээ дэлгэрэнгүй, сайхан танилцуулаад, мэдээлэлжүүлээд тэгээд жигд сайхан ингээд өгөөд явчхаасай гэж бас хүсэж байна.

3 дугаарт, бид нарын бодлогын бас нэг хийх ёстой алхмыг манай Дархан, Сэлэнгийн бүс нутгийн малчин ард иргэд бол маш их асууж ярьж байна. Тэр юу вэ гэхээр Дархан арьс ширний цогцолборыг их асууж байна. Дархан арьс ширний цогцолборыг хурдан байгуулаач ээ, Дархан арьс ширний цогцолборыг байгуулж байж бид малын махаа үнэд хүргэнэ ээ. Малаа нэг газар төвлөрүүлж, малынхаа арьс шир, түүхий эд, дайвар бүтээгдэхүүнүүдийг цуглуулдаг болно. Нэмүү өртөг шингэнэ. Орлого нэмэгдэнэ ээ. Ингэж байж бид бүхэн бас энэ цаг уурын хүндрэлтэй нөхцөл байдлын эсрэг санхүүгийн баталгаатай, хүч чадалтайгаар үзэж чаддаг болно гэдэг ийм асуудлыг ярьж байна.

Тэгэхээр хэдүүлээ энэ Улсын Их хурал дээрээсээ нэг энэ Дархан арьс ширний цогцолборын ажлыг гагцхисан байгаа байдлыг нэг гаргах ажлын хэсэг гаргаад, би хэлсэн шүү дээ. ХАА-н байнгын хорооны хурал дээр. Надад өгчих өө, тэр ажлын хэсгээ. Дарханы замын араас явсан шиг явж байгаад учрыг нь олоодохъя. Тэгэхгүй бол энэ ажил бол нэг дампуу юм болоод дуусчхаад байгаа байхгүй юу. Тэгэхээр ингээд нэг малчдаа тусалчих талаас нь хэдүүлээ ажиллая. Тэгэхээр энэ хуулийг бүгдээрээ бүгдээрээ дэмжицгээе гэж хүсэж байна. Баярлалаа.

Г.Занданшатар: Сандагийн Бямбацогт гишүүн. Дэмжсэн, дэмжээгүй

үг хэлээд яваарай. Дараагийн гишүүд, тодорхойхон.

С.Бямбацогт: Хуулийн төслийг дэмжиж байгаа. Яагаад вэ гэхээр сая Амарбаясгалан сайд хэллээ. Хөдөө малчны хот нь нэг үхэр 1 сая төгрөгийн үнэтэй, Улаанбаатар хотод гэхээрээ 5 сая төгрөгийн үнэтэй болчихоод байна гэж. Ингэж малчдын орлогыг 5 дахин нэмэгдүүлэх. Өнөөдөр малчдын орлого жилд дунджаар сая 500 мянганы орлоготой, зардал нь л 2 сая 100. Энэ үндсэндээ орлогоосоо илүү зардалтай. Үүнээсээ болоод өр зээлээсээ салахгүй, байнгын банканд зээлтэй байгаад байгаа юм.

Тийм болохоор орлогыг нь нэмэгдүүлье ээ гэдэг дээр л анхаарч, энэ хуулийг төслийг оруулж ирж байгаа юм. Яаж орлогыг нэмэгдүүлэх вэ. Ерөөсөө л бид малын гаралтай түүхий эдийг боловсруулах, малыг эрүүлжүүлэх, малын үүлдэр угсааг сайжруулах, ашиг шимийг нь нэмэгдүүлэх, малын гаралтай түүхий эдийг боловсруулах, эцсийн бүтээгдэхүүн болгох. Ийм л цогц процессыг л хийж байж, энэ малчдын орлого нэмэгдэнэ ээ.

Урьд нь Монголын төр засаг яадаг байсан, Улсын Их Хурал. Малчдын тэтгэврийн насыг 5 жилээр нааилууллаа. ЭМД-ыг 2 дахин хөнгөлж өглөө. НДШ-ийг бас 50 хувийг нь төр хариуцдаг боллоо гэх мэтийн арга хэмжээ авч байгаа. Яг энэ нь бол үндсэндээ халамжийн нийгмийн хамгааллын шинж чанартай арга хэмжээ болоод байна. Тэгвэл бид нар илүү эдийн засгийн, илүү малчдыг амьжиргааг энэ амьдралын чанарыг өөрчлөх, уламжлалт МАА тийм үү, өөрчлөх энэ талд нь бас малчдынхаа орлогыг нэмэгдүүлэх энэ рүү л чиглэсэн арга хэмжээ авъя гэж байгаа юм. Өөрөөр хэлэх юм бол мал, малчин, бэлчээр 3-д нь гурвууланд анхааръя. Мал, малчин, бэлчээр гурвууланд. Зээлтэй биш тийм үү, хадгаламжтай, орлоготой малчид бий болгоё гэдэг зорилгоор.

Тэгэхээр энэ дээр л илүү анхаарч ажиллах ёстой, тийм. Тэгэхгүй юу гэдэг

юм түр зуурын амь аргацаасан. Одоо зуд болохоор нэг 2 боодол өвс, ганц уут тэжээл өгснөөр малчдын амьдрал сайжрахгүй шүү дээ. Тэгвэл ерөөсөө заавал зуд болохоор төр засагт туслаач ээ гэдэг биш өөрсдөө тэжээлээ авчихдаг, өөрсдөө өвсөө худалдаа авчихдаг, өөрсдөө эрсдэлээ даачихдаг, ийм л орлоготой болгоё, байнгын. Үүн рүү чиглэж байгаа. Энэ үүднээсээ тэр Малчин өрхийн нэгдсэн холбооны тухай хууль Их Хурлын гишүүд санаачилсан. Энэ хууль. Засгийн газрын өргөн барьж байгаа уламжлалт МАА-д тулгамдаж буй уур амьсгалын өөрчлөлтөөс малчдад үзүүлж байгаа сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль. Урьд нь бас баталчихсан хууль байгаа, бидний. Үйлдвэр технологийн паркийн тухай хууль. Үүгээр малын гаралтай түүхий эдийг сая Дамдинням гишүүний ярьж байгаа тэр арьс шир, ноос ноолуур, дайвар бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэрүүдэд төрөөс дэд бүтцийг үнэ төлбөрийг барьж өгөх, барьсан үйлдвэрүүдэд нь хөнгөлөлттэй зээл олгох, мөн бас үйлдвэрлэж байгаа бүтээгдэхүүнийг нь 10 жилийн хугацаанд татвараас хөнгөлөх, чөлөөлөх эхний 5 жилд нь 100 хувь чөлөөлөх. Ийм бас баталчихсан хууль байгаа.

Монгол Улсын Ерөнхийлөгч бас нэг цагаан алт хөтөлбөр гээд бас хийж байгаа юм байна лээ. Энэ бүгдийг нийлүүлээд, нэгтгээд цогцоор нь түрүүний ярьсан тийм үү, малынхаа үүлдэр угсааг сайжруулах, малаа эрүүлжүүлэх, ашиг шимийг нь нэмэгдүүлэх, малын гаралтай түүхий эдийг анхан шатын боловсруулалт хоршоод нь хийдэг болгох, хоршоодын анхан шатын боловсруулалт хийсэн түүхий эдийг нь үйлдвэрүүд нь аваад эцсийн хэрэглэгч нь худалдаж аваад, эцсийн бүтээгдэхүүн болгож, нэмүү өртөг шингээх ийм л боломжуудыг бий болгомоор байна.

Малын гаралтай түүхий эд урд хөршид өнөөдөр малын цус нэг литр нь 60 мянган төгрөгийн үнэтэй байна. Малын толгой, шийрийг тийм боловсруулаад

зарахад 55 мянган төгрөгийн үнэ хүрэх бололцоотой байна. Малын гүзээ 40 мянган төгрөг, малын бөөр 1 кг нь 70 мянган төгрөгийн үнэтэй. Ийм бололцоо бидэнд байгаад байгаа юм. Хонины арьсыг боловсруулаад эцсийн бүтээгдэхүүн болговол 100 мянга хүрчих бололцоотой. Үхрийн ширийг боловсруулаад эцсийн бүтээгдэхүүн болговол 500 мянган төгрөгт хүрэх бололцоотой байх. Ийм байдлаар л үндсэндээ малчдын орлогыг нэмэгдүүлэх талд нь цогц процессуудыг нэгтгээд, энэ нэлээн хэдэн гишүүдийн санаачилсан, Засгийн газрын санаачилсан, урьд нь бас хэрэгжиж байгаа энэ хуулиудыг бас хамтад нь нэг цогц процесст оруулмаар байна.

Тийм болохоор хэлэлцэхийг нь дэмжээд цаашид нэгтгээд хэлэлцээд явах ийм саналтай байна.

Г.Занданшатар: Дашдондогийн Ганбат гишүүн.

Д.Ганбат: Энэ асуудалд жоохон арай өөрөөр хандмаар байгаа юм. Яах вэ ерөнхийдөө энэ хуулийг бол арай ийм биш, арай өөр маягаар хийж болохоор байгаа юм л даа. Тэгээд энэ сонгуулийн жил, ган зуд боллоо. Тэгээд 1 нэг малчдаас зуд дээр зоолж байгаа юм шиг нэг санал авах гэсэн л маягтай нэг иймэрхүү л юм болчихоод байна л даа. Түүнээс биш энэ дээрээ бид нар дүгнэлт хийх ёстой юм байгаа юм.

Малчдын орлогыг л сайжруулах ёстой шүү дээ. Энэ ажил 8 жилд ерөөсөө хийгдсэнгүй. Энэ ганцхан л удаа малчдын талаар төрөөс нэг 2 юм даа. Нэг нь Үндсэн хуульд бол мал төрийн хамгаалалтад байна гээд нэг заачихсан. 2 дахь нь бол мал эзэндээ очсон. Ийм л 2 заалт байгаагаас биш өшөө малчдын талаар Монгол Улсын төр засгаас бол ялангуяа МАН-аас өөдтэй нэг ч зүйл хэрэгжүүлсэнгүй дээ. Үгүй ээ, тэр чинь бол тэгээд хөөрхөн аргацааж байгаа л юмнууд байхгүй юу. Нүглийн нүдийг гурилаар хуурч байгаа. Тэгээд үүний нэрээсээ авхуулаад их сонин юм.

Уламжлалт МАА тулгамдаж буй уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн төсөл. Үгүй ээ, энэ уур амьсгалтай тэгээд 1 хууль батлаад тэмцчих юм уу? Ёстой нөгөө юу билээ, тосгоноороо хэлэлцээд дэлхий хавтгай гэж батлав гэдэг шиг л юм болж байна шүү дээ, тийм.

Тэгээд энэ малын бэлчээр чинь ямар байх юм. Даац нь ямар байх юм. Ийм судалгаан дээр ажиллах ёстой шүү дээ. 70 саяын даацтай юм уу, үгүй юм уу. Ямаа нь хэдэн хувь байх ёстой юм. Энэ мэтчилнээр бид нар ажиллах ёстой. Өнөөдөр ганц орлого олж байгаа юм, ноолуур. Өнөөдөр 150, 60 мянгантай л байх шиг байна. 200, 300 хүрэх ёстой шүү дээ. 200-гаараа 200-аас буух ёсгүй, тийм. Энэ дээр бол бид нар ёстой нөгөө стратегийн бараа бүтээгдэхүүн гэдэг шиг стратегийнх байхгүй юу. Дэлхийн зах зээл дээр бид нар 40 хувийг нь гаргадаг. Энэ дээр бодлого явуулж болохоор байгаа.

Нөгөө талаар бол малчдадаа анхаармаар байгаа юм. Энэ уул уурхай, үнэхээр хажуугаар нь энэ уур амьсгалын өөрчлөлт, дээр нь энэ бол уурхай малчдыг үнэхээр хавчиж байгаа байхгүй юу, олон талаас нь. Тэгээд бид нарын явуулж байгаа бодлого аягүй буруу байна. Бид нарын ч юу байх вэ дээ, та нарын явуулж байгаа л бодлого байхгүй юу. Яаж байна вэ гэхээр тэр банкнууд бол бүрэн хариуцах ёстой шүү дээ, даатгалынхаа системээр. Гэтэл ахиад л хэдэн мал өгөөд л, банкныхаа барьцаандаа үлдээд л, нөгөө банкны мал хариулдаг малчид хэвээрээ л үлддэг. Энэ банкиг дэмжсэн бодлого болчих вий.

Нөгөө талаар энэ уур уурхайн компаниуд нийгмийн хариуцлагын хүрээнд юу хийж байгаа юм бэ. Тэр Оюутолгой юу хийж байгаа юм. Тэр гүний усыг бүгдийг нь авчихсан. Түүнийг тойроод л манай Баянхонгорын говь хүртэл манай Баянлиг чинь 2, 3 жил дараалан ган боллоо шүү дээ. Нөлөөлж байгаа байхгүй юу, тэр чинь. Тэгээд энэ дээр таг чимээгүй байгаад байх юм. Тэгээд ямар ч тусламж

дэмжлэг үзүүлж байгаа ч юм алга, тусламж дэмжлэг үзүүлээ гэхэд түүнд тайлан тавьдаг юм алга. Ковидын үеийн 5, 10 их наядын мөнгө хаашаа алга болсон нь мэдэгдэхгүй юм, ёстой зовлонтой юм аа, та нар. Тэгэхээр чинь дараагийн хүмүүсийн зээл тусламжид чинь орж ... /минут дуусав/

Г.Занданшатар:

Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүн.

Б.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Би нэг 2 зүйл хэлье. Энэ хүмүүс энэ жилийн өвөл хүндрэхийг урьдчилж харж, Их Хурал, Засгийн газраас арга хэмжээ авсангүй гээд ингээд яриад байгаа юм л даа. Үгүй ээ, тийм биш шүү дээ. Энэ өвөл амаргүй болох нь ээ гэдгийг Засгийн газрын тэргүүн Ерөнхий сайд 8 сард албан даалгавар гаргасан. Холбогдох үүрэг чиглэл өгөгдсөн. Үүнтэй зэрэгцүүлээд Засгийн газар, салбарын яам өвлийн байдал амаргүй болох учраас энэ Дорнод, Сүхбаатар аймагт бэлтгэсэн 60, 70 мянган тонн өвсийг гадагш нь экспортод гаргахаар бэлдсэн байсныг хориглосон. Тэгжээлийг гадагш нь экспортод гаргахыг хориглосон.

Дээрээс нь малчид малаа эргэлтэд оруулах ийм боломж нөхцөлийг нь гаргаж, мах бэлтгэлд зориулж, 100 тэрбум төгрөг гаргасан. Энэ 13 онд Засгийн газар, салбарын яам арьс ширийг гадагш нь түүхийгээр гаргахыг хориглочихсон. Энэ хориглосон тогтоол шийдвэрийг хүчингүй болгосон. Энэ махны квот гэж хүнд суртал, цаана нь ашиг сонирхол шингэсэн энэ нэг юмыг задалж өгсөн. Тэгээд үүний үр дүнд чинь 120 мянган тонн түүхэндээ анх удаа экспортод гаргасан. Ийм шат дараатай арга хэмжээнүүдийг бол хангалттай авч хэрэгжүүлсэн. Гэтэл бид нарын тооцож, төсөлж байгаагүйгээр ийм хүнд нөхцөл гамшигийн нөхцөл байдал бий болсон учраас Засгийн газар шуурхай мөн арга хэмжээ авч, өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлээд, ингээд авч хэрэгжүүлж байгаа энэ арга хэмжээний чинь үр дүн шүү дээ, нэг.

Дараагийнх нь юм бол юу хэлэх гээд байна вэ гэхээр зэрэг ер нь энэ 2004-өөс 8 онд энэ нүүрс, эмийн үйлдвэр, энэ боловсруулалтын түвшнийг дээшлүүлэх ийм санал санаачилга энэ Ордос энэ газруудад явж үзээд энэ талаар хэлдгээ хэлээд л байсан. Энэ МАА-тай холбоотой юм гэхэд бид нар 2010-аад оны эхээр Латин Америкийн 3 оронд явж үзээд, тэр 3 орон бол энэ малынхаа гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг ер нь амьсгаанаас бусдыг нь экспортод гаргадаг. Тэр улсууд чинь бид Европт МАА-н түүхий эд бүтээгдэхүүнээ гаргадаг байсан бол Хятад гэж нэг сайхан зах зээл бий боллоо. 16 мянган км газар бид нар хол юм. Гэхдээ амьсгаанаас бусдыг нь бид экспортолж чадаж байна гэж ийм асуудал ярьж байсан.

Тэгээд энэ сайн жишигийг бид аян замын тэмдэглэл бичээд, төвийн хэвлэлүүдээр нийтлээд, энэ Их Хурал дээр холбогдох газруудад нь саналаа хүргүүлээд, санаачилга гаргаад ингээд ажилласан боловч 10 гаран жил ер юм хийсэнгүй шүү дээ. Огт хийсэнгүй, 2012-оос 16 онд энэ чинь 12 оны өмнө эдийн засаг бололцоотой байх үеийн эдийн засгийг ерөөсөө дөрөвхөн жил ороогүй дээ. Ер нь 2 жилийн дотор л элгээр нь хэвтүүлсэн шүү дээ. Улсын төсвийн хөрөнгө оруулалт гэхэд гурван зуун тавин наймхан тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалттай. Өнөөдөр энэ баялагтаа эзэн болж байгаа энэ авлига, хээл хахуулийг хааж байгаагийн үр дүнд 3,4 их наяд төгрөгийн төсвийн хөрөнгө оруулалттай ийм л байна шүү дээ. Ингээд юм болгоныг бас үгүйсгэж ярьж болохгүй байх гэж.

Энэ хуулийг дэмжиж байгаа үндсэн шалтгаан бол энэ уламжлалт хот айлаас эхлээд айл хүний амь нэг, саахалт хүний санаа нэг. Энэ уламжлалт аравтын тогтолцоондоо малчид хөдөлмөрийн хоршихоос өгсүүлээд анхан шатын хоршоо, тэгээд дундын хоршоо, үүгээрээ дамжуулаад үйлдвэрлэгч, тэгээд хэрэглэгч, экспорт гэсэн энэ бүхэл бүтэн

цогц системээр нь энэ асуудлыг оруулж ирж байгааг бол бүрэн дүүрэн дэмжиж байгаа юм. Би өмнө нь хэлсэн, яг өнөөдөр тулгамдсан байгаа зээл, энэ гамшигт нэрвэгдсэн малчдын хохирол, тэгээд нэн тэргүүний шаардлагатай өмнө нь хэрэгжүүлж байсан тэр малжуулах хөтөлбөр энэ 3 юмаа өнөөдөр хийх ёстой ажил. Ирээдүйд хийх ёстой энэ хөтөлбөрийг зохицуулж байгаа энэ хуулийн төслийг бүрэн дэмжиж байгаа.

Энэ малын малчдын авсан хэрэглээний зээлийг 100 хувь тэглэхээр цаад талд нь бас хүндрэл гараад байх шиг байгаа юм. Энэ Засгийн газрын тогтоол дээр ч тодорхой дурдсан байгаа. Энэ зээлийн зэрэглэл, ангилал нь уначих гээд байгаа ийм хүнд төвөгтэй асуудлууд байгаа учраас үүнийг нь би маш тодорхой хэлж байгаа шүү дээ. Хугацааг нь уужуу тавьж өгөөч ээ. Малжуулах ч адилхан. Энэ зээлийн үндсэн зээлээ төлөх хугацааг ч гэсэн уужуухан тавьж өгөөч ээ гэдэг ийм л саналыг хэлээд байгаа юм. Тэгээд энэ хуулийн төслийг бол бүрэн дүүрэн дэмжиж байгаа. Үүнийг харин тууштай бодлого тууштай л хэрэгжүүлэх хэрэгтэй.

Г.Занданшатар: 3 гишүүн дэмжсэн үг хэлсэн. 1 гишүүн нь дэмжээгүй үг хэлсэн. 2 л дэмжээгүй л үг хэлнэ. Бөхчулууны Пүрэвдорж гишүүн.

Б.Пүрэвдорж: Тэгэхээр АН бол намын бүлэг малчдын зээлийг тэглэх тэр тогтоолын төслөө заавал хэлэлцүүлэх тэр байр сууриас хэзээ ч ухрахгүй ээ гэдгийг хэлье.

2 дугаарт нь, 2 сайд малчны хотноос 1 сая төгрөгөөр үхэр гараад Улаанбаатар хотод 5 сая төгрөгөөр зарагдаж байна гэж байна. Түүн шиг худлаа юм байхгүй ээ. Та нарын амьдардаг тэр санал авах гээд байгаа баруун аймгийн чинь үхэр дунджаар цул мах нь гулуузанд 120 кг гардаг юм, 120 кг чинь энд Хүчит шонхор дээр 16 мянган төгрөгөөр зарагддаг юм. Тэгээд 1 дээд тал нь сая 800 мянган төгрөг л болж

байгаа. Тэгээд амьдрал мэдэхгүй нөхөд тэгээд л ерөөсөө ингээд л худлаа яриад л ингэдгээ болиорой гэдгийг хэлье.

Хоёрдугаарх нь, үүний хүрээндээ бас бид нар тодорхой ажлууд хийх ёстой. Энэ хуулийг яах вэ, хэлэлцэж байгаад хэлэлцэх явцдаа бид нар зөв болох тэр ажлуудыг хийнэ. Ямар ч байсан юу парламентын тэр төсөв баталдаг эрхэд халдаж байгаа энэ үйлдлийг зогсоогоод, ирэх төсвөөрөө тэр 28 тэрбум төгрөг энэ тэрээ шийдэх бүрэн боломж байгаа. Түүнийг нь парламентын эрх рүү дайрдгийг нь болиулах тэр арга хэмжээг авъя гэж бодож байна.

3 дахь бас нэг чухал зүйл бол өнгөрсөн жил бид нар 67 сая толгой малтай оны эцсээр тоологдсон. Энэ жилийн эцсээр бол нэг 52 сая толгой мал тоологдоно. Энэ үед нь юу хийх ёстой гэж мэдэж байна уу? Малаа энэ цөөхөн болсон дээр нь малаа эрүүлжүүлж авах тэр хөтөлбөрийг тодорхой мөнгө төгрөг гаргаж шийдэж авах ёстой. Энэ дээр гол нь бид нар малаа эрүүл байх юм бол бид нар сайн экспортод гаргах тэр боломжийг бүрдүүлнэ. Малаа сайн борлуулж чадах юм бол яах вэ, малчид малаа эрчимжүүлэх, чанаржуулах тэр ажлуудаа бүрэн хийгээд явах ёстой байхгүй юу даа.

Тэгээд 8 жилийн туршид ингээд л түүхий эд, малын түүхий эдийг боловсруулах талаар ёстой бид нар ирэх жилүүдэд л алаад өгнө гээд л юм яриад байгаа юм. 8 жил юмаа хийж байхгүй юу ямар ч нэг ширхэг ч үйлдвэр барихгүй, тэгээд ч ер нь бол төр тэр Дарханы аж үйлдвэрийн парк барих гэж оролдсон. Одоо тэгээд та нар түүнийгээ болиод Эмээлтийн аж үйлдвэрийн парк яриад л байгаа. Түүн дээр чинь нэг шон татагдаагүй босгоогүй байж байгаа. Тэгээд түүнийгээ хэдэн жил ярих юм. Нэг ийм байдлаар нэг тийм нэг сонгууль болохоор л нэг тийм малчдаа хайртай хүн болж хувирдаг энэ зүйлээ болиорой.

Тэгэхээр бид нар бол яах вэ энэ хуулийг бас тодорхой хэмжээгээр АН-ын

бүлэг дэмжээд явна. Яг энэ параллельны бас манай бүлгийн зээлийг тэглэх тэр тогтоолын төслөөсөө буцахгүй. Тэгэхдээ параллельны бас энэ ирээдүйд малчдад хэрэгтэй энэ хуулийг дэмжээд явъя, хэлэлцээд явъя, дэмжээд явъя. Тэгэхдээ бас нэг тодорхой хэмжээний Засгийн газар бас дутуу дулимаг юм оруулж ирсэн байна. Энэ дээрээ ялангуяа малыг эрүүлжүүлэх, мөн түүнчлэн цаашидаа авах тэр үйлдвэрлэлийг яаж бий болгох юм, түүн дээр яаж хувийн хэвшил л тэр үйлдвэрүүдийг аймаг болгонд барих ёстой. Тэр барьж байгаа үйлдвэр дээрээ яаж хувийн хэвшлийг дэмжих вэ гэдэг энэ асуудлуудыг тусгаад явсан нь зүйтэй. Бусдаар бол нэг сонгууль дөхөх дээр нэг өнгөрсөн жил ийм зовлон байж л байсан шүү дээ. Өнгөрсөн жил адилхан л Ховдод дөрөвхөн тонн тэжээл үлдээд түүнийг нь Дуут сум руу 2 машин хүргэж өгч байсан. Аймгийн төвд зарагдаж байгаа нэг ширхэг шуудай тэжээл байхгүй байсан шүү дээ. Тэрнээсээ яагаад арга хэмжээ, сургамж авдаггүй юм.

Тэгээд л өнөөдөр ингээд л нэг тийм сонгуулийн жил болохоор л нэг тийм айхтар хайртай болчихдог. Тэгээд сайд нар чинь 4 жил айлын гэрээр орохгүй байж байсан энэ жилжингээ л айл хэсчихсэн л нааж явлаа шүү дээ. Үгүй ээ, тэр малчдын гэрээр орчихсон л сүрхий явж байна лээ. Тэгээд өдөр болгон л тийм баймаар байна. Яая байз.

Г.Занданшатар: Гишүүд дэмжээгүй 1 л гишүүн үг хэлэх бололцоотой. Дэмжихгүй гишүүн.

Шууд санал хураах уу. Тэгсэн байна. Цагаанхүүгийн Идэрбат гишүүн. Цагаанхүүгийн Идэрбат гишүүн дэмжээгүй л үг хэлнэ шүү дээ. Та дэмжихгүй үг хэлэх үү. Одоо 3 хүн дэмжсэн үг хэлчихсэн. Дуламдоржийн Тогтохсүрэн гишүүн та дэмжээгүй үг хэлэхгүй бол хаслаа.

Үгүй ээ үгүй, одоо ингээд Идэрбат гишүүн, Тогтохсүрэн гишүүн хоёр хоёулаа барьцана, хоёуланг нь хаслаа. Ингээд

гурвууланг нь хаслаа. Дэмжээгүй үг хэлэхгүй.

Ингээд санал хураалт явуулна.

Энэ малчдынхаа талаар авах гэж байгаа арга хэмжээ ер нь тэгээд хоршоолох хөдөлгөөн, ирээдүйд чиглэсэн арга хэмжээнүүд дээр бол нийгэм, эдийн засгийн үр дагаврыг тооцож оруулах ёстой.

Ингээд гишүүд үг хэлж дууслаа.

Одоо Байнгын хорооны саналаар санал хураалт явуулна. Санал хураалтад бэлэн үү? Бүлгүүд.

Байнгын хорооны саналаар Уламжлалт МАА-д тулгамдаж буй уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Зээлийн батлан даалтын сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хоршооны тухай хуулийн зарим хэсгийг хүчингүй болсонд тооцох тухай, Газрын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүд болон “Тогтоолд нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэнд тооцсон санал хураалт явуулна. Дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт.

59,5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Төслүүдийг хэлэлцэх нь зүйтэй гэж гишүүдийн олонх үзсэн тул төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэнд тооцон анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр БОХХААБХ-нд шилжүүлж байна.

14.01 цаг

Дараагийн асуудалд орно. Эрхэм гишүүд ээ.

14 цаг болсон учраас үдээс хойш болох чуулганы нэгдсэн хуралдаанаар Монгол Улсын Ерөнхий сайдад хандан “Монгол Улсын сэргээгдэх эрчим хүчний үнэ тариф, баримт бичгийн бодлогын хэрэгжилт, хэтийн төлөвийн талаар” тавьсан асуулгын хариуг сонсоно.

Асуулгын хариуг Монгол Улсын эрчим хүчний сайд Баттогтохын Чойжилсүрэн хариулна.

Түрүүн сонсож байсан, 2 удаа хойшилчихсон. Баагаагийн Баттөмөр гишүүн асуулга тавьсан гишүүн л мэднэ. 2 удаа хойшилсон юм байна. Хөөе, энэ Чойжилсүрэн гишүүн хаачихсан юм бэ? Түрүүн сууж байсан чинь. Туваан гишүүн суудалдаа суугаарай.

Ажлын хэсгийг оруул. Зарим сайд нар жоохон хариуцлагатай байна шүү.

Эрчим хүчний сайд Баттогтохын Чойжилсүрэн хариулна. Та хаашаа алга болчихдог юм бэ. Таныг аль хэдийн урьчихсан.

Б.Чойжилсүрэн: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ, Улсын Их Хурлын гишүүн Баттөмөрөөс Монгол Улсын Ерөнхий сайдад хандан тавьсан “Монгол Улсын сэргээгдэх эрчим хүчний үнэ тариф, баримталж буй бодлогын хэрэгжилт, хэтийн төлөвийн талаар” асуулга ирүүлсний дагуу та бүхэнд мэдээллийг хүргэе.

Монгол Улсын сэргээгдэх эрчим хүчийг хөгжүүлэхэд тэргүүлэх ач холбогдол өгч, гадаад дотоодын хөрөнгө оруулагчдыг татах зорилгоор Сэргээгдэх эрчим хүчний тухай хуулийг 2007 онд Улсын Их Хурлаас соёрхон баталсан. Тус хуулиар хөрөнгө оруулалтыг тогтвортой байлгах зорилгоор нар, салхи, усны эх үүсвэрүүдийн тарифыг ам доллароор тогтоон хуульчилсан. Сэргээгдэх эрчим хүчний тухай хууль 2007 онд Улсын Их Хурлаар соёрхон батлагдсанаар Эрчим хүчний зохицуулах хорооноос 2008-2018 онуудад 39 хуулийн этгээдэд нийт 1352,4

мвт чадал бүхий сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийн барилга байгууламж барих тухай зөвшөөрөл олгожээ.

Эрчим хүчний зохицуулах хорооноос 2 салхин цахилгаан станц, 4 нарны цахилгаан станцыг шинээр барьж байгуулах тусгай зөвшөөрлийг сунгасан. Тусгай зөвшөөрөл нь сунгагдсан нар, салхины цахилгаан станцуудын тариф 9,5 центээс 16 цент байгаа нь эрчим хүчний салбарын хувьд санхүүгийн хүндрэл бий болгохоор байна.

Өнөөгийн байдлаар улсын хэмжээнд нийт 297мвт-ын нар, салхи УЦС-ууд ашиглалтад орсон. Үүнээс хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар 90мвт-ын нийлбэр чадалтай 6 нарны цахилгаан станц, 150мвт-ын нийлбэр чадалтай 3 салхины цахилгаан станц ашиглалтад орж, нэгдсэн сүлжээнд холбогдон ажиллаж байна.

Алсын хараа 2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт сэргээгдэх эрчим хүчний суурилагдсан чадлыг 2030 он гэхэд 30 хувьд хүргэх болон Уур амьсгалын өөрчлөлтийн тухай НҮБ-ын суурь конвенцын Парисын хэлэлцээрийн хүрээнд Монгол Улсын хүлэмжийн хийн ялгаралыг 2030 он гэхэд 22,7 хувиар буюу 16,89 сая тонн СО₂-той дүйцэх хэмжээгээр бууруулах, үүнээс эрчим хүчний үйлдвэрлэл хангамжийн салбарын хүлэмжийн хийн ялгаралыг 2030 оны түвшинд 8,35 сая тонноор бууруулах зорилтыг тус тус тавьсан.

Энэ хүрээнд сэргээгдэх эрчим хүчийг зохистой хэмжээнд дэмжин хөгжүүлэх дунд, урт хугацааны бодлого, зорилго, зорилтуудыг хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүнд:

1. Монгол Улсын Засгийн газрын хөнгөлөлтөөр 90мвт, БНХАУ-ын Засгийн газрын хөнгөлөлттэй зээлээр 90мвт-ын Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц барих төслийг хэрэгжүүлж байна.

2. Хөгжлийн банкттай хамтран 80мвт-ын хүчин чадалтай 200мвт цагийн багтаамжтай цэнэг хураагуурын системийг сүлжээнд залгана. 2023-2024 оны өвлийн оргил ачаалалд чухал хувь нэмэр оруулсан.

3. Дэлхийн банкны санхүүжилтээр Ховд аймгийн Мянгад сумд 10мвт-ын нарны цахилгаан станцыг барьж, 2022 онд ашиглалтад оруулсан.

4. АХБ-ны санхүүжилтээр Сэргээгдэх эрчим хүчийг нэмэгдүүлэх төслийн хүрээнд Завхан аймгийн Алдархаан сумд 5мвт-ын нарны цахилгаан станц болон 3,6мвт цагийн батарей хуримтлуурын системийг 2022 онд, Говь-Алтай аймгийн төв Есөнбулаг сумд 10мвт-ын нарны цахилгаан станцыг 2023 онд, Алтай сумд 300квт-ын нарны цахилгаан станц болон хуримтлуурын системийг 2022 онд тус тус ашиглалтад оруулсан.

Хөвсгөл аймгийн Мөрөн сумд 10мвт-ын нарны цахилгаан станцын барилга угсралтын ажил үргэлжилж байна. Мөн шинээр нарны станцыг хэрэгжүүлэх суурь судалгааны ажил хийгдэж байна. АХБ, Стратеги Уур амьсгалын сангийн 1,2 сая ам.долларын буцалтгүй тусламжаар сэргээгдэх эрчим хүчийг нэмэгдүүлэх төслийн хүрээнд Ховд аймаг, Завхан аймаг, Баянхонгор аймаг, Увс аймаг, Говь-Алтай аймаг нийт 5 байршилд нийт 10 мянган м² талбайд 0,5мвт-ын нийлбэр чадал бүхий газрын гүний дулааны насосын системийг суурилуулж байна.

2023 оны байдлаар хувийн хэвшлийн эх үүсвэрүүд нь төвийн бүсийн нэгдсэн сүлжээний суурилагдсан чадлын 18 хувийг эзэлж байгаа боловч 2023 оны тайлан тэнцлээр нийт цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэлийн 8,8 хувийг үйлдвэрлэж, сахилгын цахилгаан эрчим хүчний борлуулалтын 22,3 хувийг авсан байна. Эдгээр нарны цахилгаан станцаас төвийн бүсийн нэгдсэн сүлжээнд 1 квт цаг эрчим хүчийг 500-600 төгрөгөөр,

салхин станцуудаас 1 квт цаг цахилгаан эрчим хүчийг 328-330 төгрөгөөр тус тус худалдан авч байгаа нь дулаан, цахилгаан, усан үйлдвэрлэдэг ДЦС-уудын цахилгаан үйлдвэрлэлийн дундаж тариф 112,9 төгрөгөөс 3-5 дахин өндөр байна.

Монгол Улсын эрчим хүчний систем нь дотооддоо горим тохируулгын түргэн ачаалал авах эх үүсвэргүйн улмаас ОХУ-тай холбогдсон 220 киловольтын цахилгаан дамжуулах агаарын шугамаар эрчим хүч импортлож, горимын тохируулга хийж байна.

Төвийн бүсийн эрчим хүчний нэгдсэн сүлжээний 2013-2022 оны өвлийн их ачаалалд нарны цахилгаан станцууд оролцдоггүй бол цахилгаан станцууд 0,2-10,2 хувиар системийн оргил ачаалалд оролцсон.

Сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэлийг зохистой хэмжээнд нэмэгдүүлэхийн тулд Сэргээгдэх эрчим хүчний тухай хуульд заасны дагуу эх үүсвэрийг шинээр барьж байгуулахдаа өрсөлдөөнт сонгон шалгаруулалтын зарчмаар хэрэгжүүлэх эрх зүйн зохицуулалтыг бий болгосон. Тус хуулийн хүрээнд Дэлхийн банк болон ОУСК-тай хамтран 100мвт-ын хүчин чадалтай салхин станцын төслийг өрсөлдөөнт сонгон шалгаруулалтаар хэрэгжүүлэхээр бэлтгэл ажлыг ханган хамтран ажиллаж байна.

Мөн Дэлхийн банкттай хамтран эрчим хүчний системд тохируулгын үүрэг гүйцэтгэх 200мвт-ын хүчин чадалтай 80 мвт цагийн багтаамжтай, батарей хуримтлуурын системийг өрсөлдөөнт сонгон шалгаруулалтыг зохион байгуулахаар бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.

Дэлхий нийтэд техник, технологи хөгжих хэрээр нар, салхины эх үүсвэрийн үндсэн тоноглолуудын үнэ өртөг буурч, сэргээгдэх эрчим хүчний төслүүдийг төр, хувийн хэвшлийн түншлэлийн зарчмаар өрсөлдөөнт сонгон шалгаруулалтыг зохион байгуулснаар зардлыг бууруулж

байна. Тухайлбал, Монгол орны байгаль цаг уур, газар зүйн байршлын хувьд ойролцоо Узбекистан улсад 100мвт-ын хүчин чадалтай нарны цахилгаан станцын төсөл хэрэгжүүлэгчийг өрсөлдөөний үндсэн дээр сонгон шалгаруулж, Цахилгаан эрчим хүч худалдах, худалдан авах гэрээг 2019 онд 25 жилийн хугацаатай байгуулснаар нэгдсэн сүлжээнд нийлүүлэх тарифыг 2,67 цент болгож, бага тарифаар хэрэглэгчдийг хангах боломжийг бүрдүүлжээ.

Мөн Камбож улсад 100мвт-ын хүчин чадалтай нарны цахилгаан станцын төсөл хэрэгжүүлэгчийг сонгон шалгаруулж, нэгдсэн сүлжээнд шилжүүлэх тарифыг 3 цент болгосон туршлага байна. Дэлхийн улс орнууд нүүрс, газрын тос зэрэг хүлэмжийн хий ялгаруулдаг эх үүсвэрээс үе шаттай татгалзаж, эрчим хүчний үйлдвэрлэл, хэрэглээг байгальд ээлтэй, хүлэмжийн хийн тэг ялгаралттай эрчим хүч, цэвэр, эрч цэвэр эрчим хүчний эх үүсвэрээр хангахаар зорьж байна.

Цаашид Монгол Улсын эрчим хүчний нэгдсэн системийг горим ажиллагааны хувьд тогтвортой өөрийгөө зохицуулах чадвар бүхий систем болгон бүрдүүлэх нь салбарын том тулгамдсан асуудал болж байна. Горим тохируулгын эх үүсвэртэй байх нь өдөр, шөнийн хэрэглээний горимыг зохицуулж, эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх төдийгүй дэлхийн хөгжлийн чиг хандлагатай нийцүүлэн, сэргээгдэх эрчим хүчийг хөгжүүлэх боломжийг бүрдүүлэх юм.

Олон улсад горим тохируулгын эх үүсвэр нь хийн болон УЦС байгаа ба манай улсад энэ чиглэлээр бага, дунд чадлын УЦС, усан цэнэг цахилгаан станцтай болох тохируулгын үүрэг бүхий хийн цахилгаан станц, эрчим хүчний хуримтлуурын системийг шинээр барих зайлиггүй шаардлага үүсээд байна.

Эрчим хүчний салбарт 100мвт-аас дээш хүчин чадалтай горим тохируулгын

эх үүсвэрийг барьж ашиглалтад оруулсан нөхцөлд хувьсах сэргээгдэх эрчим хүчний нөлөөллийг бууруулах зорилгоор урьдчилсан тооцоогоор 150-200мвт-ын суурилагдсан хүчин чадалтай нар, салхины эх үүсвэрийг шинээр байгуулах техникийн боломж бүрдэх юм.

ЭХЯ-наас тохируулгын эх үүсвэрийг бий болгох зорилгоор улсын төсвийн хөрөнгө оруулалтаар төвийн бүсийн нэгдсэн сүлжээнд ажиллах ус хуримтлуурт цахилгаан станц, дотоодын урсац бүхий Байдрагийн УЦС төслийн ТЭЗҮ-ийг боловсруулж, төслийг хэрэгжүүлэх бэлтгэх ажлыг хангаж байна. Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданишатар: Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя.

Баттогтохын Чойжилсүрэн Эрчим хүчний сайд, Нансалын Тавинбэх ЭХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга, Батмөнхийн Ерэн-Өлзий ЭХЯ-ны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Гомборагчаагийн Балжинням Диспетчерийн үндэсний төвийн захирал, Базарвааны Эрдэнэбулган Эрчим хүчний зохицуулах хорооны Үнэ тарифын газрын дарга, Пүрэвжавын Товуудорж Эрчим хүчний хорооны зохицуулагч.

Асуулгын хариулттай холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүн байна уу? Баттөмөр гишүүнээр тасаллаа. Хүрэлбаатарын Булгантуяа.

Х.Булгантуяа: Яах вэ, эрчим хүчний асуудал бас нийслэл Улаанбаатар хотод тулгамдсан асуудал байгаад байгаа учраас Засгийн газраасаа гадна бид нар чинь бас тойрог, иргэд олон нийтийг төлөөлж байгаа юм чинь асууя гэж бодож байна. Манай нийслэл Улаанбаатар хотын ерөөсөө утаа, бохирдол, агаарын бохирдол энэ бүх юмны эх үүсвэр үнэнийг хэлэхэд ДЦС-тай холбоотой. Улаанбаатар хотын цахилгаан станцын энэ эрчим хүчний эх үүсвэрийг нэмэгдүүлэхэд дараагийн 3-4 жилд ер нь ямар төсөл хөтөлбөрүүд

төлөвлөж байна вэ? Ингэснээр ялангуяа энэ захын хороод руу дахин төлөвлөлт явуулах гэхээр, барилгын төслүүд явуулах гэхээр ерөөсөө эх үүсвэрийн дутагдал л байгаад байна.

Дээрээс нь Амгалан ДЦС гээд л тэгэхэд өнгөрсөн жил доголдол үүссэн. Эргэн тойрных нь байр орон сууцууд нь бас хөлдөхөөр шахсан. Нэг иймэрхүү доголдлууд явж байгаа эх үүсвэрүүд дээр ч гэсэн бас гараад байна. Амгалан ДЦС-ын хүчин чадлыг 116-гаар нэмэгдүүлнэ гэсэн байна. Энэ төсөл маань ер нь явцын хувьд ямархуу шатдаа явж байна вэ? Хэзээ ашиглалтад орох вэ? Улаанбаатар хотын энэ эх үүсвэрийн талаас эхлээд асуучихъя. Тэгээд шаардлагатай бол нэмж тодруулъя.

Г.Занданшатар: Чойжилсүрэн сайд хариулъя. Баттогтохын Чойжилсүрэн сайд хариулна.

Б.Чойжилсүрэн: Булгантуяа гишүүний асуултад хариулъя. Ингээд эхний хэд хялбараас нь хариулчихъя. Амгалан ДЦС-ыг энэ 4 сарын 18-ны өдөр ашиглалтад авахаар бэлтгэл ажил хийгээд явж байна. Бүтэн сайны өглөө, нөгөөдөр. Бид нар өглөө 11 цагаас газар дээр нь уулзаад явах байх. 4 сарын 18-нд холбочих болов уу гэсэн ийм тооцоололтой явж байгаа, 1.

2 дугаарт, Төвийн бүсийн эрчим хүчний системд бид нар манай эрчим хүчний систем маань сүүлийн 23 онд хамгийн өндөр өсөлт үзүүлж байгаа. Жилийн хэмжээгээр дунджаар 7%. Гэхдээ зуны сарууддаа нэг 5-6 хувьтай. 11, 12, 1, 2 дугаар саруудын цахилгаан эрчим хүчний хэрэглээний өсөлт жилд дунджаар 11,5-12 орчим хувьтай байгаа юм. Үүнээс шалтгаалаад өнгөрсөн өвөл 23-24 оны өвлийг эрчим хүчний систем хоногт дунджаар эдгээр сарууд дээр бид нар 100-160 мвт-ын дутагдалтай давж туулсан. Энгийн иргэдэд бид нар хөнгөллөө гэж ярьдаг. Хуулийн хэллэг нь. Гэхдээ энгийнээр ярих юм бол тог таслаад энэ өвлийг давлаа.

Одоо энэ 2024-өөс 25 оны өвлийг яаж давах вэ гэхээр магадгүй хэрэглээний өсөлт дахиад өнгөрсөн жилийн өвөлтэйгөө харьцуулахад нэг 250 орчим мегаваттаар нэмэгдэх болов уу гэсэн ийм хүлээлт байна. Эхнийх нь нэг 80 мвт цагийн эрчим хүчийг БНХАУ-аас Оюутолгой төслийн юу, цахилгаан эрчим хүчний хангамжийн шугамыг ашиглаад энэ Сонгинын дэд станц хүртэл 80 мвт хэрэглэгчийг нэг импортлох тусад нь салгаж нэг холбох нэг систем.

2 дугаарт, энэ Бөөрөлжүүтийн цахилгаан станц гээд ийм цахилгаан станц бий. Хувийн салбар хэрэгжүүлж байгаа. 150 мвт-ын 1 блокыг энэ 10 сарын 01-нд ашиглалтад авах ийм зорилт тавиад явж байгаа. Холбогдох ажил хийж байгаа.

3 дугаарт, энэ 5 сарын дундуур, 24 оны 5 сарын дундуур Дорнодын цахилгаан станцыг 50 мвт-аар өргөтгөж байгаа. Энэ ажил дуусах байх. Тэгсэн тохиолдолд энэ ашиглалтад орсон тохиолдолд 24-25 оны өвөл зүүн бүсээсээ төвийн бүс рүү, төвийн бүсээсээ зүүн бүс рүү урсгадаг байсан цахилгаан эрчим хүчийг хэмнээд магадгүй 1 30 мвт орчмын нэмэлт эх үүсвэр бий болно гэж. Төвийн бүсдээ. Энэ 3-ыг явахаар нийтдээ 1 260 орчим мегаваттын нэмэлт эх үүсвэрүүд нэмж орно. 2024-өөс 25 оны үед.

Ингээд энэ хэмжээндээ эрчим хүчний хэрэглээ 260 мвт-аас нэмж хэрэглэгдэхгүй бол өнгөрсөн өвлийн хэмжээнд тодорхой хэмжээний хязгаарлалтууд хийгдсэн, ийм байдалтай өнгөрүүлэх байх.

25-26 оны өвөл дээр бол Бөөрөлжүүтийн цахилгаан станцын 150 мвт-ын 1 блок ашиглалтад орох яг өнөөдрийн байдлаар ажил нь эхэлсэн ийм байгаа юм. Баруун бүсийн тухайд харьцангуй гайгүй. Оросын холбооноос импортлож авч байгаа. Хятадаас нэг Ховдын 3 сум авч байгаа, энэ дээр гайгүй

байгаа. Алтай, Улиастай ... /минут дуусав/

Г.Занданишатар: Тодруулах дэг байхгүй, асуултад.

Ганибалын Амартүвшин гишүүн.

Г.Амартүвшин: Баярлалаа. Эрчим хүчний асуудал бол нийслэлчүүдэд бас их тулгамдсан асуудал. Сайдын хэлж байгаагаар өнгөрсөн өвлийг бид нар бас арай гэж нэг давсан, нэлээн хязгаарлалт хийж байгаад. Гэхдээ энэ нөгөө сэргээгдэх эрчим хүч эх үүсвэр нь сайн боловч бас нөгөө удирдахад аягүй төвөгтэй эрчим хүчний эх үүсвэр гэж ойлгож байгаа шүү дээ. Хэрэггүй үед үйлдвэрлэдэг, хураагуургүй байвал бас эрчим хүчнийхээ нийлүүлэлтийг зохицуулахад бас төвөгтэй байдаг. Тэгэхээр энэ хураагуур нэмэгдэж баригдах ямар төсөл байна, ойрын хугацаанд. Ялангуяа энэ нийслэлд хамааралтай тийм төсөл байна уу, үгүй юү гэдгийг би тодруулаад асуучихъя.

2 дугаарт, өмнө нь баригдсан нар, салхины төслүүдийн төлбөр нь төлөгдөөгүй байгаа гэсэн тийм яриа байгаад байна л даа. Өөрөөр хэлбэл улс тэр тариф нь гэрээ зураад тарифыг нь төлнө гээд амлалт өгсөн боловч тодорхой хэмжээний зарим тохиолдолд нэлээн их хэмжээний өр төлбөртэй байгаа юм байна лээ. Улс нь, нөгөө төслүүддээ тарифаа төлдөггүй. Энэ талаар тодорхой тоон мэдээлэл өгөөч ээ? Баярлалаа.

Г.Занданишатар: Баттогтохын Чойжилсүрэн сайд хариулна.

Б.Чойжилсүрэн: Амартүвшин гишүүний асуултад хариулъя. Манай салбарын хүндрэлийг ойлгож байгаад танд бас талархаж байна. Нар орчихоор эсвэл салхи зогсчихоор тийм хэмжээний чадал нөөцлөх шаардлагатай. УЦС-ууд манай улсын тухайд хүндрэлтэй байгаа. Монголын бүх голууд голдуу гадагшаа урсдаг учраас 2 улсын хоорондох харилцаа болж хувирдаг. Тухайлбал, Эгийн голын

усан цахилгаан станцыг барьж байгуулах асуудал дээр ОХУ тодорхой хэмжээний бас гомдол гаргасан. Юнескод гомдол гаргасан гэх мэт хүндрэлүүд байна.

Тэгэхээр юу бид нар хамгийн төвөгтэй асуудал бол сэргээгдэх эрчим хүчийг сүлжээнд нэмж залгахад энэ чадлыг нөөцлөх энэ асуудал яг хамгийн төвөгтэй асуудал учраас бид нар нэмж холбуулж чадахгүй байгаа ийм хүндрэл бий.

2 дугаарт, нар, салхины эх үүсвэрүүдээс төвийн сүлжээнд эх үүсвэрээ юу цахилгаан эрчим хүч нийлүүлчхээд, төлбөрөө авч чадаагүй байна гэсэн ийм мэдээлэл асуух шиг боллоо. Ийм зүйл байхгүй. Манай Диспетчерийн үндэсний төвийн захирал Балжинням надтай цуг ирж байна. Ажлын хэсгийн 1 дүгээр микрофоныг Их Хурлын дарга өгөх бололцоо байна уу? Яг тайлбарыг нь хэлээд. Хэдэн цахилгаан станц, ямар юу задаргааг нь хэлээд өгчихмөөр байна.

Г.Занданишатар: Ажлын хэсэг 1.

Диспетчерийн үндэсний төвийн гүйцэтгэх захирал Балжинням. Эрчим хүчний системд одоогийн байдлаар 6 нар, 3 салхины цахилгаан станцууд ажиллаж байгаа. Ингэхээр нэг худалдан авагчтай загвар эрчим хүчний салбарт үйлчилдэг. Энэ нэг худалдан авагчийн загварын гол онцлог нь төвлөрч орж ирсэн хөрөнгө мөнгийг үйлдвэрлэгч, тусгай зөвшөөрөл эзэмшигч нарт 100 хувь тэг үлдэгдэлтэй орлогын данснаас өдөрт нь хуваарилж ингээд явдаг ийм системтэй. Тэгээд энэхүү үйлдвэрлэсэн цахилгаан эрчим хүчийг цахилгаан эрчим хүчний тоолуураар нийлүүлэгдсэн тэр хэмжээгээр нь өдөр өдөрт нь өгөөд ингээд явж байгаа.

Хуримтлагдсан өр авлага бол байхгүй байгаа.

Л.Мөнхбаатар: Хариулт хангалттай юу.

Улсын Их Хурлын дэд дарга Салдангийн Одонтуяа асуултаа асууя.

С.Одонтуяа: Тэгэхээр сүүлийн 8 жил эдийн засгийн хувьд, улс төрийн хувьд хамгийн тааламжтай ийм үе байсан. Түүхий эдийн үнэ өндөр байсан. Гэтэл яагаад энэ олон салбарт ингээд улаан гэрэл асаачхав аа? Түүний нэг нь эрчим хүчний салбар. Тэгээд энэ шинэ эрчим хүч, нар, салхи, зай хураагуурын энэ бүх зүйлүүдээ их ад үзэх юм. Тэгээд л юм л бол энэ салбар луугаа л болохгүй бүтэхгүй гээд. Гэтэл энэ салбар чинь бас нэлээд ачааллыг үүрсэн байна шүү дээ. Тэгээд би ингээд та нарын энэ өгсөн тайлангаас харлаа л даа. Энэ хооронд ямар станцууд бий болов гэсэн чинь яг л нөгөө та бас л та нарын муу хэлээд байдаг 12-16 онд АН засаглаж байх үедээ санаачилж, хийсэн, эхлүүлсэн, гар хөлийн үсгийг нь зурсан, гадаадын хөрөнгө оруулагчдыг нь урьсан энэ бүх зүйлүүд байгаад байх юм. Жишээлэхэд манай намын үед бол би бас тэр үед гишүүн байсан, мэднэ. 155 мвт-ын салхи, 90 мвт-ын нарны цахилгаан станцыг 100 хувь хувийн хэвилийн хөрөнгө оруулалтаар Монгол инженерүүд барьж байгуулж байсан юм. Тэгэнгүүт та нарын нийт хүчин чадал сэргээгдэх эрчим хүчин дээр 281 мвт гэж байгаа байхгүй юу. Тэгэхээр 245-ыг нь манай намын үед 4 жилийн дотор эхлүүлсэн, хийсэн ийм зүйл байна. Тэгэхээр та нар танай нам чинь ерөөсөө нэг 40 мвт дээр л нэг юм хийх гэж оролдсон юм биш үү гэдгийг 1 дүгээрт хэлмээр байна. Юм үнэнээрээ сайхан.

Тэгээд бид нар бол хагас тэрбум гаруй долларын 100 хувийн хөрөнгө оруулалт шүү. Хувийн. Ерөөсөө татвар төлөгчдийн мөнгө энэ дээр нэгийг ч зараагүй. Ийм зүйлийг хийсэн байна. Монголдоо татсан байна. Энэ бол юуны үр дүн бэ гэхээр оновчтой бодлого, зохицуулалтын л үр дүн.

Харин сүүлийн 8 жил харамсалтай нь энэ салбарт хөрөнгө оруулалт, гаднын хөрөнгө оруулалт бол ер нь зогсоод, гадаадын хөрөнгө оруулагч нүүрээ

буруулсан. Би бас Чойжилсүрэн сайдад бас сарын өмнөх зүйл дээр нэг зүйлийг бас хүсэлт тавьж байсан. Энэ салбар цахилгаан станцууд салхины, байгуулагдахын тулд 247 гарын үсэг авдаг юм байна. Энэ бол маш их хүнд суртлыг бий болгодог юм байна. Та энэ дээр бас анхаарч ажиллаарай гэж хэлж байсан. Үүнийгээ танд сарын өмнө хэлсэн, энэ дээр та бас дүгнэлт хийж үзэв үү? Ер нь яг юун дээрээ ингээд ийм их олон гарын үсэг авах болдог юм бэ?

Тэгээд ер нь энэ хүнд суртлын бууруулах, хувийн хэвшилээ дэмжих дээр ямар бодит алхам хийсэн бэ? Тэгээд нөгөө дуудлагаар буюу окшнаар гээд нэлээд ярьдаг байсан, энэ дээр хэдэн төсөл энэ маягаар хэрэгжиж чадсан бэ гэдгийг асууя. Тэгээд биднийг энд ингээд зовлон тоочиж байх хооронд манай урд хөри зөвхөн 23 онд л гэхэд 220 гегаваттын нар, 70 гегаваттын салхийг шинээр барьчихсан байна шүү дээ. Тэгэхээр бид ... /минут дуусав/

Л.Мөнхбаатар: Асуултад хариулъя. Чойжилсүрэн сайд хариулъя.

Б.Чойжилсүрэн: Одонтуяа гишүүний асуултад хариулъя. Би манай эрчим хүчний салбар ямар нэгэн тийм улс төрийн зорилго агуулахгүй гэж их боддог улсууд байгаа юм. Тэгээд бид нар сүүлийн 8 жил МАН засагласан. 12-16 оны хооронд АН засагласан юм. Тэгээд би АН-ын үед оруулсан эдгээр станцууд гээд ярьж байна. Магадгүй зүгээр юу, үүнийг нэг талаас нь ярьж болно. Гэхдээ 1 квт цаг цахилгаан эрчим хүчийг 500-600 төгрөгөөр нийлүүлж байгаа. Салхин станцуудаас 1 квт цаг цахилгаан эрчим хүчийг 328-330 төгрөгөөр тус тус худалдан авч байгаа нь дулаан, цахилгаан хослон үйлдвэрлэдэг ДЦС-уудын цахилгаан үйлдвэрлэлийн дундаж тариф 113 төгрөгөөс 3-5 дахин өндөр байгаа. Энэ хэмжээгээр төвийн бүсийн нэгдсэн системийг алдагдалд оруулаад, өнөөгийн хүндрэлтэй залгуулчихсан гээд би ийм шүүмжлэлтэй зүйлийг танай нам дээр хаяглаж ярихгүй байгаа байхгүй юу. Улс

төржөөд яах юм гээд. Асуудал ингээд ярих юм бол яг энэ байдлаар цаашаа удаан үргэлжлэх юм бол дампуурахад бэлэн болчихсон байна. Манай эрчим хүчний салбар. Дампууралд хүргэсэн гол хүчин зүйл бол энэ байгаа. Ярихгүй, яриад яах вэ. Үүнийг бид нар хоорондоо маргаад яах вэ.

Сүүлийн 8 жилийн хугацаанд МАН засагласан. Ийм хэмжээний, ийм өртгөөр, цахилгаан эрчим хүч нийлүүлэе гээд ийм 8 төсөл бэлэн байна. Тусгай зөвшөөрөл нь сунгагдсан. Харамсалтай нь бид нар энэ урьдын үеийн ах нар, улс төрч нар маань ийм өндөр үнэтэй цахилгаан эрчим хүчийг төвийн сүлжээнд нийлүүлнэ гэсэн ийм хуулийн бүх шийдвэрүүдийг гаргачихсан байх үед аргаа бараад бараг гэсэн боогдуулж байгаад энэ төслүүдийг бид нар сүлжээнд холбуулж чадахгүй байгаа. Санхүүгийн тогтвортой байдлыг хадгалж чадахгүй дампуурчих гээд байгаа учраас. Ганцхан шалтгаан нь. Ийм л хүндрэл байгаа гэдгийг та бүхэнд хэлье.

Тэр 247 гарын үсэг гэдэг бол хэтрүүлэгтэй тоо байх. Аливаа нэг төсөл хэрэгжүүлэхийн тулд эхний ээлжид ЭХЯ-нд хандаж байгаа. Эрчим хүчний зохицуулах хороонд хандаж байгаа. Холбогдох шийдвэр гарч байгаа. Дараа нь Диспетчерийн үндэсний төвтэй Цахилгаан эрчим хүч худалдах, худалдан авах гэрээнүүд байгуулагдаж байгаа. Энэ хооронд тийм 247 гарын үсэг зурагдана гэж тооцохгүй байна. Би энэ удаа яг хэчнээн гарын үсэг байгааг нь тоолж үзсэнгүй. Танд эргээд мэдэгдэхээс. Манай ЭХЯ, ажлын хэсгийнхэнд хэчнээн гарын үсэг байгааг нэг төсөл хэрэгжүүлэхийн тулд хэчнээн гарын үсэг хэрэгтэй байгааг одоо гаргая, эргээд мэдэгдье.

Л.Мөнхбаатар: Улсын Их Хурлын гишүүн Дамбын Батлут асуултаа асууя.

Д.Батлут: Та бүхэндээ энэ өдрийн мэндийг хүргэе. Би урьд нь бас тодруулж байсан зүйлүүдээсээ л ярих гэж байгаа юм. Өнөөдөр манай эрчим хүчний салбарын хувьд нэлээн хүндхэн жилүүд

болж байна. Өвлийн ид ачааллын үед резервгүй бараг тэгээд зарим нэг аваарын горимд орох юм бол маш хүнд байдалд байхаар хот, аймгийн төвүүд, суурин газрууд ч хөлдөх нөхцөл байдлын эрсдэлд орчихсон тийм л байдалтай өвөлжиж байна л даа.

Тэгээд энэ эрчим хүчний систем цаашидаа хэрхэн ажиллах вэ гэдэг дээр бас тодорхой байр суурийг сонсмоор байна. Би урьд нь асууж байсан. 2013 оноос хойш тэр нар болон салхин сэргээгдэх эрчим хүчний нэг 9 компани байгуулагдаад ажиллачихсан. Тэгээд 1 квт цахилгаан эрчим хүчээ Монгол Улсын төвийн эрчим хүчний системд 303-606 төгрөгөөр нийлүүлдэг. Тэгээд энэ нь болохоор нийт эрчим хүчний хэрэглээний 9 хувь. Борлуулалтын олго орлогын 27 хувийг аваад яваад байгаа байхгүй юу. Тэгээд л компани нь бол жилийн нэг 60, 70 тэрбум төгрөгийн ашигтай ажиллаад байдаг. Төрийн өмчийн төвийн эрчим хүч систем бүхэлдээ 180, 200 орчим тэрбумын алдагдалтай ажиллаад байдаг. Энэ байдлыг хэрхэн засах вэ?

Би ахиад 2 дахиа асууж байгаа шүү. 2023 оны 5 дугаар сард асууж байсан асуултыг ахиад асууж байна. Энэ компаниудтай энэ гэрээгээ дүгнэх, үүрэг хариуцлагын асуудлаа ярих, үнэ хөлс бууруулах асуудал дээр ямар ахиц гаргах юм бэ? Яагаад ер нь энэ дээр ингээд нэг монопол эрхтэй компаниуд яваад энэ төвийн эрчим хүчний системийн алдагдал дээр алдагдал болгоод тэгээд энэ нэг хувийн хэдэн компани тэнд нэг бараг тэр чинь ажилчин ч байхгүй биз дээ. Цөөхөн хэдхэн л хүнтэй, өөрийн өртөг бол их л бага гэж ойлгож байгаа. Ингээд нэг баахан мөнгө олсон, ашигтай ажилласан байдаг юм. Энэ байдал чинь өнөөдөр эрчим хүчний системийн өөрийн өртөг доторх тарифаа нэмэгдүүлж чадахгүй, ажилчид нь цалингаа нэмэгдүүлж яаж чадахгүй, техник технологийн шинэчлэл хийж чадахгүй ийм л нөхцөл байдал оруулаад байгаа юм шүү дээ. Тэгээд үүнийгээ хэзээ засаж, залруулах гээд байгаа юм бэ энэ 9 компани дээр ер нь

ямар ажиллагаа зохион байгуулсан юм бэ гэдэг дээр нэг хариулт өгөөч.

2 дугаарт нь, манай Уулын баяжуулах Эрдэнэт үйлдвэрийн ДЦС төвийн эрчим хүчинд өөрийнхөө үйлдвэрлэсэн цахилгаан эрчим хүчээ 190 орчим төгрөгөөр өгдөг. Тэгээд буцаагаад өөрсдөө хэрэглэхээр авахдаа 300 гаран төгрөгөөр аваад байгаа байхгүй юу. Үгүй ээ, энэ чинь шударга юм уу. Хувийн хэвшилд болохоор бид нар найр тавиад л тэр сэргээгдэх эрчим хүч дээр бид нар 1 квт-ыг нь 300-606 төгрөгөөр аваад байдаг. Үндэсний компани энэ Эрдэнэт үйлдвэрийг болохоор 190 төгрөгөөр нь үйлдвэрлүүлчхээд буцаагаад нийлүүлэх эрчим хүч өөрсдөө өгөхдөө төв эрчим хүчнээс нийлүүлэхдээ 303, 300 гаран төгрөгөөр өгөөд байдаг. Ийм шударга биш байдал байгаад байх юм. Энэ ... /минут дуусав/

Л.Мөнхбаатар: Энэ дээр тодорхой хариултууд өгье. Эхлээд Чойжилсүрэн сайд хариулна. Дараа нь Эрчим хүчний зохицуулах хорооныхон энэ дээр нэмж хариулах нь зүйтэй. Чойжилсүрэн сайд хариулъя.

Б.Чойжилсүрэн: Батлут гишүүний асуултад хариулъя. Үнэхээр манай салбарын зовлонг та ойлгож байна, ийм л байгаа. Сэргээгдэх эрчим хүчнээс 1 квт цагийг нь 600 төгрөгөөр авчхаад, ахуйн хэрэглэгчдэд 140 төгрөг, Эрдэнэт үйлдвэрт 303 төгрөгөөр нийлүүлж байгаа нь үнэн. Одоо бидний чадаж байгаа нь энэ Эрдэнэт үйлдвэрээ шахаж өндөр үнэтэй шахаж байгаа. Дотоодын цахилгаан эрчим хүч үйлдвэрлэж байгаа ДЦС-уудаасаа өртгөөс нь доогуур авч байгаа. Дундаж үнэ нь 113 төгрөг. Манай ажлын хэсгийнхэн нэмээд хариулчаарай. ТЭЦ 4-өөс хамгийн хямд байгаа. Сүлжээнд нийлүүлж байгаа үнийг нь. Үүнийг дундажлахын тулд ийм л юм хийж байгаа.

Энэ хуулийг Сэргээгдэх эрчим хүчний тухай хуулийг 2007 онд батлаад

ийм үнэтэй, ийм эрчим хүч нийлүүлнэ ээ гээд хуульчлаад заагаад өгчихсөн. Үүнээс шалтгаалаад таны яриад байгаа яг төвийн бүсийн эрчим хүчний системд холбоотой 6 нарны станц, 3 салхин цахилгаан станц байгаа. Үнийг нь бууруул гэдэг ийм шаардлага тавихаар буулгахгүй байгаа учраас цахилгаан эрчим хүч нийлүүлэх хэмжээг нь буулгаж байгаа. Үүнээс шалтгаалаад гаднын хөрөнгө оруулагч нар, Монголын бүх улс төрч нар, бүх дарга нар дээр бүгд бид нарыг яаж байгаа, гомдоллож байгаа. Иймэрхүү байдалтай байгаа.

Өнгөрсөн 2007 онд тухайн үед баталсан Улсын Их Хурал, Засгийн газрын гишүүдийг энэ зүгээс 20, 10 хэдэн жилийн дараа шүүмжлээд байх нь хэцүү. Тэр үед техник, технологи хөгжсөөгүй байсан учраас хугацаагүй батлаад хаячихсаны хүндрэлээр ийм болчихоод байна. Яг өнөөдрийн байдлаар 6 нарны станц, 2 салхин цахилгаан станц энэ саяын 9-өөс гадна тусдаа, дахиад тусгай зөвшөөрөл нь сунгагдчихсан, цахилгаан эрчим хүчээ нийлүүлнэ ээ гээд ийм хүндрэл байгаа юм.

Тэгээд өчигдөр бид нар хуралдаж байгаад дунд 1 шийдвэр гаргаж байгаа. Нар нарны станцыг нэг сүлжээнд нийлүүлэх дээд хэмжээг нь 10 цент, 40 хувьтай биш ээ 20 хувьтай байх нар, 20 хувьтай байгаа тэнцэх хэмжээний 4 цаг гаралтын чадал нь 40 хувьтай тэнцэх хэмжээний батарей хуримтлууртай цуг ашиглалтад оруулсан тохиолдолд дараагийн станц сэргээгдэх эрчим хүчнүүдийг сүлжээнд холбуулъя гэдэг ийм шийдвэр зөвшөөрье гэдэг.

Салхин дээр бол өөрийнх нь нэрлэгдсэн чадлынх нь 40 хувьтай тэнцэх хэмжээний батарей хуримтлууртай цуг ашиглалтад оруулсан. Нэг зэрэг, ашиглалтад оруулах юм бол энэ сэргээгдэх эрчим хүчний төслүүдийг үлдсэн байгаа энэ 8-ын тухайд. Ийм байр суурь баримтална.

Цаашидаа энэ 8 асуудал шийдэгдсэний дараа нар болон салхин

цахилгаан станцуудыг бол уралдаант сонгон шалгаруулалтаар зарлана. Түүнээс ондоо арга байхгүй. Үүнээс болж таны яриад байгаа сэргээгдэх эрчим хүчнийхэн 2022 онд 65 тэрбум төгрөгийн ашигтай. Төвийн бүсийн эрчим хүчний систем 100 ... /минут дуусав/

Л.Мөнхбаатар: Батлут гишүүн бас тодорхой зүйл асуусан, тийм ээ. Эрдэнэтийн ДЦС-аас 190 төгрөгөөр төвийн эрчим хүчинд нийлүүлдэг. Буцаагаад авахдаа 300 гаруй төгрөгөөр аваад байна. Энэ асуудал, алдагдал нь хэрхэн яаж тооцогдох вэ энэ асуудал хэр зөрөө байгаад байгаа юм. Үүнийг их тодорхой хариулж өгөөч ээ гээд байна.

Энэ дээр хэн хариулах вэ? Чойжилсүрэн сайд хариулъя. Ажлын хэсэг нэмж хариулж болно.

Б.Чойжилсүрэн: Батлут гишүүний яриад байгаа шүүмжлэл үнэн. 190 төгрөгөөр сүлжээнд нийлүүлчээд Эрдэнэт үйлдвэрийн дулаан цахилгаан станцаас. Буцаагаад Эрдэнэт үйлдвэртэй тооцоо хийхдээ бид нар 303 төгрөгөөр хийж байгаа нь үнэн. Чадаж байгаа нь л энэ. Ийм байдалтай байгаа нь үнэн.

Эрчим хүчний зохицуулах хороо нэмээд хариулъя.

Л.Мөнхбаатар: Энэ дээр бол Эрчим хүчний хороо үнэ тарифын асуудал байгаа байх. Энэ дээр зохицуулалт хийдэг эрх бүхий зохицуулалтын байгууллагын хувьд ямар арга хэмжээ авах вэ? Энэ асуудлыг хэрхэн шийдвэрлэх вэ? Их тодорхой хариулмаар байна. Энэ дээр хэн хариулах вэ? Хэн билээ? Товуудорж. Товуу хариулах юм байна. Эрчим хүчний зохицуулах хорооны зохицуулагч Пүрэвжавын Товуудорж хариулъя.

П.Товуудорж: Эрдэнэт үйлдвэр 2015 онд анх ЭХЯ-аас ажил эхлүүлэх зөвшөөрөл авч, энэ үйлдвэрийг өргөтгөлийг барьсан. Тухайн үед ЭХЯ, Диспетчерийн үндэсний төв, Эрдэнэт

үйлдвэр, Эрдэнэт, Булганы ЦТС 2-ын хооронд байгуулсан гэрээгээр энэ станц ашиглалтад ороод 5 жил яг таны хэлдэг зохицуулалтаар Эрдэнэтийн ГОК бол уул уурхайн үнээрээ Эрдэнэтийн энэ станц Эрчим хүчний зохицуулах хорооноос юу баталсан тарифаар нь явна гэдэг ийм гэрээгээр тухайн үед ажил эхэлж, ажил эхлүүлж явсан байгаа.

Өнөөдрийг хүртэл яагаад энэ ингээд энэ хэмжээгээрээ 5 жил өнгөрчхөөд мөрдөгдөхгүй байна вэ гэвэл Эрчим хүчний зохицуулах хороо Эрчим хүчний хуулийн дагуу тусгай зөвшөөрөл олгоод нөхцөл шаардлагыг нь тавьж өгдөг. Тэгэхээр Эрчим хүчний хуулийн энэ 25 дугаар зүйлийн 25.1.3-д байж байгаа. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь санхүүгийн тайлан бүртгэлийг тусгай зөвшөөрөл олгосон үйл ажиллагааны төрөл тус бүрээр тусгай зөвшөөрөлд хамаарахгүй үйл ажиллагааны тайлан бүртгэлээс тусад нь хөтөлнө. 25.1.4 дээр аудитын байгууллагаар баталгаажуулсан санхүүгийн тайланг тусгай зөвшөөрөл олгогчдод жил бүр гаргаж өгөх гэсэн ийм үүргийг яг Эрдэнэт үйлдвэрийн энэ Эрдэнэтийн ДЦС нь бол биелүүлэхгүй байгаа. Нэг ёсондоо, бид нар тэр тарифын зардлыг нь яг ГОК-оосоо ялгаад манайд санхүүгийн энэ аудитлагдсан тайланг ирүүл гэхээр өнгөрсөн хугацаанд ирүүлэхгүй байгаа. Энэтэй холбоотой Эрдэнэт үйлдвэрийн дулааны станц манай Эрчим хүчний зохицуулах хороог өнгөрсөн онд бол шүүхэд өгсөн. Тэгээд шүүхэд өгөөд энэ тайлбарыг үйлдвэрээс бол гаргаж өгөхгүй байгаа.

Тийм учраас энэ шүүхийн процесс бол цааши нь явахгүй ийм хүлээлттэй байдалтай байж байгаа.

Л.Мөнхбаатар: 2 байгууллагуудын яах вэ, юу яахгүй, Батлут гишүүн ээ, нөгөө нэмэлт асуух цаг бол байхгүй, дэгээрээ байхгүй учраас. Тэгэхээр хэн Товуудорж манай зохицуулагч өөрөө ЭХЯ-нд бас олон жил ажилласан. Энэ чиглэлийн жаргал зовлонгуудыг мэдэж байгаа байх. Тэгэхээр 2 байгууллагуудын

хоорондын асуудал байгаад байна гэж ойлгож болох уу? Үүнийг тодорхой мэдээллүүдээ өгөөгүй юм байна шүү дээ, тийм үү? Энэ асуудлыг ер нь бас нэг талд нь гаргаж шийдвэр гаргахгүй бол яг ингээд энэ байдлаараа яваад байх нь хэр зохимжтой вэ? Энэ дээр ямар нэгэн шийдэл гаргалгаа нь бас юу байж болох вэ? Энэ талаар бас та нэг тодорхой хариулт өгөөч?

Чойжилсүрэн сайд тодорхой хариулт өгье.

Б.Чойжилсүрэн: Мөнхбаатар дарга аа, таны асуугаад байгаа энэ асуулт 2 байгууллагын хоорондох асуудал биш ээ. Аргаа барахад л хийж байгаа асуудал. Өнгөрсөн 2022 оны 12 сарын 01-нээс цахилгаан эрчим хүчний үнийг нэмэгдүүлсэн. Тухайн үед уул уурхайн хэрэглэгчдийн тарифыг бол 38 хувиар нэмэгдүүлсэн. Энэ нэмэгдлийн хүрээнд л Эрдэнэт үйлдвэрийн цахилгаан эрчим хүчний хэрэглээ ийм үнэтэй болж байгаа юм.

Тийм учраас энэ 2 байгууллагын хоорондох асуудал биш, манай эрчим хүчний системийн хамгийн чухал асуудал болчихоод байгаа юм. Одоо байгаа сүүлийн жилүүдэд 20, 21, 22 онуудад хүн төрөлхтөн түүний дотор Монгол Улс энэ ковид гэдэг айхтар өвчинтэй тулсан. Ковид өөрөө үнийн өсөлтийг бий болгосон. Түүний дараа дайн гэж нэг гадаад том шоктой. Энэ 2 хүндрэлийн үед манай эрчим хүчний хэрэглээний өөрийн өртөг айхтар нэмэгдэж байна.

Харамсалтай нь манай энэ салбар өөрөө цахилгаан эрчим хүчний үнийг тариф болгож, төрөөс мөрдүүлдэг учраас алдагдалтай яваад байгаа ийм л салбар байгаа юм. Энэ үнийн өсөлт иргэдийн амьдралд тодорхой хэмжээний дарамт учруулаад байгаа учраас эхлээд эдийн засгийн өсөлтийг бий болгох шаардлагатай байх. Дараа нь эдийн засгийн өсөлтийг айлын хаалгаар иргэдийн карманд оруултал бас тодорхой хэмжээний 12-18 сар хоцрогдолтой гэж

явдаг. Тийм учраас магадгүй бид нар энэ 2024 он дуустал эдийн засгийн өсөлт гайгүй болоод иргэдийн орлого сайжирсан үед цахилгаан эрчим хүчний үнийг дахиад нэмэхээс ондоо арга байхгүй. Ийм л байгаа.

Л.Мөнхбаатар: Ерөнхий зохион байгуулалтыг чинь ойлгож байна. Их тодорхой асууя. Тэгвэл дахиад. Энэ Тавинбэх сайд хариулах юм байна, тийм ээ. Тавинбэх Төрийн нарийн бичгийн дарга. Энэ дээр нэг ийм юм байгаад байгаа юм. Сая зөрөө байна гээд байна шүү дээ, тийм ээ, 100 хэдэн төгрөгөөр нийлүүлээд Эрдэнэтийн ДЦС тэгээд 303 төгрөгөөр буцааж авч байна гээд. Үүний чинь зөрөө нь жилд хэд орчим тэрбум төгрөг болдог юм бол? Энэ тоог нь бас нэг хэлж өгөөч.

Тэгээд сайдын хэлсэн дээр ажлын хэсгээс нэмээд Тавинбэх Төрийн нарийн бичгийн дарга нэмж хариулъя. Ажлын хэсгийн 4 номерын микрофоныг өгье.

Н.Тавинбэх: Гишүүний асуултад хариулъя. Тийм, үйлдвэрийн үнийг хэрэглэгчийн үнэтэй харьцуулж ярьж байна, гишүүд. Үйлдвэрийн үнэ дээр нэмэх нь дамжуулах, түгээх, хангах, диспетчерийн зохицуулалт нэмэгдсэн хөлснүүд нэмэгдэж байж хэрэглэгч дээр очдог гэдгийг би хэлье.

Тийм учраас түрүүний асуултад хариулсан манай хүмүүсийн хариулт дээр бас энэ зардал нэмэгдэнэ ээ. Шууд үйлдвэрийн үнэ хэрэглэгчийн үнийг харьцуулж ярих нь зохимжгүй ээ гэдгийг би хэлье.

Л.Мөнхбаатар: Тэр зөрөөний тоо нь байгаа юу, та хэдэд. 1 жилд гардаг зөрөө тооцоолол бас байдаг байлгүй тийм ээ. Түүнийг дараагийн асуулт хариултуудад та бүхэн нэмээд хариулж болно. Одоогоор бэлэн биш байна. Байна уу? Ажлын хэсгийн 1 дүгээр микрофон уу, 2 уу? Ажлын хэсгийн 2 дугаар микрофоныг өгье. Нэр албан тушаалаа хэлээд асуултад хариулъя.

Эрчим хүчний зохицуулах хороо Үнэ тарифын газрын дарга Эрдэнэбулган байна. Эрдэнэт үйлдвэрийн ДЦС-аас жилдээ 2024 онд систем рүү 276 сая квт цаг цахилгаан эрчим хүчийг 1 квт-ыг цахилгааныг нь 164 орчим төгрөгөөр нийлүүлж байгаа. Энэ нь 303 төгрөгөөс зөрөө нь 139 төгрөгийн зөрөөтэй. Тэгэхээр энэ 276 сая квт цаг дээр энэ зөрөөнд тооцож үзэх юм бол 39 тэрбум төгрөгийн зөрөө гарч байгаа. Жилд.

Л.Мөнхбаатар: Жилд 39 тэрбум төгрөгийн зөрөө алдагдал байна гэж харагдаж байгаа юм байна.

Улсын Их Хурлын гишүүн Сандагийн Бямбацогт асуултаа асууя.

С.Бямбацогт: Сая бид нар Монгол Улсын эрчим хүчний сүлжээнд нийлүүлэгдэж байгаа эх үүсвэрүүдийн үнийн тарифын асуудлыг бас сонсчихлоо. Хамгийн өндөр нь нарны станц байна. 1квт нь 600 төгрөг. Хятадаас бид нар 1 квт-ыг эрчим хүчийг үндсэндээ 500 төгрөг, Оросоос 400 төгрөг импортлоор авч байгаа. Салхины станц тэгвэл 350 төгрөгөөр 1квт эрчим хүч нийлүүлдэг юм байна. ДЦС-ууд 3, 4 дүгээр цахилгаан станц бусад эд нар болгон 100 орчим төгрөгөөр нийлүүлдэг юм байна. Тэгвэл Ховд аймагт байгаа Дөргөний УЦС 1 квт-ыг эрчим хүчийг сүлжээнд 50 төгрөгөөр нийлүүлж байгаа. Говь-Алтай аймагт байгаа Тайшир усан цахилгаан сүлжээнд 1 квт-ыг 37 төгрөгөөр нийлүүлж байгаа. 37 төгрөг хамгийн хямдхан тог нийлүүлж байгаа эх үүсвэр УЦС байна, УЦС байна.

Тэгэхээр 1 дүгээрт нь, энэ Говь-Алтай аймгийн иргэд Тайшир УЦС-ын тогийг 37 төгрөг тийм үү, больё 100 төгрөгөөр ч юм уу авах боломж байхгүй юу, хямдруулаад. Ховд аймгийн иргэд бас Дөргөний УЦС-аас 50 төгрөгөөр нийлүүлж байгаа тогийг нэг 50 нь больё, 100 төгрөг авах бололцоо байхгүй юу. Энэ дээр ямар шийдэл байж болох вэ? Нэг.

2 дугаарт нь, УЦС бол хамгийн хямд тарифтай, тийм үү. Байдаг юм

байна гэдэг нь эндээс харагдаж байна шүү дээ. Нарны станц 600 төгрөгөөр тог үйлдвэрлэж байхад нийлүүлж байхад Тайширын усан цахилгаан Дөргөний тийм үү, 37-50 төгрөг 12 дахин бага, 15 дахин бага, 15-аас 12 дахин бага. Дээрээс нь наргүй бол нарны станц ажиллахгүй, салхигүй бол салхины станц ажиллахгүй. УЦС өдөр шөнөгүй, нартай наргүй, салхитай салхигүй ажилладаг. Дээрээс нь ДЦС байгаль орчинд хорттой сөрөг нөлөөтэй хүлэмжийн хий ялгаруулдаг. УЦС бол эко. Ямар ч байгаль орчинд сөрөг нөлөө байхгүй.

Тийм болохоор л бид нар бас энэ УЦС бол барьж байгуулмаар байгаа юм лдаа. Энэ ч үүднээсээ 1968 оноос хойш яригдсан Эрдэнэбүрэнгийн УЦС-ын асуудлыг 2012 онд Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт тусгуулж, 2015 онд Эрдэнэбүрэнгийн УЦС-ын төслийн нэгж байгуулуулж, 18 онд Хятад улсын хөнгөлөлттэй Засгийн газрын зээлд хамрагдуулж, 21 онд гүйцэтгэгч компани шалгарсан байгаа. Чайна Повер компани хийж гүйцэтгэхээр. Өнгөрсөн 23 онд үндсэндээ барилга угсралтын ажил УЦС-ын барилга угсралтын ажил эхлүүлэх замыг нь тавьж дууссан. 1000 орчим хүн ажиллах кемпээ барьж байгуулж дууссан байгаа.

Сая 24 оны 3 сард Хятад улсын Төрийн зөвлөл зээлийн хэлэлцээрийг эцэслэж баталсан. Одоо ингээд үндсэндээ энэ ажил эхлэх ёстой. Энэ ажил маань эхлэх юу болж байна вэ? Өөрөөр хэлэх юм бол үндсэндээ ямар ч саадгүй болсон гэж ойлгож байгаа. Хурдан хугацаанд хэлэлцээр 2 талаасаа гарын үсэг зураад, тэгээд барилга угсралтын Чайна Повер компани орж ирээд ажиллах ёстой. Энэ хэзээ эхлэх бол? 1 дүгээрт. 2 дахь асуулт нь.

3 дахь асуулт нь орон нутгийн иргэдийг, орон нутгийн ААН-ийг энэ бүтээн байгуулалтын ажлууд оролцуулах. Энэ бас нэг 4 жил, 5 жил орчим үргэлжлэх ёстой бүтээн байгуулалтын ажил байгаа. Тэгээд тэнд тээвэрчин, жолооч

нар ачааг нь тээвэрлэмээр байна. Ард иргэд нь мах, сүү, төмс, хүнсний ногоогоо нийлүүлмээр байна. Зам, барилгын компаниуд нь бас тэр далан барихаас нь авхуулаад газар шорооны ажилд нь оролцмоор байна. Энэ тал дээр эн тэргүүнд орон нутгийн компаниудыг, орон нутгийн иргэдийг ажилтай, орлоготой байлгах энэ дээр маш хатуу бодлого байх ёстой. Энэ дээр ЭХЯ яг юу хийж байна, яг яаж төлөвлөж байна? Энэ бидэнд бас нэлээн тийм том бодлого байх ёстой. Тэгэхгүй тэгээд л орж ирсэн зээл бид нар буцаагаад төлнө шүү дээ, энэ зээлийг чинь. Төлөх зээлийг буцаагаад л Хятадын компани л аваад явчихдаг биш нэг тодорхой хэсэг нь Монголдоо, Монголчуудын орлого олж үлдэх ёстой. Энэ дээр бас маш тийм хатуу бодлого эхнээсээ барих ёстой. Энэ дээр ямархуу ажлыг төлөвлөж байгаа вэ? Үүнийг бас нэг хариулж өгөөч.

Л.Мөнхбаатар: Сандагийн Бямбацогт гишүүний асуултад хариулъя. Чойжилсүрэн сайд хариулъя.

Б.Чойжилсүрэн: Бямбацогт гишүүний асуултад хариулъя. Манай ажлын хэсгийнхэн нэг 2 зүйл бэлтгэж байгаарай. Дөргөнөөс болон Тайшираас нийлүүлж байгаа цахилгаан эрчим хүчний үнийг 1, 2 дугаарт энд хөрөнгө оруулалтаа нөхсөн юм уу нөхөөгүй юм уу, 2, 3 дугаарт Дөргөн болон Тайширын цахилгаан станцтай холбоотой дамжуулан зээлдүүлсэн өрийн үлдэгдлүүдийг одоо яг бэлтгэхээрэй. Бямбацогт гишүүнд танилцуул.

3 дугаарт, 2 дугаар асуултынх нь тухайд ингэе. Эрдэнэбүрэнгийн УЦС ингээд 4 сарын сүүл 5 сарын эхэн гэхэд ашиглалтад орох байх, ажил нь эхлэх байх. Ажил эхэлснээс хойш 51 сарын дараа буюу 2028 оны 7, 8, 9 дүгээр сарын үед ашиглалтад орно гэсэн ийм төлөвлөгөөтэй байгаа. Та өөрөө мэдээллийг мэдэж байгаа. Та бид 2 чинь өнгөрсөн намар Эрдэнэбүрэнгийн УЦС-ын төслийг хэрэгжүүлэгч компанитай ААН-тэй уулзалт хийж, эдгээр таны яриад

байгаа зүйлийг ярьсан байгаа. Түүний дараа манай би бас манай яамныхны нөхөд яг энэ талаар Монголын талын оролцоог нэмэгдүүлээрэй, Монголоос худалдан авах худалдан авалтаа нэмэгдүүлээрэй гэдэг ийм хүсэлтүүдийг, шахалтуудыг тавьж байгаа. Ийм байдалтай байгаа гэдгийг хэлье.

Ингээд ажлын хэсгийн хэддүгээр микрофон дээр бэлэн байна. Энэ хямдруулах бололцоо шулуухан үнэнийг хэлэхэд сонгууль дөхчихсөн учраас хошгоруулаад яах вэ ард түмэнд. Чадахгүй байх. Одоо байгаа үнэ их хямдруулсан үнэ гэж ойлгох хэрэгтэй. Үнийг аль болох бага л нэмэгдүүлэх талаар л ийм л зорилтыг тавьж ажиллаж байгаа ЭХЯ. Түүнээс биш янз бүрийн тийм биелүүлж чадахгүй зүйлийг хэвлэл мэдээллээр Улсын Их Хурлын индрийг ашиглаж худлаа зүйл амлах их хортой гэж бодож байгаа.

Л.Мөнхбаатар: Хариулт болсон уу.

Одоо Улсын Их Хурлын гишүүн Баагаагийн Баттөмөр асуултаа асууна. Дараа нь асуулга тавьсан гишүүнийхээ хувьд бол тусдаа бас үг хэлэх байгаа.

Баагаагийн Баттөмөр гишүүн асуултаа асууя.

Б.Баттөмөр: Энэ нар, салхины эрчим хүч үйлдвэрлэдэг хүмүүс тарифыг буулгах боломжгүй ээ гэж хариу өгдөг юм байна л даа. Тэгэхээр яг бодит өртөг нь ямар байдаг юм бэ? Тайлан баланстай яаж тусдаг юм бэ? Яамны зүгээс үүнийг та нар яаж тооцож байна. Яагаад буулгахгүй гэдгийг

Л.Мөнхбаатар: Баттөмөр гишүүн та микрофоноо дөхүүлээд яриарай. Зааланд бас сайн сонсогдохгүй байна.

Б.Баттөмөр: 1 дэх асуулт энэ байна.

2 дахь асуулт энэ 9 гэрээ яг хэдийд, хэдэн оны хэдэн сард хэн гэдэг сайдын үед хэн гэдэг албан тушаалтан энэ гэрээнүүдийг хийсэн юм бэ? Танай яаманд энэ яг энэ чиглэлээр ашиг сонирхлын зөрчилтэй хүмүүс ажилладаг гэж би сонсож байсан юм. Хариуцлагатай бий шүү. Одоо Их Хурлын протоколд байгаа шүү, хуралдааны. Тэр хүмүүс хэвээрээ байна уу?

Дараагийн асуулт. Энэ ААН, иргэн өөрийнхөө хэрэгцээнд эх үүсвэр барих ажил боломжтой байгаа юм л даа. Тэгээд үүнийг дэмжих чиглэлээр ер нь ямар ажил хийх гэж байна? Өөрөөр хэлбэл айл өрх болгон, ААН болгон эрчим хүч үйлдвэрлэгч. Бид чинь хэрэгцээнийхээ 24, 5 орчим хувийг импорттоор авч байна шүү дээ. Тэгэхээр энэ чиглэлээр юу хийгдэж байна?

Би энэ асуулгад бол сэргээгдэх эрчим хүчийг л асуусан юм. Тэгсэн чинь нэг баахан зузаан юм ирүүлсэн чинь л тэр чигээрээ л эрчим хүчний салбарын хийгдэж байгаа энэ бүх л юм л энд биччихсэн байх юм л даа. Тэгэхээр сэргээгдэх эрчим хүчийг та нар дэмжих чиглэлээр яг ямар юм хийгдэж байна? Яг ямар эрх зүйн орчин дутаад байна? Монгол Улсын Их Хурлаас, Монгол Улсын Их Хурлаас юу хиймээр байна. 2016 онд байна уу, 19 онд ч билүү нэг хууль батлагдсан тийм ээ. Тариф, тарифыг хэрэгжүүлэх ёстой энэ Эрчим хүчний зохицуулах хороо. Яамандаа ч яамны сайдын шийдвэргүйгээр үүнийг зохицуулах боломжтой. Энэ хуулийн хэрэгжилт ямар байна? Яг ямар түвшинд явж байна? Энэ эрчим хүчний үнэ тариф, ер нь тэгээд шийдэл бол үнэ тариф нэмэх шүү дээ. Өөр шийдлүүд их бас ховор. Янз бүрийн юм байгаа байх л даа. Тэгэхдээ үнэ тарифыг ард иргэдэд, ААН-д ялангуяа ард иргэдэд дарамт болохгүйгээр нэмэх ямар боломжууд байгаа юм бэ гэсэн ийм байна.

Энэ иргэд бол эрчим хүч худалдъя гэж байгаа юм. Намайг асуулга тавьсан чинь хүмүүс надад хандаж байна л даа. Би эрчим хүчээ худалдмаар байна. Асар хямд

үнээр авах гэж байна, бараг өгснөө л өгөөгүй нь дээр ээ гэж. Тэд нарын авах нэгэнт 8, 9, 10 хэдэн центээр аваад байгаа юм чинь. Эд нарын бас авах тэр тарифыг нэмэх чиглэлээр янз бүрийн асуудлууд бол байж болох уу, үгүй юү? Тийм... /минут дуусав/

Л.Мөнхбаатар: Баттөмөр гишүүний асуултад хариулъя. Хэн хариулах вэ? Ажлын хэсэг нэмж хариулъя, тийм ээ. Чойжилсүрэн сайд хариулна, Эрчим хүчний сайд. Нэмж ажлын хэсэг.

Б.Чойжилсүрэн: Манай ажлын хэсэг байна шүү дээ, сая Баттөмөр гишүүний асуусан асуулт байна шүү дээ. Залгачихсан байгаа 6 нар, 3 салхины цахилгаан станц байгаа. Хэдэн онд ашиглалтад орсныг нь бүгдийг нь 1 дүгээрт бэлтгэж байгаарай. Цаг хожоод. Би ондоо асуултад хариулж байя. Нэг. Ямар сайд хэдэн оны хэдэн үед гэдгийг нь тодорхой болгочих байх.

Ашиг сонирхлын зөрчилтэй хүмүүс ажилладаг гэсэн ийм шүүмжлэл байгаа. Одоогийн байдлаар АТГ-аас ийм дүгнэлттэй албан хаагч манай системд алга байна. Удирдах албан тушаал дээр нь. Яам болон Диспетчерийн үндэсний ТӨК-ууд дээр гэдгээ хэлье.

Иргэд, ААН-үүд өөрсдөө цахилгаан эрчим хүчээ төвийн бүсийн нэгдсэн системд холбохгүй бол өөрөө өөрийнхөө цахилгаан юуг хэрэглээг хангах нь нээлттэй байгаа шүү дээ. Зөвшөөрөл авахгүйгээр, 1.

Иргэд маань өөрсдөө сэргээгдэх эрчим хүч панел тавьчихаад төвийн бүсэд нийлүүлэе гэдэг ийм санал тавьдаг. Харамсалтай нь яг тийм хэмжээний, тодорхой хэмжээний, давлагаа болгуулаад мэдрэгдэм ийм хэмжээний санал, хүсэлт ирэхгүй байгаа, 1 дүгээрт.

2 дугаарт, иргэд маань бага хүчин чадлаар ажиллаж байгаа учраас нэгжийнх нь үнэ өндөр гарна. Хөрөнгө оруулалтынхаа элэгдлээрээ тооцоод

хөрөнгө оруулалтаа буцааж нөхөж авна гэдэг ийм байдлаар санал, санаачилгууд бол одоохондоо яаман дээр ирэхгүй байна гэдгийг хэлье.

Сэргээгдэх эрчим хүчийг дэмжихэд нэг л саад байна. Холбоотой байгаа 6 нарны станц, 3 салхины станц байгаа. Дээр нь нэмээд өнгөрсөн жилүүдэд өгчихсөн 39 тусгай зөвшөөрлөөс Эрчим хүчний зохицуулах хороо янз бүрийн байдлаар сунгахгүй, сунгах хүсэлтээ өгснийг явж байгаад яг өнөөдрийн байдлаар 4 байна уу, Зохицуулах хороо үүнийг яг хэлээдхээрэй. Яг хүчин чадлаар нь. 4 нарны станц, 2 салхин цахилгаан станц байгаа. Шүүх дээр, 2 3 төслийн асуудал шүүх дээр явж байгаа. Иймэрхүү байдалтай байгаа. Эдгээр одоо байгуулагдах залгагдчихсан болон залгагдах бэлэн болчихсон байгаа энэ 8 станцын хувьд үнэ өндөр байгаа. Хэрвээ энэ 8 станцыг бид нар байгаагүйсэн бол одоо шууд тендер зарлаад явахад нар, салхины хосолмол эх үүсвэрээс магадгүй дунджаар 4-5 центээс хэтрүүлэхгүйгээр цахилгаан эрчим хүчийг бид нар нийлүүлээд, тендер зарлаад, төвийн бүсийн эрчим хүч болон бусад Монгол Улсын хэмжээнд хэрэглээндээ сүлжээнд нийлүүлчих, залгуулчих ийм бололцоо байгаа. Узбекистан улсад жишээлбэл 2,67 центээр 100мвт-ын станц ашиглалтад орсон байна. Кампожид мөн ялгаагүй 4 гээд бусад улс орнуудын жишигийг ингээд судлаад явахаар хямдруулах бололцоотой байдаг.

Харамсалтай нь Монголын төр шийдвэр гаргаад, хуульчилж батлаад эдгээр хүмүүст энэ 8 станцын, задаргааг хэлээдхээрэй.

Л.Мөнхбаатар: Ажлын хэсэг нэмж хариулъя. Товуу хариулах уу? Ажлын хэсгийн 3 дугаар микрофоныг өгье.

П.Товуудорж: Өнгөрсөн хугацаанд ЭХЯ-ны Шинжлэх ухаан техникийн зөвлөлөөр дэмжигдэж нийтдээ сэргээгдэх эрчим хүчний салхины 7, нарны 40 нийт хүчин чадал 1622мвт-ын хүчин

чадалтай ийм төслүүд Эрчим хүчний зохицуулах хороон дээр тусгай зөвшөөрөл авахаар хүсэлтээ өгсөн. Үүний 2007-2017 он ны хооронд салхин дээр 7 станц, наран дээр 31 станц нийлбэр хүчин чадал 1352,4 мвт-ын хүчин чадалтай тусгай зөвшөөрлийг олгосон. Үүнээс таны хэлдэг 9 сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр нийлбэр хүчин чадал нь 245 мвт-ын хүчин чадалтай. Салхины 3, нарны 6 станц бол үйл ажиллагаанд ингээд системд холбогдоод үйл ажиллагаа явуулж байна.

Хүчингүй болсон тусгай зөвшөөрөл нь цуцалсан 22 байгаа. Энд Нарны станц нь 16, 20-21 онд. Салхины 1 станц, 23 онд Салхины 1, Нарны 4 гээд нийтдээ 597,4 мвт-ын хүчин чадалтай 22 тусгай зөвшөөрөл бол цуцлагдсан. Тусгай зөвшөөрлийн хугацаа дуусаагүй байгаа 6 станц байгаа. Салхины 2 нийлбэр хүчин чадал нь 202 мвт, нарны 4 нийлбэр хүчин чадал нь 60 мвт, сунгах шийдвэр нь гараагүй 2 станц байгаа. Салхины 1 станц 50 мвт, нарны станц нь 50мвт ингээд нийлмэл хүчин чадал нь 100мвт. Эдгээр 9 станцын Эрчим хүчний зохицуулах хорооноос үйл ажиллагаа барилга угсралтын ажлаа дуусаад үйл ажиллагаа үйлдвэрлэл явуулах тусгай зөвшөөрөл олгодог. Энэ хугацаагаар Хили Энержи ХК-ийн 50мвт-ын Төв аймгийн Сэргэлэн дэх станц 2013 оны 6 сарын 19-нд, Хили Энержи Ази буюу Өмнөговь аймгийн Цогтцэций сум дахь 50мвт-ын станц 2017 оны 6 сарын 14-нд, Сайншанд салхин паркийн Дорноговь аймгийн Сайншианд сум дахь 55 мвт-ын салхин станц 2019 оны 01 сарын 17-нд, нарны станц Солар Повер интернэйшнл Дархан-Уул аймаг дахь 10 мвт-ын нарны станц 2017 оны 01 сарын 06-нд, Эвридэй ферм Улаанбаатар хотын СХД дэх 10 мвт-ын станц 2017 оны 08 сарын 31-нд, Наран тээг Дорноговь аймгийн Замын-Үүд 2018 оны 11 сарын 22, И Эс Би Солар Энержи Говьсүмбэрийн Сүмбэр 10мвт 19 оны 3 сарын 28, Тэнүүн Гэрэл констракин Төв аймгийн Сэргэлэн сум 2019 оны 07 сарын 04, Десерт Солар Повер ван 2020 оны 10 сарын 16 Дорноговь аймгийн Сайншианд сум гээд энэ 9 сум эх үүсвэрийн эрчим хүч

үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл бол ийм цаг хугацаанд олгогдсон байна, Эрчим хүчний зохицуулах хорооноос.

Л.Мөнхбаатар: Гишүүд асуулт авч, хариулт авч дууслаа.

Гишүүд бол асуулт асуусан. Энэ дотор бас олон асуудлуудыг хөндөж асуулаа. Дамбын Батлут гишүүний тавьсан Эрдэнэтийн ДЦС-тай холбоотой, үнэ тарифтай холбоотой, түүний алдагдалтай холбоотой асуудлаар Эрчим хүчний зохицуулах хороо Батлут гишүүнд бичгээр тодорхой танилцуулга хүргүүлээрэй. Энэ дээрээ шийдэх арга зам, нөхцөл байдлуудаа тодорхойлсон ийм танилцуулгыг Батлут гишүүний нэр дээр ирүүлэх нь зүйтэй гэдгийг хэлье.

Одоо асуулга тавьсан Улсын Их Хурлын гишүүн Баагаагийн Баттөмөр үг хэлнэ.

Б.Баттөмөр: Энэ эрчим хүчнийхээ асуудлыг шийдэж байж хөгжил ярина. Манай эрчим хүчний систем бол аль эрт дампуурчихсан шүү дээ. Улс л татаж чангааж л авч явж байгаа. Ер нь төвөгтэй байдалд үүссэн байна л даа. Яах вэ дэлхийн чиг хандлага сэргээгдэх эрчим хүч рүү, нар, салхи, УЦС, батарей гээд янз янзын юм руу л явж байх шиг байна.

Ер нь алслагдсан манайх шиг ийм алслагдсан газар нутагтай, хүн цөөтэй газар төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэх дээр нар, салхины станцаас тэр батарейд хуримтлуулах байдлаар эрчим хүчний асуудлыг шийдэх гарц бол зөв, зөв өө гэж ингэж миний хувьд боддог. Тэгэхдээ мэргэжлийн улсууд та бүгд яаж мэддэгийг ямар бодлого барьж байгааг би сайн мэдэхгүй байна.

Ер нь өнөөдөр ард иргэдийн нуруун дээр энэ сэргээгдэх эрчим хүчний дэмжих тариф гэж 23,7 төгрөг авч байгаа шүү дээ, ард иргэдээс. Тухайн үед хариуцлагагүй өндөр үнэтэй хийсэн

гэрээнээс болоод ард иргэдээ Монголын 3,4 сая хүний нуруун дээр ийм юм үүрэгдэж байгаа шүү дээ. Ийм хариуцлагагүй юм хийчихээд тэгээд та нар хэлэхгүй л байна л даа. Ямар сайдын үед хэн хийгдсэн юм гээд. Танайхан энд орж ирээд ярьж байсан шүү дээ. Одоо ч гэсэн ашиг сонирхлын зөрчилтэй улсууд нь энд байж л байгаа гээд. Тэр улсуудаа хэлэхгүй л байна шүү дээ.

Нэгэнт та нар эрчим хүчний би бол сэргээгдэх эрчим хүч асуусан. Гэхдээ эрчим хүчний бүх юм бас яриад байгаа учраас энэ Бөөрөлжүүтийн станц яах юм. 1,4 тэрбум квт цагийн эрчим хүчийг 28 жилийн хугацаанд 8,8 центээр нийлүүлнэ ээ гээд хийчихсэн. Өөрчлөгдсөн үү, өөрчлөгдөөгүй юу. Тийм үнээр тийм их том эрчим хүч худалдаж авах боломж байгаа юм уу. 10 дугаар сард эхний блок нь орно гэж байгаа биз дээ, энэ чинь одоо. Үгүй ээ, тэгээд яах юм тэр чинь төрийн хэвшил барьчихлаа.

Тэгээд тэгж хохироож болохгүй шүү дээ. Энэ болохгүй байгаа юмнуудаа Чойжилсүрэн сайд аа, энэ төр засагтаа үнэнээ хэлж орж ирж тавих хэрэгтэй. Яах юм, энэ чинь ингээд л болж байгаа юм шиг яваад байдаг ийм байж болохгүй шүү дээ.

Сэргээгдэх эрчим хүчийг яаж дэмжих юм. Ямар эрх зүйн орчин хэрэгтэй байна. Түүнийг бид боломж байдаг бол шийдэх шаардлагатай. Монголын төр шийдэх шаардлагатай.

2 дугаарт, энэ ашиггүй хийгдсэн гэрээнүүдийг яах юм. Ерөөсөө ингээд нэг тийм хулгай, авлигын шинж чанартай юм хийчихээд тэгээд ард нь хүмүүс нуугдчихдаг шүү дээ. Монголын өнөөдрийн бүх ажил тэр шүү дээ. Энэ эрчим хүчний энэ гэрээг бол үүний цаад талд бол ашиг сонирхлын зөрчил байна гэж үзэж байна. Би бол. Тэнд одоо тэр Узбекистанд юу билээ, энэ чинь 2,7 центээр 1 квт-ыг нь нийлүүлж болж байна шүү дээ. Тэгтэл энэ чинь бүүр 8, 9 центээр аваачаад нийлүүлчихсэн. 19

центээр. Салхиных нь 8, 9 цент. Энэ бүр 19 цент одоо энэ чинь хэд дахин юм. 7, 8 дахин, 6, 7 дахин илүү үнэтэй ийм л байна л даа, нөхөд ээ. Тэгээд ер нь Монголын өнөөдөр ажил ийм байна. Ийм байдалтай байхад бол Монгол Улс хөгжин гэж бол байхгүй ээ. Та нар. Үнэхээр харамсалтай байна шүү дээ.

Тэгээд энэ эрх зүйн орчин энэ яаж бүрдүүлэх юм байгаа юм. Яах ёстой юм. Ямар арга хэмжээ авах ёстой юм. Энэ хүн болгон эрчим хүч үйлдвэрлэгчийг дэмжих ёстой. Тэр 100 мянган панел гээд нэг 50 хувийн хөнгөлөлт үзүүлж байсан. Тийм юм бол байж л байсан. Одоо тэр таван толгойн станц Кампожууд барина л гээд байсан, Камбожууд дэлхийд станц барьж байсан туршилагыг мэдэхгүй л юм байна.

Тэгээд тэр маань юу болчихсон юм бэ? Энэ чинь эрчим хүчний нүүрсэнд тэнд шатаад байдаг. Бид нар энд зүгээр суугаад байдаг. Бараг 2000 оноос хойш л үндсэндээ ярилаа шүү дээ. 20 хэдэн жил яриад байхгүй. Ийм арчаагүй, ийм ажиллаж бол болохгүй. Зүгээр өөрөө би сайдыг бол шүүмжилж байгаа юм биш шүү, ажил аваад нэг 2 жил болж байгаа. Өөрийн чинь хувьд бол хийе, бүтээе гэж байгаа юм бол байгаа байх.

Ер нь манай эрчим хүчний салбар өнөөдрийн байж байгаа бодит дүр төрх энэ шүү дээ. Үе үеийн сайд нар, үе үеийн албан тушаалтнуудын та нарын хийсэн ажил бол байхгүй ээ. Үр дүн бол эцсийн үр дүн бол байхгүй. Ингэж ажил хийж болохгүй. Хариуцлагагүй хийсэн гэрээний төлөө 1 квт тутамд иргэн бараг 30-аад төгрөг төлж болохгүй шүү дээ, энэ чинь.

Тэгээд Бөөрөлжүүтийнхээ асуудлыг ярих ёстой. Би худлаа яриад байна уу, эсвэл. Тоо зөрөөтэй байна уу? Зөрөөтэй бол энэ зөрөөг нь та нар гаргаад шийдэх хэрэгтэй. Ер нь эрчим хүчний асуудлаа ер нь энэ төр Засгийн газар энэ Их Хурал дээр авчирч энэ тайлангаа тавих ёстой. Би дахиад асуулгаа тавина. Энэ дээр.

Л.Мөнхбаатар: Асуулга тавьсан гишүүн Баттөмөр үг хэллээ.

Улсын Их Хурлын гишүүн Баагаагийн Баттөмөрөөс Монгол Улсын Ерөнхий сайдад хандан тавьсан асуулгын хариуг чуулганы нэгдсэн хуралдаанаар сонслоо.

Сайд, ажлын хэсэгт баярлалаа.

15.05 цаг

Дараагийнхаа асуудалд орно. Гишүүд танхимдаа орёё.

Баттөмөр гишүүн санал, дүгнэлт уншина шүү. Гишүүд танхимдаа ороорой.

Гишүүд ээ, дараагийнхаа асуудалд орёё.

Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулъя.

Төслийн анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооны дарга Баагаагийн Баттөмөр танилцуулна. Таныг индэрт урьж байна.

Ажлын хэсгийг оруулаарай.

Б.Баттөмөр: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ, Улсын Их Хурлын гишүүн Учралаас 2019 оны 02 дугаар сарын 20-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурлын 2019 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэж, төслүүдийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлсэн.

Улсын Их Хурлын даргын 2022 оны 04 дүгээр сарын 08-ны 49 дүгээр захирамжаар Улсын Их Хурлын гишүүн Учралаас өргөн мэдүүлсэн Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн чуулганы хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах, Байнгын хорооны санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг Улсын Их Хурлын гишүүн Баттөмөрөөр ахлуулж, Улсын Их Хурлын гишүүн Мөнх-Оргил, Мөнхцэцэг, Пүрэвдорж, Энхболд нарын бүрэлдэхүүнтэй байгуулан ажиллууллаа.

Байнгын хороо 2024 оны 04 сарын 11-ний өдөр хурлаараа дээрх хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасны дагуу явуулж, дараах санал, дүгнэлтийг гарган та бүхэнд танилцуулж байна.

Байнгын хорооны хуралдаанаар төслүүдийн анхны хэлэлцүүлэг явуулах үед ажлын хэлтсээс бэлтгэсэн зарчмын зөрөөтэй 22 санал, хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн зарчмын зөрөөтэй 3 саналыг санал тус бүрээр хэлэлцэж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжлээ.

Тухайлбал хуулийн үйлчлэх хүрээг Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 8 дугаар бүлгийн 8.2-т заасан эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилалд хамрах чиглэлийн үйл ажиллагааг эрхэлдэг мэргэжлийн нэгдсэн холбоог энэ хуулиар зохицуулахаар өөрчилж, мөн энэ хуулиар зохицуулснаас бусад харилцааг ТББ-ын тухай хууль, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль болон холбогдох бусад хуульд зааснаар зохицуулах асуудлыг хуулийн төсөлд нэмж тусгах зарчмын зөрөөтэй саналыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Төсөлд мэргэжлийн нэгдсэн холбоог байгуулах, түүнд тавих

шаардлага, үйл ажиллагаа, зохион байгуулалт, эрх зүйн байдлыг тодорхойлох, төрийн байгууллагатай хамтран ажиллахтай холбогдсон харилцааг тодорхойлж, мэргэжлийн нэгдсэн холбоо нь тухайн салбарын мэргэжлийн холбоодын олонхоос бүрдэх, тухайн салбарын зах зээл дэх үйлдвэр, борлуулалт, худалдан авалтын 50-аас дээш хувийг эзэлдэг байх.

Хэрэв мэргэжлийн нэгдсэн холбоо нь тухайн салбарын олонхын төлөөлөл бүхий гишүүнчлэлтэй бол энэ хуульд нийцүүлэн Мэргэжлийн нэгдсэн холбооны чиг үүргийг хэрэгжүүлэх зарчмын зөрөөтэй саналын төсөлд нэмж тусгасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжлээ.

Мэргэжлийн нэгдсэн холбоо үүсгэн байгуулагдсан өдрөөс хойш 30 хоногийн дотор Улсын Дээд Шүүхэд бүртгүүлэх хүсэлт хүргүүлэх, баримт бичгийг нягтлан шалгах, уг холбоог бүртгүүлэх, бүртгэхээс татгалзах нөхцөл, шаардлагыг хуулийн төсөлд шинээр нэмж тусгах, зарчмын зөрөөтэй саналыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчил хянан шалгах, шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг хууль санаачлагчид нь буцаах санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжлээ.

Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаарх зарчмын зөрөөтэй саналын томъёоллыг Байнгын хорооны санал, дүгнэлтийн хамт та бүхэнд тараасан болно.

П.ОЮУНГЭРЭЛ

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрөөтэй саналуудыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүгдээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Л.Мөнхбаатар: Баагаагийн Баттөмөр гишүүнд баярлалаа.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан чуулганы нэгдсэн хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя.

Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Хаш-Эрдэнийн Сүрэнхорол, Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын зөвлөх Сүхээгийн Тэнгис, Ажил олгогчдын нэгдсэн холбооны гүйцэтгэх захирал Хуягийн Ганбаатар нар оролцож байна. Ганбаатар даргаасаа асууж болно.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух Их Хурлын гишүүд нэрсээ өгье.

Алга байна.

Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрөөтэй саналууд байгаа.

Гэхдээ Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд заасны дагуу санал хураалтыг 04 дүгээр сарын 18-ны өдрийн 10 цагаас санал хураалтыг явуулахаар шийдлээ.

Өнөөдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул чуулганы нэгдсэн хуралдааныг өндөрлүүлж байна.

**ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ**